



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1-3
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	4-33
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	34-133
<hr/>	
<i>1. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	38-41
<i>2. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	41-42
<i>3. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/</i>	42-49
<i>4. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	49-51
<i>5. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	51-56
<i>6. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	56-71
<i>7. Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий түр хорооны тайлан сонсох</i>	71-87
<i>8. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нарын 19 гишүүн 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх</i>	87-89

9. **“Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл** 89-91
10. **“Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл** 92-93
11. **“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/** 93-94
12. **Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 95-100
13. **“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/** 100-104
14. **Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 104-104
15. **“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл** 104-105
16. **Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 105-106
17. **Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/** 106-114
18. **Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/** 114-121
19. **Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/** 121-123

20. **“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/** 123-132
21. **“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан/** 132-133

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилоттой: Ё.Баатарбилэг, Ц.Мөнх-Оргил, Д.Цогтбаатар, Б.Энхбаяр;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, С.Амарсайхан, Л.Оюун-Эрдэнэ, Ч.Ундрам;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Баярсайхан, Ц.Мөнхцэцэг;

Тасалсан: Ц.Туваан, Н.Учрал;

Хоцорсон: Ш.Адъяаа-17 минут, А.Адъяасүрэн-06 минут, Ц.Анандбазар-21 минут, П.Анужин-36 минут, Х.Баделхан-24 минут, С.Батболд-2 цаг 15 минут, Д.Ганбат-50 минут, Н.Ганибал-06 минут, Т.Доржханд-1 цаг 29 минут, Л.Мөнхбаатар-31 минут, С.Одонтуяа-02 минут, М.Оюунчимэг-01 минут, Ш.Раднаасэд-1 цаг 59 минут, Д.Сарангэрэл-05 минут, Б.Саранчимэг-31 минут, Ц.Сэргэлэн-2 цаг 20 минут, Ч.Хүрэлбаатар-2 цаг 32 минут, Б.Энх-Амгалан-48 минут, Н.Энхболд-4 цаг 10 минут, Т.Энхтүвшин-15 минут, Ж.Эрдэнэбат-40 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Д.Өнөрболор, Г.Дамдинням, Б.Пүрэвдорж, П.Анужин нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар, Д.Өнөрболор, Г.Дамдинням, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг үг хэлж, горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг, Г.Дамдинням нарын гаргасан хэлэлцэх асуудлын дарааллын нэгдүгээрт байгаа Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлсний дараа чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлье гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 12

Бүгд: 47

74.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Горимын санал дэмжигдсэн тул Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг түр хойшлуулав. /10.30/

Нэг.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газраас 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерөн-Өлзий, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:

33

Татгалзсан: 17
Бүгд: 50
66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Монгол Улсын ерөнхий аудитор Д.Занданбат, Монгол Улсын ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Б.Заяабал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж танилцуулав.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж, Монгол Улсын ерөнхий аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 19
Бүгд: 47
59.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./11:13/

Уг асуудлыг 11 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “, цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөлд дор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1 Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 21
Бүгд: 47
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.08.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн

боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярмаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням таницуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3” гэснийг, 6.14 дэх хэсгийн” “тусгай” гэснийг тус тус төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашдаа тохиолдол бүр/, 6.5 дахь хэсгийн “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг” гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 6.15 дахь хэсгийг нэмэх:

“6.11.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.15.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 17
Бүгд: 47
63.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмшсэн мэдлэг, ур чадварыг” гэж өөрчилж, 8.1 дэх хэсгийн “суралцагч”

гэсний өмнө “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх:

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.12-т заасан байгууллага мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33

Татгалзсан: 17

Бүгд: 50

66.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “63.1, 63.2, 63.3 дахь заалтад” гэснийг “63 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, төслөөс 11.6, 11.7 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35

Татгалзсан: 15

Бүгд: 50

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1 Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоонд Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д зааснаас гадна хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүрдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32

Татгалзсан: 18

Бүгд: 50

64.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 22 дугаар зүйлийн гарчиг, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна”

гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан үндэсний зөвлөлд” гэж, төслийн 22.9.5 дахь заалтын “эдийн засгийн” гэснийг “эрэлтэй болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.8 дахь хэсгийг төслөөс хасаж, 22.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний олонхын саналаар томилно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 18
Бүгд: 51
64.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 23.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг, 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 16
Бүгд: 51
68.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын эрхийн хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8, 24.1.9 дэх заалт, 24.2 дахь хэсэг нэмж, төслөөс 24.1.4, 24.1.5 дахь заалтыг хасах:

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншлэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох ахиулах, сунгах;

24.1.9.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирлыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх.

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 35
Татгалзсан: 16
Бүгд: 51
68.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэснийг

“өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-т заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	33
Татгалзсан:	19
Бүгд:	52

63.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжээгүй санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсгийг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд Төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт, цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн 23.1.10-д заасан журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх.

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилно.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	30
Татгалзсан:	21

Бүгд: 51
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Одхүү, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Серикжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 43 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Г.Ганболд, Б.Пүрэвдорж, Ж.Батжаргал, Ж.Батсуурь, Б.Дэлгэрсайхан, Т.Энхтүвшин, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны саналаар, “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 18
Бүгд: 52
65.4 хувийн саналаар дэмжигдлээ.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Долоо.Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий түр хорооны тайлан сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн дарга Д.Эрдэнэсамбуу, Хяналт шалгалтын хэлтсийн референт Ж.Лхагвасүрэн нар байлцав.

Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий хянан шалгах түр хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын явцын тайланг Түр хорооны дарга Г.Ганболд танилцуулав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 13 цаг 07 минутаас хуралдааныг даргалав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Ш.Адьяа, С.Ганбаатар, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Хянан шалгах түр хорооны дарга Г.Ганболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т заасны дагуу Хилийн боомтуудаар ачаа, тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий хянан шалгах түр хороог татан буугдсанд тооцов.

Уг асуудлыг 13 цаг 49 минутад хэлэлцэж дуусав.

Найм. “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нарын 19 гишүүн 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан

үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Серикжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн түр хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргалыг хасаж, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд, М.Оюунчимэг нарыг нэмэх горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 18
Бүгд: 42
57.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хойшлуулж, “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулж хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг, “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулж хэлэлцүүлье гэсэн горимын санал гаргав.

Г.Занданшатар: Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 18

Бүгд: 43

58.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ес. “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, “Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23

Татгалзсан: 20

Бүгд: 43

53.5 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Арав. “Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын ерөнхий санхүүч П.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, “Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Арван нэг. “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын ерөнхий санхүүч П.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: Дэд хорооны саналаар, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Горимын санал дэмжигдсэн тул дээрх тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 14 цаг 51 минутад хэлэлцэж дуусав.

Арван хоёр.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Төсвийн байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн нар хариулж, тайлбар хийв.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Арван гурав.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Хуулийн хэлтсийн дарга Л.Мөнхжаргал, Эрчим хүчний зохицуулах хорооны Ажлын албаны дарга Б.Болор-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор, Ж.Батсуурь, Г.Ганболд нар үг хэлэв.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Төсвийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболорын гаргасан, Төсөлд ““1,5 мегаваттаас” гэснийг “15 мегаваттаас” дээш /хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар/” гэж өөрчлөх” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 15
Бүгд: 40
62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 26 минутад хэлэлцэж дуусав.

Арван дөрөв.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 28 минутад хэлэлцэж дуусав.

Арван тав. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Бундхорол, мөн газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын ерөнхий санхүүч П.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар, “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 14
Бүгд: 43
65.1 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 32 минутад хэлэлцэж дуусав.

Арван зургаа.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023.01.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Г.Нарантуяа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Арван долоо.Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Сангийн яамны Санхүү, бодлогын газрын

Өрийн удирдлагын хэлтсийн дарга Б.Одонтуяа, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Золжаргал Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ нар байлцав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Ж.Батжаргал, Д.Батлут, Ц.Идэрбат нарын тавьсан асуултад Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Д.Эрдэнэбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун нар хариулж, тайлбар хийв.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3-т заасны дагуу Баасан гарагийн 10.00 цагт эцэслэн батлах санал хураалтыг явуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.

Арван найм.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.9.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, баг, дүүрэг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 14
Бүгд: 45
68.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 9
Бүгд: 49
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий этгээд олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	36
Татгалзсан:	13
Бүгд:	49

76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн 22, 23 дугаар зүйлийг 22 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22 дугаар зүйл. Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавих шаардлага

22.1.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан болон доор дурдсан баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд б-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн гэрээ, танилцуулга;

22.1.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

22.1.3.стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлага хангасан хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

22.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

22.1.5.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх мөнгөн болон бусад хөрөнгийн жагсаалт, хэмжээ, баталгаа, эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.6.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;

22.1.7.ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг, сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын байгууллагад нийт багшийн 90-ээс доошгүй хувьд мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад нийт багшийн 80-аас доошгүй хувьд мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг;

22.1.8.цэрэг, цагдаа, төмөр замын мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын санал;

22.1.9.боловсролын сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, ял шийтгэл хүлээж байсан эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

22.1.10.татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

22.2.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан эрх хүлээн авагч Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, шийдвэр гарган эрх шилжүүлсэн байгууллагад тайлагнана.

22.4.Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийн 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

22.5.Мэргэжлийн, техникийн, дээд боловсролын шинэ мэргэжлийн, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх зөвшөөрлийг хүсэлт гаргахад Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичиг болон энэ хуулийн 22.1.3-22.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх үйл ажиллагааны танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эрхлэхээс 5-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд цахимаар ирүүлнэ.

22.6.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд хуульд заасан нөхцөл, шаардлага хангасныг нотолсон баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийн хамт үнэн зөв бүрдүүлэх эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

22.7.Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой

шинэ мэргэжлээр сургалт эрхлэх хүсэлтийг шийдвэрлэхэд энэ хуулийн 22.5-д заасан хугацаа хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 7
Бүгд: 49
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 24, 25 дугаар зүйлийг 23 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

23.1.Сургуулийн өмнөх, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас доошгүй байна. Ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрлийн хугацаа 12 жил байна.

23.2.Зөвшөөрлийн хугацааг зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3.Энэ хуулийн 22.1.10-г заасан татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 7
Бүгд: 49
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 26 дугаар зүйлийг 24 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

24.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

24.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;
24.1.2 зөвшөөрлийг хүчингүй болгосон;
24.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;
24.1.4.нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

24.1.5.хуульд заасан бусад.

24.2.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдох эд хөрөнгийн харилцааг Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

24.3.Татан буугдсан боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох баримт бичгийг орон нутгийн болон үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.

24.4.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах шийдвэрийг тухайн хичээлийн жилтэй уялдуулж суралцагчийн сурах эрхийг хөндөхгүйгээр эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43

Татгалзсан: 6

Бүгд: 49

87.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: 1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалтыг төслөөс хасаж, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5 дахь хэсгийг нэмэх:

“6.3.Боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 6.4-т заасан агуулгыг монгол хэлээр эзэмшүүлэхээс гадна тухайн боловсролын сургалтын байгууллагын төлөвлөгөөнд заасан гадаад хэлийг судлахад энэ хуулийн 6.1 дэх хэсэг хамаарахгүй.

6.5.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42

Татгалзсан: 7

Бүгд: 49

85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан дараах боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн” гэснийг “монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монголын түүхийн” гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Монгол Улсад боловсрол эзэмшүүлэх сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх бөгөөд эх хэлээрээ суралцах болон бусад гадаад хэл суралцах эрхийг үл хөндөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 37

Татгалзсан: 10

Бүгд: 47

78.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.4.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн дотуур байрны нийт зардал, төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хувьсах зардал, хоолны зардал, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогтмол зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 40
Татгалзсан: 9
Бүгд: 49
81.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.

Арван ес.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд болон “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын газрын дарга Х.Тамир, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга О.Хуягцогт, Боловсролын бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Цолмон, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, “Бүх нийтийн боловсролын төлөө” Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч Д.Тунгалаг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх

ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслүүдийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

1.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар:

Г.Занданшатар: “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 15
Бүгд: 48
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 15
Бүгд: 48
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 15
Бүгд: 48
68.8 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Г.Занданшатар: Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 11
Бүгд: 47
76.6 хувийн саналаар дэмжигдлээ.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 41 минутад хэлэлцэж дуусав.

Хорь. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.07.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Жамъянхүү, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.Пүрэвсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Итгэлт, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Одхүү, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн компанийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Серикжан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Б.Пүрэвдорж, Г.Ганболд нарын тавьсан асуултад Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт нар хариулж, тайлбар хийв.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар Эдийн засгийн

байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн тэмдэглэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж заасны гэж заасан Зорилт 1.2-т тусгагдсан үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 11
Бүгд: 44
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хилийн боомт дахь ачаа тээврийн урсгалыг сайжруулах, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын хооронд урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 10
Бүгд: 44
77.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн 1.3 дахь дэд заалтын “Ганцмод боомт” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн” гэснийг “зураг төслийн” гэж, “өмчлөгч” гэснийг “эээмшигч” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 10
Бүгд: 43
76.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшингийн гаргасан, Төслийн 1.4 дэх дэд заалтын “20 сая тонн хүртэлх” гэснийг “20 сая тонноос доошгүй” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 14
Бүгд: 43
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцагийн гаргасан, Төслийн 1.4 дэх дэд заалтын “Ганцмод” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “өртөө” гэснийг “боомт” гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 32
Татгалзсан: 12
Бүгд: 44
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Г.Занданшатар: Төслийн 1.1 дэх дэд заалтын “Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэснийг “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэж, 1.7 дахь дэд заалтын “Энэ заалтын 3, 4-т” гэснийг “Энэ тогтоолын 1 дэх заалтын 3, 4 дэх дэд заалтад” гэж, 2 дахь заалтын “хорооны хуралдаанд” гэснийг “хороонд” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 33
Татгалзсан: 11
Бүгд: 44
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын Их Хуралд 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг татан авах тухай 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр ирүүлсэн 1/112 тоот албан бичгийг уншиж, танилцуулав.

Хорин нэг. “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Эдийн засгийн байнгын хорооноос боловсруулсан/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Улсын Их хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 17 цаг 14 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, М.Оюунчимэг нарын урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Н.Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин, Б.Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь аймгийн Сурын холбоо, Шагайн холбооны төлөөлөл, Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын “Номундалай” сургуулийн 2003 оны төгсөгчид, Үндэсний аврах бригадын Ахмадын хорооны гишүүд, “Гоёмсог” компанийн ажилтан, албан хаагчид Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 21 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 03 минут үргэлжилж, 73 гишүүнээс 61 гишүүн хүрэлцэн ирж, 83.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 15 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН

БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН

2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 12 минут

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна. Сайд нь хаачсан байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Боловсролын ерөнхий хуультай хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.

Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашиунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай

холбоотой авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл Засгийн газраас нэн яаралтайгаар өргөн мэдүүлсэн.

“Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

“Төрийн аудитын байгууллагын цалинг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

10-д Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс тээвэрлэн нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалгах түр хорооны тайлан сонсох

11 Монгол Улс-Азийн хөгжлийн банк хоорондын аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Соёрхон батлах үргэлжилнэ. Эцсэн батлах учраас

12.Гаалийн тариф гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл эцсийн хэлэлцүүлэг. Энэ эцсийн хэлэлцүүлгийг урагшаа 2 дугаар асуудал болгоод тавьчих уу. Ийм хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэнэ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-д заасны дагуу 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их

Хурлын гишүүн Пүрэв-Очирын Анужин, Дамдинсүрэнгийн Өнөрболор, Бөхчулууны Пүрэвдорж, Гонгорын Дамдинням, Хишигээгийн Нямбаатар нараас тус тус албан бичгүүд ирүүлсэн байна. Ингээд Хишигээгийн Нямбаатар сайд үг хэлнэ. Пүрэв-Очирын Анужин гишүүн үг хэлнэ. Анужин гишүүн алга байна. Хаслаа.

Х.Нямбаатар: Их Хурлын гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг эрье.

Би нэг зүйл хэлэх гэсэн юм. Энэ нөгөө намрын чуулганаар 1 асуудал ингээд хэлэлцэх асуудалд багтсангүй. Цаг хугацааны хувьд нэлээн том ийм шахуу явж байгаа. Тэр нь юу вэ гэхээр 8 дугаар сарын 12-ны өдөр арбитрын маргааны хугацаа товлогдсон байгаа. Өнгөрсөн 2021 оны 12 дугаар сарын 29-ний өдөр гарсан шиг санаж байна. Улсын Их Хурлын 103 дугаар тогтоол гарсан. Их Хурлын дарга аа, тэгэхээр 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр Засгийн газраас ажлууд хийгдсэн. 103 дугаар тогтоолоор 6 заалт бүхий үүрэг даалгаврыг Засгийн газарт даалгасан. Тэгэхээр бид нар ямар ч байсан Засгийн газарт даалгасан 6 чиглэлээр хөрөнгө оруулагч талтай хэлэлцээрийн ширээний ард жил гаран суусан. Тэгэхээр энэ асуудлыг хаврын чуулган хааснаас хойш бид нар ээлжит бус зарлаж асуудлыг хэлэлцэж шийдэх үү. 8 дугаар сарын 12-ны өдөр Лондоны арбитр дээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явагдана. Ийм байгаа. Тэгээд бид нар хэлэлцэгч талтай хэлэлцээрийн ширээний ард суусан бүх саналуудаа Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан дээр гишүүдэд танилцуулах, 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг танилцуулах ийм шаардлага байгаа. Тэгээд Их Хурал хэрхэн шийдвэр гарахаас шалтгаалж цаашид нөгөө Арбитрт маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны асуудал яригдана. Нэг ийм юутай байгаа. Энийг би өнөөдөр зориуд үг авч, хэлж байгаа нь ийм байгаа. 5 заалт үндсэндээ бүрэн хэрэгжсэн гэж ажлын хэсгийн зүгээс үзэж байгаа. 6 заалт дээр хөрөнгө

оруулагч талтай нэлээн олон заалтууд дээр хөрөнгө оруулагч талаас буулт хийсэн саналууд ирсэн. Энэ санал болгоныг нэгдсэн байдлаар дэлгэрэнгүй танилцуулах нь зөв байх. Одоо чуулганы төгсгөлд энэ асуудлыг хэлэлцэхээр иргэний нийгмийн байгууллагууд бусад байгууллагуудаас хулгайгаар төгсгөлд нь асуудал хэлэлцлээ гэдэг ийм асуудал гарч болзошгүй гэдэг үүднээс ээлжит бусаар уг асуудлыг авч хэлэлцэх үү яах вэ. Энэ дээр Их Хурлын дарга нэг чиглэл өгөөч л гэсэн ийм зүйлийг хэлэх гэж үг авсан юм аа.

Г.Занданшатар: Ойлголоо. 1 дүгээрт өнөөдөр хэлэлцэх асуудалд ийм дараалал байхгүй. Өнөөдөр хэлэлцэх асуудалтай бол холбогдохгүй байна. 2 дугаарт ээлжит бус чуулган чуулах уу, үгүй юу гэдгийг Даргын дэргэдэх зөвлөлөөр шийднэ. 3 дугаарт тэр 103 дугаар тогтоолын төслийн хэрэгжилт гэх үү ямар нэгэн баримт бичгийг нь эхлээд заавал өргөн баригдсан байх хэрэгтэй байна л даа. Тайлан. Тэгээд тэрний дараа энэ асуудлыг ярина. Ингээд дараагийн Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор үг хэлнэ.

Д.Өнөрболор: Энэ өглөөний мэндийг хүргэе гишүүддээ.

Энэ 7 хоногийн хэлэлцэх асуудлын дараалалд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф болон гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэхээр байгаа. Миний хувьд нийслэлчүүдийн төлөө нэн ялангуяа Улаанбаатар хотод хорт утаа үйлдвэрлэхийн эсрэг удаа дараа байр сууриа илэрхийлээд байгаа. Гишүүдийн анхааралд би дахиад хэлье ээ. Нийслэл Улаанбаатар хотод татваргүйгээр ашиг олох, хорт утаа үйлдвэрлэдэг 1000 уурын зуухыг ажиллуулах ийм хууль батлагдах гэж байна. Бид саяхан “Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр” баталсан. Аж ахуйн

үйл ажиллагаагаараа холбоотой ашиг сонирхлын зөрчилтэй хуулийн төсөл санаачлахыг хязгаарлана гэж энэ танхимаас олон нийтэд бид нар зарласан байж байгаа юм. Тэгээд Занданшатар дарга аа, ер нь Улсын Их Хурлаас баталсан энэ бодлого шийдвэр 7 хоногийн настай байж болохгүй ээ. Энэ хуулийг батлахыг дэмжих нь ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт үйлдэл болно гэдгийг би гишүүдэд хариуцлагатайгаар анхааруулмаар байгаа юм. Ийм гэмт үйлдлийн суурь болсон хуулийг батлахгүй, иргэдийнхээ төлөө эрүүл саруул ухамсартай хандах гишүүд энэ танхимд олноороо байгаа гэдэгт би итгэж байгаа. Тэгээд гишүүдэд би нэг зүйлийг маш сайн ойлгуулах зүйтэй гэж бодож байна. Өчигдөр Занданшатар дарга аа, технологийн хувьд бас мэдээллийг дутуу авсан байж болох магадлалтай юм байна лээ. Өөрөөр хэлэх юм бол 1,5мвт гэдэг бол асуудал болоод байгаа юм. Яг ний нуугүй хэлэхэд. Харин 15, 20мвт байх юм бол энэ нэг их айхтар асуудал болохгүй байгаа юм. Учир нь 15, 20мвт-ын дэд станцууд гэх юм бол ард иргэд байгаль орчинд сөрөг нөлөө багатай, бүрэн шатлалтай агаар орчны бохирдлыг 99,99%-аар шүүх боломжтой ийм технологиор хийх боломжтой юм. Харин 1,5мвт гэдэг бол өнөөгийн нөхцөлд зөвхөн түүхий нүүрсээр ажилладаг технологийн хувьд ийм нүүрснээс өөр шийдэл байхгүй ийм л технологи байгаад байна. Тийм учраас би Улаанбаатар хотод энийг бол зөвшөөрч болохгүй ээ. Бид нар өнөөг хүртэл хэрэгжүүлж ирсэн энэ бодлогоосоо бүүр 180 градус ухрах нь ээ. Ийм л асуудал болоод байгаа юм. Тэгээд яах вэ, Чойжилсүрэн сайд болохоор үндсэндээ 300 мянган айлын гэр хороолол үндсэндээ 1000 зуух болно гэж тайлбарлаад байгаа юм. 1000 зуух болох нь үнэн. Гэхдээ энэ 1000 зуух чинь хуучин 300 мянган айл өрхөд бид нар сайжруулсан шахмал түлш түлүүлэхийг стандартаар шаардаж байсан бол одоо энэ 1000 зуух чинь түүхий нүүрс түлэх л ийм нөхцөл байдал руу орчхоод байгаа

учраас энийг эсэргүүцээд байгаа юм. Тийм учраас энэ 1000 орчим яндан түүхий нүүрс ингээд түлэх нь ээ. Тийм учраас ард иргэдийн өвчлөлийн суурь болсон амь насаа олноороо эрсдэх ийм гамшиг руу бид нар ахиад буцахгүй байхыг уриалж байна аа. Тийм учраас гишүүд энэ дээр тодорхой.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэр уриалгаа үг дээр хэлээ. Энэ хуулийн деталь ярихгүй. Энэ чинь Улаанбаатарт 300, 400 мянган яндан утаа үйлдвэрлээд байна шүү дээ. Тэрийг л багасгах зорилготой Засгийн газрын санаачилж байгаа ажлыг тэр Байнгын хороо дээр ярь. Хувийн болон хувьсгалын сонирхлоор янз бүрийн асуудал энэ дээр ярихыг хориглоно.

Дараагийн гишүүн Гонгорын Дамдинням гишүүн үг хэлнэ.

Г.Дамдинням: Дарга аа, хэлэлцэх асуудлын дараалал дээр нэг ийм хүсэлт байна аа. Боловсролын ерөнхий хуулийн төслийн талаар. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо Их Хурлын удирдлага болон хуулийн төслийн хүрээнд Байнгын хорооны даргын хүрээнд дахиж үргэлжлүүлж чиглэл авсан заалтууд дээрээ үргэлжлүүлж хуралдах шаардлагатай байгаа тул Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороог хуралдуулаад, тодорхой саналуудыг хураалгасны дараа боловсролын 2 хуулийнхаа урдуур ерөнхий хуулиа дахиж оруулж ирэх ийм хүсэлттэй байна. Энийг шийдээж өгөөч.

Г.Занданшатар: Одоо энэ асуудлыг Тамгын газар дэгийн хуулийн зохицуулалтыг нь харъя. Санал хурааж шийдэх байх гэж бодож байна. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Би онцгой татварын хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулсан. Энэ бол товчхоноор хэлэхэд хуурамч шатахууны

эсрэг хууль байсан. Энийг Үндсэн хуулийн цэц аж ахуйн үйл ажиллагаанд оролцож, би ийм жишээ ерөөсөө байхгүй. Тэгээд энд оролцож, миний хуулийг хүчингүй болгосон байгаа. Үүний улмаас дахин хуурамч шатахуун үйлдвэрлэх ийм нөхцөл бололцоо бий болж байна. Би өчигдөр Үйлдвэржилтийн байнгын хороо дээр орж үг хэлсэн. Тэр үгэн дээр Уул уурхайн яамны нэг газрын дарга надад хариулахдаа би тэр 3 байришлыг нэрлэсэн юм. Чойр, Баян, Рашаант гээд энэ 3 газарт үйлдвэр байвал та нар энд нийт тэр хуурамч шатахууны 85 хувь нь хольж байгаа. Тэгээд энд үйлдвэр байна уу зургийг нь надад аваад өгчхөөч л гэж хэлж байгаа юм. Үйлдвэр байхгүй гэж байгаа. Тэгээд юу байгаа юм гэхээр цех байгаа юм гэж байгаа юм. Үгүй ээ, тэр цехээр шатахуун үйлдвэрлэдэг байсан бол юугаа хайж та нар тэр Алтанжаргалан дээр 1 тэрбум 600 сая доллароор үйлдвэр бариад байгаа юм бэ. Цехээрээ л хий л дээ. Тэгээд би тэмцлээ зогсоочихъё гэж байгаа шүү дээ. Нэг үйлдвэрийн зураг л аваад ир тэгээд л болоо. Эх захгүй ингээд янз янзаар доромжилдог зүйл хэтэрч байна. Тэгээд сүүлдээ бүр нөгөө аж ахуйн асуудлыг шийдсэн Цэцдээ намайг өгсөн байна. Манай Батсуурийг бас өгсөн байна. Энэ Пүрэвдоржийг Их Хурлын гишүүнээс нь огцруулаад өгөөч ээ гэсэн юм шиг байгаа юм.

Монгол Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг бол ард нийтийн эрх ашиг, тэдний төлөө л зүтгэх ёстой байдаг. Тэдний эрүүл мэндийн төлөө л зүтгэж байгаа. Тэдний эд хөрөнгийг хамгаалахын төлөө л зүтгэж байгаа. Энэ дээрээ Цэц хууль бусаар шийдвэр гаргасан. Би тийм итгэл үнэмшилтэй байгаа. Дээрээс нь өнөөдөр Цэц дахиад Пүрэвдоржийг аваад ир. 1 өргөдөл өгүүлчих гэж хэлсэн юм шиг байна лээ. Би бол зуудаг нохой шиг хүн. Аль нь дийлэхээ үзнэ ээ.

Г.Занданшатар: Өнөөдрийн хэлэлцэх асуудалтай холбоогүй асуудал

байна. Гонгорын Дамдинням гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Мөнхцэцэг. Энэ дэгээрээ олонхын саналаар Байнгын хорооны даргын саналаар санал хураалт явуулна. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн.

Г.Мөнхцэцэг: Манай Боловсролын ерөнхий хууль ер нь бас 2 жил гаран хэлэлцэгдээд, тэгээд 2 удаа эцсийн хэлэлцүүлэг рүү орж ирж байгаа нь энэ байгаа юм аа. Түрүүчийн чуулганаар орж ирэхдээ ер нь зарчмын зөрүүтэй санал хураалтын явцад ямар нэгэн байдлаар дэг зөрчсөн эсэх дээр Улсын Их Хурлын Тамгын газраас хяналт шалгалт хийгээд, дүгнэлт гарга гэдэг ийм ажлын хэсэг гаргаад ажилласан юм байна лээ. Тэгээд ер нь яг протоколоо үзэж хараад, үг үсэглэлийг нь уншаад Байнгын хороо ямар нэгэн байдлаар дэг зөрчсөн зүйл байхгүй юм байна гэсэн ийм дүгнэлтийг гаргасан юм. Тэгээд бид нар бас энэ ерөнхий хууль дотор Англи хэл заах, заахгүй тухай гээд ингээд нийгэм рүү хүртэл нэлээн олон ийм асуудал болоод яваад байгаа учраас Байнгын хороо энийгээ эцэслээд, саналынхаа томъёолол юмнуудаа дахиж эргэж харж оруулж ирье гэдэг ийм горимын санал гаргаж байгаа юм. Ер нь бид ганц нэг хүний эрх ашигт нийцсэн ч байдаг юм уу, ганц нэг хэл заах заахгүйн тухайд ямар нэгэн зүйлчилсэн зүйлээр хуулийг ингэж ямар нэгэн байдлаар гацаах ийм байдал үүсгэж болохгүй юм. Их Хурлын гишүүд ер нь хэлж байгаа үг, гаргаж байгаа саналдаа хариуцлагатай хандах ёстой. Ийм учраас ер нь бид Монгол хүн байх тухай, Монгол хэл соёлоо дээдэлсэн тэр тусмаа энэ Боловсролын хууль дотор бол энэ зүйлүүдийг шигтгэж оруулж ирэх ёстой гэдэг үндсэн агуулга зарчмаа барьж ажиллах ёстой байгаа. Тийм ч учраас өнөөдөр Байнгын хороог дахин хуралдуулж Ерөнхий хуульд орж байгаа зарим нэг саналын томъёолол дээр дахиж эргэж харах, дахиад Байнгын хороогоороо хэлэлцээд оруулж ирэх ийм

горимын санал оруулж байгаа юм аа. Тэгээд энэ саналыг дэмжиж гишүүд маань санал өгөөрэй гэж хүсэж байгаа юм.

Г.Занданшатар: Эхлээд ямар ч байсан хэлэлцэх асуудалдаа орно.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор үргэлжлүүлэн санал хураах байсан. Ингээд Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан тодорхойлолтоор Их Хурлын үйл ажиллагаа Монгол Улсын Их Хурлын үндсэн зорилт ард түмний төлөөллийн дээд байгууллагын хувьд ард түмний засаглах эрхийг хангахад оришиж, Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ гэж заасан байна. Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалтад хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асууж байр сууриа илэрхийлэх, санал гаргах, санал хураалгах, горимын саналын талаар дэг зохицуулсан. Ингээд Байнгын хороон дарга, ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням нарын гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Байнгын хороо ер нь дэгийн зөрчилтэй байсан учраас энэ асуудлыг хойшлуулсан. Багцалж 3 саналыг Байнгын хороо дээрээ протокол үзэхэд 1, 1-ээр нь санал хураалгасныг багцлаад Их Хурлын чуулган дээр 1 санал болгож, 3, 4 саналыг 1 болгоод ингээд багцлаад оруулж ирж дэг зөрчсөн. Ийм учраас Байнгын хороо дахиж хуралдах нь зүйтэй гэж үзэж байгаа. Сая ажлын хэсгийн ахлагч,

Байнгын хорооны дарга нар ч гэсэн саналаа хэллээ. Ингээд Байнгын хорооны дарга болон Дамдинням гишүүний гаргасан горимын саналаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооог дахин хуралдуулж, дэгийн зөрчил болон саналын томъёоллуудыг гүйцээн боловсруулах ийм шаардлагатай байгаа учраас санал хураалт явуулъя. Санал хураалт явуулах юм уу, шууд буцаачих юм уу. Санал хураалт явуулчихъя. Гишүүд анхааралтай байгаарай. Санал хураалт. Бүгдээрээ дэмжээд боловсролын реформоо дэмжээд явуулчихъя. Чинзориг сайд аа, дараа нь танай төсвийн хууль байгаа шүү. 74,5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ. Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо хэдэн цагаас хуралдах юм Мөнхцэцэг дарга аа. За ингээд хуралдъя. Бусад хуулиуд одоо явуулна.

Одоо нэг эцэслэн батлах хуулиуд байна. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүнээр тасаллаа. Өнөөдөр олон асуудалтай шуурхай явна аа.

Д.Өнөрболор: Саяын миний үг аваад хэлээд байсан асуудлын нэг хэсэг нь орж ирж байгаа нь энэ. Тэгээд гишүүдийн анхааралд ба бас нэг зүйлийг хэлье ээ. Дахиад хэлэхэд нийслэл Улаанбаатар хотод татваргүйгээр ашиг олох зорилготой, хорт утаа ялгаруулах 1000 уурын зуухыг бий болгох ийм хуулийг батлах гэж байна. Тэгээд энэ бол үндсэндээ сая 1 дэх өдрийн Байнгын хорооны хурал дээр миний бие санал гаргаж эрх зүйн дүгнэлт гаргуулахаар санал гаргасан байж байгаа. Тэгээд энэ эрх зүйн дүгнэлт одоогоор гараагүй байна. Энэ дүгнэлт гарч,

танилцуулагдаагүй байгаа. Тэгэхэд энэ Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт оруулж байна. Тэгээд би сая технологийн асуудлыг нь тайлбарлаж хэлж өгсөн байгаа. Тэгээд энэ хүч түрж байгаа үйл явцаас харахад олон нийтийн анхаарал сарнисан яг баяр наадмын өмнө улайрч байгаа нь иргэдийн эсрэг ер нь увайгүй гэмт үйлдэл юм гишүүд ээ. Тэгээд хууль зүйн дүгнэлтээр Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцээгүй зөрчсөн гэсэн дүгнэлт гарвал энэ хууль Үндсэн хуулийн зөрчилтэй батлагдаад явах нь. Тийм учраас хэн ер нь урьдчилаад ийм дүгнэлт гарна гэдгийг мэдээд, Байнгын хороогоор Тэмүүлэн дарга энэ асуудлыг ингээд холбоотой 1 юмны 2 тал асуудлыг ингээд явуулаад байгаа юм бэ. Энэ ямар нэгэн нөлөөлөл байна уу. Уг нь бол ерөөсөө яг 1 юмны 2 тал л байгаад байгаа байхгүй юу. Энэ уурын зуухын тоног төхөөрөмжийг хил гаалиар хөнгөлөлттэй оруулж ирэх, тэгээд тэрийгээ угсраад хорт утаа үйлдвэрлэх, түүгээрээ дамжуулаад Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөгдөх, мөн ард иргэдийнхээ эрүүл аюулгүй орчинд амьдрах боломжийг хязгаарласан, Үндсэн хуулийг зөрчсөн ийм хууль батлагдах гэж байна. Тийм учраас гишүүд ээ, та бүгд маань энэ дээр бас анхааралтай байж ард иргэдийнхээ эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа энэ хуулийг батлахгүй байхыг дэмжиж өгөөч ээ гэж та бүгдээс хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Засгийн газраас өргөн барьсанд төсөл. Төсвийн байнгын хорооны дарга эхлээд хариулъя. Тэгээд дараа нь Чойжилсүрэн сайд хариулъя. Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл дээр гол нь ерөөсөө эрчим хүчний салбарын аюулгүй байдалтай холбоотой асуудал, тэр дундаа системийн болоод найдвартай, тогтвортой үйл

ажиллагааг хангах чиглэлээр л энэ хэрэв системд байгаа цахилгаан станц, дулааны эрчим хүч үйлдвэрлэж байгаа станцуудын тоног төхөөрөмжүүдийг Монголд тэр дундаа үйлдвэрлэдэггүй тоног төхөөрөмжүүдийг импортоор оруулж ирэх юм бол гаалийн албан татвараас чөлөөлөхөөр тусгаж оруулж ирж байгаа. Тэгэхээр энэ бол нэг талдаа манай эрчим хүчний салбарт ойрын олон жилийн хугацаанд хийгдээгүй байгаа техник технологийн шинэчлэлийн асуудлууд, дээр нь магадгүй инновац илүү шинэ технологийг хэрэглэх боломж бололцоог бүрдүүлэх л хангамж байгаад байгаа юм. Тэгэхээр үндсэндээ та бүхэн бүгдээрээ л мэдэж байгаа. Эрчим хүчний салбар дээр сүүлийн олон жилийн хугацаанд бид нар ямар ч бай нэг талдаа дотоодын аж ахуйн нэгж байгууллагууд, тэр дундаа эрчим хүчний салбарын аюулгүй байдлыг хангаж байгаа аж ахуйн нэгжүүдэд энэ хэмжээний дэмжлэг үзүүлж байсан зүйл байхгүй. Техник технологиуд бүгд хуучралтай. Аймаг, орон нутаг, хот, хөдөө ялгаа байхгүй бид нар энэ шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлагатай байгаа. Энэ үндсэн дээр Засгийн газрын зүгээс хуулийг нэн яаралтай горимын хүрээнд өргөн мэдүүлж орж ирсэн. Төсвийн байнгын хороо Улсын Их Хурлынхаа дэгийн тухай хууль, чуулганыхаа нэгийг баримталж энэ хуулийнхаа хүрээнд хэлэлцүүлгийг хийсэн байгаа. Харин эрх зүйн дүгнэлт гаргуулах асуудал зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуультай холбоотойгоор явсан. Улсын Их Хурлын Тамгын газраас эрх зүйн дүгнэлт нь гарсан байгаа. Үүн дээр ямар нэг зөрчил байхгүй ээ гэдэг дүгнэлтийг гаргаж өгсөн. Тэгэхээр энэ хүрээндээ Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороо бол энэ хүрээндээ хэлэлцээд явж байгаа гэдгийг хэлэх байна.

Г.Занданшатар: Эрх зүйн дүгнэлт нь гарчихсан юм байна шүү дээ. Гараагүй гээд байсан. Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Гишүүдийнхээ өнөөдрийн амрыг эрье.

Өнөрболор гишүүн жоохон бухимдалтай байгаа байх. Өөр үзэл бодолтой байгаа хүнийг хүлээн зөвшөөрч аль болох таны бодлыг нийцүүлэхийг хичээлгүй яах вэ. Гэхдээ бид нар яг бодит байдалтайгаа эвлэрэхгүй бол болохгүй нь ээ. Та сүүлийн үед жоохон хэтрүүлэгтэй яриад эхэллээ. Тэр Улаанбаатар хотод 1000 уурын зуух баригдахгүй ээ. ТЭЦ-3, ТЭЦ-2, ТЭЦ-4 дээрээ бид нар нүүрсээр түли хэрэглэж байгаа. Энийг үргэлжлүүлээд хэрэглэхээс ойрын жилүүдэд ондоо арга байхгүй гэдгийг би танд хэлсэн. Харин 1,5мвт гээд таны шүүмжлээд байгаа энэ хэмжээ бол 36 мянга орчим метр квадратыг халаах хэмжээ байгаа юм. 300 орчим айл гэсэн үг. 300 айл тус тусдаа сайжруулсан шахмал түли түлээд ч гэсэн хорт утаа ялгаруулж байгаа нь үнэн. Энийг нэг дулааны станц руу хамгийн бага хэмжээ болгоод станц дээр нь бүрэн шаталттай зуух тавиад тэгээд шүүлтүүрдээд тавьчих юм бол агаар мандалд ялгаруулж байгаа хорт хийний хэмжээ 10 орчим дахин бууцхаад байгаа юм. Тэгэхээр ямар ч байсан бүрэн утааг арилгаж чадахгүй гэхэд байгаа санхүүгийнхээ бололцооны хэмжээнд утааг бууруулах арга хэмжээнүүдийг эцэс төгсгөлгүй аваад явъя гэсэн ийм л бодлогоор оруулж ирсэн. Тэгэхээр гишүүд маань энэ асуудлыг Засгаас оруулж ирсэн энэ шийдвэрийг дэмжиж өгөөч ээ л гэж хүсье.

Г.Занданшатар: Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн тодруулж асууя. 1 минут.

Д.Өнөрболор: Ер нь бол энэ гол асуудал нь ерөөсөө яг энэ хуулиар дамжуулаад шинэ сэргэлтийн бодлогын том зорилго, бодлоготой зэрэгцээд Улаанбаатар хотод түүхий нүүрсээр утаа үйлдвэрлэх асуудал давхар орж ирээд байгаад л асуудал байгаад байгаа байхгүй юу. Тэгээд би сая гишүүдэд

тайлбарласан. 1,5 мегаваттын хүчин чадалтай станцууд бол 1000 зуухыг үйлдвэрлэж байгаа. Энэ 1000 хорт утаа үйлдвэрлэж байгаа энэ зуух маань өөрөө өнөөдөр ямар ч тийм бүрэн шаталттай байх боломжгүй, зөвхөн түүхий нүүрс ашиглах л ийм боломжтой байж байгаа. Өнөөдөр төр засгаас түүхий нүүрс ашиглахыг хорьчихсон байж байгаа. Энэ хорьсон зүйлийг ард иргэдэд болохоор 200-300 мянган айл өрхөд та нар зөвхөн сайжруулсан түлш түл гээд ингээд шаардаад байж байгаа. Үүнийхээ эсрэг яг энэ 1000 зуух чинь буцаад түүхий нүүрс түлэх 1,5мвт-ын уурын зуухнууд Улаанбаатар даяар бий болох ийм нөхцөл байдал үүсэж байгаа. Тийм учраас энэ хуулийг та бүгд ард иргэдийнхээ эрүүл аюулгүй.../минут дуусав/

Г.Занданишатар: Чойжилсүрэн сайд хариулъя. 1000 уурын зуух гэж яриад байгаа юм. Ийм тоо энэ хуульд чинь байхгүй байх юм.

Б.Чойжилсүрэн: Өнөрболор гишүүн ээ, нэг зүйлийг амьдралтайгаа нийцүүлэх гэж оролдоё. Жишээлбэл Гачуурт руу ТЭЦ-3-аас дулааны шугам татаад утгагүй байна. Замдаа хөрөөд тэр дулаан чинь очихгүй байгаа юм. Тэгэхээр Улаанбаатар хотын тийм тодорхой хэсгүүд бий. Тэр тархмалаар нь дулааны станц бариад шийдэх. Газ гэдэг сэдэв байна. 2030 оноос нааш бүрэн орж ирэхгүй нь ээ. Цахилгаанаар халаа гэсэн тохиолдолд 3 гегаватт цахилгаан эрчим хүч хэрэгтэй. Зүйрлээд хэлэх юм бол ТЭЦ-4 шиг 4 цахилгаан станц халаана. Энэ ажлыг мөнгө нь байгаад хийхэд доор хаяж 5-6 жил шаардагдана. Энэ хооронд жоохон уян хатан нь эрх өвөл ч гэсэн ялгаагүй бид нар дахиад л утааны асуудал яригдана. Боломжоороо энэ утаагаа багасгах тухай юу оролдож.../минут дуусав/

Г.Занданишатар: Санал хураалт явуулъя. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Дэгтэй. Энэ эцсийн хэлэлцүүлэг явж байна.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлээ.

10.39 цаг.

Дараагийн асуулт оръё. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор танилцуулна. Индэрт урьж байна.

Д.Өнөрболор: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн хуулийн дагаж мөрдөх хугацааг 2023 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс гэж өөрчлөх санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 1 санал байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1.Төслийн 2 дугаар зүйлийн “2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн. Монгол Ардын намын бүлгийн дарга. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энийг дэмжинэ. Тэгэхгүй бол 7 сарын 1 өнгөрчхөөд байна шүү дээ. Хууль хэрэгжих хугацааг нь өөрчилж байна. 66 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцсийн

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүллээ.

10.42 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн 2 дахь хэлэлцүүлгийг явуулна.

Төсвийн зарлагын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Пүрэвдорж гишүүн байхгүй бол Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос өөр хүн байна уу. Хуралдаа сууж баймаар байх юм. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос чинь Жигжидийн Батжаргал гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дүгнэлтийг танилцуулна. Индэрт урьж байна. Төсвийн орлого 1,1 их наядаар нэмэгдэж, төсвийн зарлага 731 тэрбумаар хэмнэгдэж, зарцуулалтгүй байж, төсвийн алдагдал 1,8 их наяд төгрөгөөр буурсан.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, 2 дахь хэлэлцүүлгийг бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын

хяналтын дэд хороо болон Улсын Их Хурлын Байнгын хороодод шилжүүлсэн.

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа төсвийн гүйцэтгэл болон Байнгын хороодын ирүүлсэн санал, дүгнэлтийг хэлэлцэн нэгтгэн гаргасан дүгнэлтээ та бүхэнд танилцуулж байна.

Аудитын газраас аудит хийж Улсын Их Хуралд нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг ирүүлсэн. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтээр төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого болон тусламжийн дүнг 17 их наяд 126 тэрбум төгрөг, нийт зарлагыг 18 их наяд 159,6 тэрбум төгрөгөөр баталгаажуулж, 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Тогтвортой байдлын тухай хуулийн 6.1 дэх хэсэгт заасан тусгай шаардлагыг хангасан гэж үзсэн байна.

Тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал нь 1 их наяд 32 тэрбум төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувьтай тэнцэж байна. Түүнчлэн Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитын тайлан мөн Монгол банкны санхүүгийн тайланг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгүүлэн төрийн нийтийн хөрөнгө дүн мэдээг илэрхийлэх боломжийг бүрдүүлэх, Монгол Улсын Их Хурлаас тухайн жилийн төсвийн хуулиар батлаагүй хөрөнгө оруулалтын болон нийгмийн шинж чанартай төсөл арга хэмжээг төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгөөр санхүүжүүлж байгаа асуудал хэрээс хэтэрсэн байна гэдгийг анхааруулж байна.

Байнгын хороод бүх төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэж санал, дүгнэлтээ Зарлагын дэд хороонд хүргүүлсэн. Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанаар төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Төрийн аудитын

байгууллагаас хийсэн хяналт шалгалтын хүрээнд хариуцлагын ямар хэмжээ авсан, хэдэн хүнд хариуцлага тооцсон талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж 2022 оны дүгнэлтээр хэдэн төгрөгийн зөрчил илрүүлсэн, нийт хэдэн шийдвэр гаргадаг албан тушаалтан байгаа талаар тус тус асуулт асууж, хариулт авсан.

2022 оны төсвийн гүйцэтгэлээр нийтдээ 5 их наяд төгрөгийн санхүүгийн зөрчил гарсан байгаа. Тэнд нийт 6618 төсвийн гүйцэтгэл дээр гарын үсэг зурдаг албан тушаалтан байна. Нэг албан тушаалтанд ойролцоогоор 65 тэрбум төгрөгийн 808 сая төгрөгийн зөрчил нэг албан тушаалтан дээр ноогдож байна. 800 сая. Тийм учраас төсвийн гүйцэтгэлийг ялангуяа Засгийн газар энэ төсвийг зарцуулахдаа хариуцлагатай байх ийм шаардлага гарч ирж байна.

Тийм учраас Төсвийн зарлагын хяналтын дэд хороогоор Монгол Улсын ерөнхий сайд Оюун-Эрдэнэ-д аудитын байгууллагаас өгсөн шаардлагын хүрээнд албан тушаалтнуудад хариуцлага хүлээх шаардлага хүргүүлдэг боловч албан тушаалтнуудыг хаацайлдаг ийм байдал маш их байна. Аудитын байгууллага хуулиар бол шаардлага л хүргүүлнэ. Хариуцлага тооцох албан тушаалтан нь тухайн Ерөнхийлөн захирагч нар байдаг. Гэтэл энэ нь нэг нэгэндээ барьцаалагдсан энэ хүмүүс хариуцлага тооцох боломж ерөөсөө байхгүй байна гэдэг ийм дүгнэлт гаргасан.

Тийм учраас Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос нийтдээ 23 аж ахуйн нэгжид 3 их наяд төгрөгийн санхүүгийн зөрчил гаргасан байгаатай холбогдуулан тэр хүмүүст, албан тушаалтнуудад заавал хариуцлагыг 9 сарын 1-ний дотор тооцох ийм албан бичгийг хүргүүлж байгаа.

Мөн түүнчлэн Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлтэй

холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг Төсвийн байнгын хорооны дарга Тэмүүлэнгийн санаачилгаар дэд хорооны гишүүд хэлэлцэж, Их хурлаар хэлэлцүүлэхээр оруулж байгаа. Ялангуяа энд бол төсвийг батлаад өгдөг, хэтрүүлж хэрэглэдэг, зардал гаргадаг энэ явдал хэрээс хэтэрсэн байна. Тийм учраас энэ дээр тодорхой хэмжээний хариуцлага тооцох, ялангуяа Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, түүнд дурдагдсан нийтийн сонсгол хийх ийм шаардлага зайлиггүй гарч байна.

Тийм учраас энэ тогтоолын төслийг Улсын Их Хурлын гишүүд та бүхэн баталж өгнө гэдэгт найдаж байна.

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Түүнчлэн Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос Төрийн аудитын байгууллагаас гаргасан дүгнэлтэд дурдсан зөрчлүүдэд хариуцлага тооцох албан арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл өгөх албан тоот хүргүүлэхээр тогтсон.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Наянтайн Ганибал

нарын урилгаар Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ерөнхий боловсролын сургуулийн 1986 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт төгсөгчид та бүхнийг Сүхбаатарчууд даа ажлын өндөр амжилт, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Ажлын хэсгийг танилцуулчихъя.

Монгол Улсын Сангийн сайд Болдын Жавхлан, Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Цэвэгсүрэнгийн Наранчимэг, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Дэлгэрийн Энхболд, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жигжидийн Ганбат, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Батжаргалын Заяабал, Чойжилсүрэнгийн Тавинжил Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга, Нарангийн Мөнхсүх Сангийн яамны санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга, Жамъяншаравын Дэлгэржаргал Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга, Булганхүүгийн Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга, Байгальмаагийн Одонтуяа Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтсийн дарга.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: 2022 он бол өөрөө нэг арай хийж ажил хийх боломж олдсон ийм он. Тийм ч учраас бид төсөв хөрөнгө хэлэлцэхдээ 2022 он, 2020, 2021 гэсэн амаргүй ковидын дараа нөхцөл байдал

овоо нааштай эргээж байна. Өчигдөр Сангийн сайдын хэлж байгаагаар 2022 оны оны сүүлчээс гэхэд ажилттай байсан эдийн засаг 4,8 хувь болж өссөн. Валютын нөөц, нүүрс тойрсон авлига, хулгайг зогсоосноос валютын нөөц нэмэгдсэн гээд эерэг үр дагаврууд гарсан. Бид 2022 оны төсвийг нэлээд өөдрөг үзэл бодолтой баталж өгсөн. Тэгээд сая зарлагын дэд хорооны дарга ч бас хэлж байна. Би зарим нэг зүйлтэй санал нэг байна. Аливаа ажилд гүйцэтгэл гэж маш чухал. Үр дүн, гүйцэтгэл энэ чинь өөрөө бүгд төсвийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө явж байгаа. Тэгээд 2022 оны гүйцэтгэлээс харахад зогссон, удааширалтай, бараг хийгдээгүй ажлууд нэлээд байна. Би яагаад энэ гэр хорооллын дахин төлөвлөлт, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг яриад байгаа юм бэ гэхээр одоо та нар хар үер болоогүй 2, 3-хан өдрийн борооноор л гэхэд тэр чигээрээ яаж ус урсаж, хөрсний бохирдол ямар түвшинд хүрч байна. Гэр хорооллын тэр бохирдсон хөрс тэр чигээрээ хотын төв рүү орж ирж байна. Хотын төвд нөгөө ус хамгаалах тэр технологио хийгээгүйгээс болоод тэр чигээрээ усанд автаж байна. Авлига хорооллыг тойрсон ус алдалтыг та нар хараадах даа. Тэгээд энэ бүхэн юу юм. Нөгөө гүйцэтгэл муутай, энд тавих хяналт хариуцлагагүй, хариуцлага тооцохгүй байгаа зүйлүүдээс шалтгаалж байна шүү дээ. Тэгээд би өмнөх хурал дээр ч хэлж байсан. Аудитын дүгнэлтэд сөрөг буюу хязгаарлагдмал гэж гарсан. Ялангуяа Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр 3 гэрээт ажлын гэрээний хугацаа нь дууссан. Гүйцэтгэл удааширалтай бараг хийгдээгүй, гэрээ нь сунгаагүй. Аудитаар өгсөн зөвлөмжийг нь хэрэгжүүлээгүй 2022 оны нийслэлийн Засаг даргын захирамж нь биелээгүй, нийслэлийн өмчид шилжүүлсэн 18 орчим тэрбум төгрөг нь тусгагдаагүй, яаж зарцуулсан нь тодорхойгүй гээд энд дурдчихсан байна л даа. Тэгээд бид ямар хариуцлага тооцох вэ л гэж би асуугаад

байгаа юм. Сая хэлж байна. Нээрээ нэг хугацаатай, хариуцлага тооцох механизмтай баймаар байна. Энэ чинь тэнд нэг ажил хийж байгаа хүн байгаа. Хариуцаж байгаа дарга байгаа. Хэнээс шалтгаалсан бэ гэдэгт нь хариуцлага тооцохгүй бол дахиад 2023 он, 2024 онд яг ийм байна. Тэгээд төсөв улсын мөнгө ингээд л хэдэн тэрбумаараа иднэ. Харин тэр нөгөө гэр хорооллыг дэд бүтэцжүүлэх ажил нь зогсчихсон. Улаанбаатар хотын утаа униарыг хар л даа. Хөрсний бохирдлыг. Энэ чинь өөрөө өчигдөр бид нар Дархлаажуулалтын хууль, Нийгмийн эрүүл мэндийн хуулийг ярьж байхад хөрсний бохирдлоос үүдэлтэй А гепатит вирус л гэхэд хэд дахин өсчихсөн, дэлхийн дунджаас дээгүүр даваад 2 дахин болчихлоо гээд бид нар яриад сууж байна шүү дээ. Энэ нь юу юм гэхээр хариуцлага тооцохгүй байгаагаар, гүйцэтгэлд нь хяналт тавиад, үр дүнг нь тооцохгүй байгаагаар л холбоотой гэж үзэж байна. Тийм учраас аудитын газрынхан хариулах байх л даа. Өөр хэн хариулах бол. Яаж бид нар энд хариуцлага тооцох вэ. Одоо тэр Төсвийн байнгын хорооноос оруулж ирж байгаа тэр хуулийг л баталчихвал бүх юм болчих юм шиг яриад байх юм. Тэр чинь шат шатдаа яг хариуцлага тооцоод, яг энэ дээр жишээлбэл хэн яг хариуцлага хүлээх бол. Энэ дээр манай аудитын газрынхан надад хариулт өгөөч. Тэгээд бүгдээрээ энэ дээр хугацаатай үүрэг даалгавар өгье. Гүйцэтгэлд нь хяналт тавьж, энийг биелүүлье. Ийм асуулт би асуумаар байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дарга Бөхчулууны Пүрэвдорж хариулна.

Б.Пүрэвдорж: Оюунчимэг гишүүний шүүмжилж ярьж байгаа зөв өө. Үнэхээр хүйтэн сэтгэлтэй хүмүүс ялангуяа төсвийн гүйцэтгэл дээр маш хариуцлагагүй, харгис ийм байдлаар хандаж байгаа. Ер нь бол төсвийн хөрөнгө оруулалтаар маш их ажлуудыг хуваарилж тавьдаг. Их Хурлын гишүүд

бас тойрог тойрогтоо тодорхой хэмжээний тэр хүмүүсийн эрх ашигт хангасан хөрөнгө оруулалтуудыг тавьж өгдөг. Жишээ нь үерийн далантай холбоотой маш их олон хөрөнгө оруулалтуудыг Улаанбаатар хотын болон улсын төсвөөр хангалттай хийсэн. Ялангуяа Чингэлтэй дүүрэг энэ тэр дээр нэлээн их хийгдсэн байгаа. Гэтэл энэ дээр тендер шалгаруулалтаар нь өөрийнхөө нэг цүнхтэй компанийг оруулдаг, 10 хувийг нь авдаг ийм явдал хэрээс хэтэрсэн учраас тэрэндээ буцаагаад хариуцлага тооцох механизм байхгүй. Тэр өөрсдийнхөө хамаарал бүхий нөхдөд өгчихсөн хүмүүс доод талын албан тушаалтнуудаараа тэр тендерийн ажлыг нь хүлээлгэж авдаг ийм зүйлүүдээс болоод өнөөдөр маш тийм чанаргүй бүтээн байгуулалтын ажил хийгдэж байгаа нь төсвийн гүйцэтгэлд муугаар нөлөөлж байна. Тийм учраас төсвийн гүйцэтгэл дээр ялангуяа Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу сонсгол хийх, албан тушаалтанд хариуцлага тооцох тэр сонсголыг хийж болж байна. Нийтийн сонсгол хийж болж байна. Олон төрлийн сонсгол хийх замаар бид нар төсвийн гүйцэтгэлд хүйтэн хандсан тэр хүмүүст хариуцлага тооцох тэр ажлуудыг бид нар энэ парламентын хүрээнд хийж явахгүй бол Засгийн газар нь толгой дээрээ гарчихсан, гүйцэтгэх засаглал нь дураараа байдаг ийм явдал хэрээс хэтрээд байгаа шүү гэдгийг хэлэх нь зүйтэй байгаа. Тэгтэл жишээ нь энэ жил ерөөсөө 2023 оны төсөв дээр уртаашаа гуравхан хөрөнгө оруулалт тавигдсан байхгүй юу даа. Тэрний 2 нь Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах зорилго зорилгоор автобусанд 300 тэрбум, түгжрэлд 150 тэрбум төгрөгийн 2 хөрөнгө оруулалт л тавьсан гэж бодож байгаа. Гэтэл Ховд аймагт нэг хөрөнгө оруулалт дахиад л тавигдсан. Гэтэл тэрийг өнөөдрийг хүртэл тендерийг нь шалгаруулахгүй сууж байна шүү дээ. Ганцхан тендерийг. Тэгэхээр энд юу байна гэхээр ерөөсөө энэ тендерийн ард хэдэн албан тушаалтан

суучихаад л авлигалаа хараад сууж байдаг. Таалагдахгүй болохоор буцаадаг ийм зүйл хэрээс хэтэрсэн байна л гэж би хараад байгаа юм. Тийм учраас ялангуяа төсвийн гүйцэтгэл дээр хариуцлагатай байх, Их Хурал өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавих. Төсвийн хуулийг бид нар баталсан. Тийм учраас баталсныхаа хуулийнхаа хэрэгжилтэд хариуцлага тооцох тэр механизмыг ажиллуулна гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: 83 Аудитын ерөнхий газрын орлогч даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг.

Ц.Наранчимэг: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Төрийн аудитын байгууллагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 25 байгууллагад сөрөг, 13 байгууллагад аудит хийхээс татгалзсан дүгнэлт өгсөн. Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлд зааснаар аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, сөрөг дүгнэлт авсан бол хариуцлага тооцох албан шаардлагыг томилдог эрх бүхий албан тушаалтанд хүргүүлдэг, татгалзсан дүгнэлт авсан байгууллагын удирдлагыг ажлаас чөлөөлөх албан шаардлагыг хүргүүлдэг ийм хуулийн зохицуулалттай. Тэгэхээр манайх албан шаардлагуудаа хүргүүлсэн. Таны яриад байгаа энэ асуудал дээр бол хариуцсан төсвийн ерөнхийлөн захирагчид нь дээд шатын томилдог эрх бүхий албан тушаалд нь хариуцлага тооцох зохицуулалттай. Хариуцлагагүй хандаж байна гэж ингэж ойлгож байна.

Гэр хорооллын хөрөнгө оруулалттай холбоотойг 85 хариулна.

Г.Занданшатар: 85.

Д.Энхболд: Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал Энхболд байна. Оюунчимэг гишүүний асуултад үргэлжлүүлэн хариулъя.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын аудитаар захиалагчийн болон зохиогчийн хяналт хангалтгүй байна гэдэг ерөнхий дүгнэлт хийсэн. Энэ хүмүүст холбогдох арга хэмжээг авхуулахаар дээд шатын байгууллагад нь хандахаас гадна таны ярьж байгаа асуудалтай холбоотой дэд бүтцийн асуудал дээр Ерөнхий сайдад 3 албан шаардлага хүргүүлсэн. Энэ 3 албан шаардлагын 1 нь бол дэд бүтэцтэй холбоотой асуудал дээр анхаарч шийдвэрлээч ээ гэдэг ийм албан шаардлагыг Ерөнхий сайдад хүргүүлсэн байгаа. Тэгээд аудитын байгууллагын акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байгаа учраас Зарлагын дэд хороон дээр бас энэ дээр Ерөнхий сайдад чиглэл өгүүлэх ийм шийдвэрийг өнөөдөр Зарлагын дэд хороон дээр давхар гаргуулж албан бичиг хүргүүлэхээр шийдвэрлэсэн байгаа.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн 1 минут тодруулж асууя.

М.Оюунчимэг: Тэгэхээр сая Аудитын газрынхан маань тодорхой хэлж байна л даа. Хариуцлага алдсан хүмүүстэй хариуцлага тооцох албан бичиг тодорхой хариуцаж байгаа хүмүүст нь явуулсан гэж байна. Тэгэхээр Их Хурлын дарга аа, өнөөдөр Улсын Их Хурлаас мэдээж гүйцэтгэлтэй холбоотой тогтоол гарах байх. Энэ хариуцлагатай улс орны хэмжээний том ажлыг удаашруулсан, хариуцлага алдсан тэр зориулалтын мөнгийг зориулалтын юманд нь зарцуулаагүй, гэр хорооллыг хөгжүүлэх ажлыг зогсоож байгаа энэ хүмүүст хариуцлага тооцох, ер нь энэ гүйцэтгэл дээр алдаатай байгаа хүмүүст хариуцлага тооцох заалтыг тогтоолын төсөлд оруулах саналтай байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогогийн Энхтүвшин, Борхүүгийн Дэлгэрсайхан нарын урилгаар Дорноговь

аймгийн Сурын холбоо, Шагайн холбооны төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Шагайчид, харваачдадаа баяр наадам удахгүй болох гэж байна. Тэгээд цэц мэргэн оноо ариун байхын өлзийтэй ерөөлийн өргөн дэвшүүлээд сайн сайхныг хүсэн ерөөе. Сайхан наадаарай.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууна.

Б.Баттөмөр: 2022 оны төсвийн гүйцэтгэл, төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал буурч байгаа боловч 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарсан. Төсвийн орлого 1,7 их наяд төгрөгөөр давсан. Энэ давалт бол нүүрс дээр хийсэн менежмент боломжоос дутуу төлөвлөсөн гэж ингэж тооцож байгаа. 2022 оны төсвийн орлогыг тооцохдоо 2021 оны төсвийн гүйцэтгэлээс 700 тэрбум төгрөгөөр дутуу төлөвлөсөн. Эдийн засгийн өсөлт 4,8 хувь гэж гарсан. Тэгэхдээ бүтээмжийн өсөлт энд байхгүй. Нэмэгдсэн өртөгт суурилсан өсөлт байхгүй. Гадаад худалдааны эргэлт 21,5 тэрбум доллар хүрсэн боловч худалдааны тэнцэл нь 3,8 тэрбум долларын алдагдалтай. Төлбөрийн тэнцэл 779 сая долларын алдагдалтай, уул уурхайгаас бусад бүх салбар үндсэндээ 1,5 тэрбум долларын өр үйлдвэрлэж байгаа. Инфляц 13,5 хувь, урсгал данс 2,7 их наяд төгрөгийн алдагдалтай, санхүүгийн данс 1,5 их наяд төгрөгийн алдагдалтай, нөөц хөрөнгө 1,2 их наяд төгрөгийн алдагдалтай байгаа. Гадаад өр 33,5 тэрбум доллар болж өр багассангүй. Гадаадын шууд хөрөнгө оруулалт зээллэг 2022 онд 900 сая доллароор өссөн. Засгийн газрын өр 5,9 их наяд төгрөгөөр өссөн. Тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ 835 тэрбум буюу 36 хувиар өссөн. Халамжийн үйлчилгээнд 1,4 сая хүн хамрагдаж зардал нь 56,8 хувиар өссөн. Ядуурал болон ядуурах магадлалтай иргэдийн тоо 42,5 хувь байсан бол энэ буураагүй. Баян хоосны ялгаа 2022 онд буураагүй. Гэмт хэргийн өсөлт 39 хувиар өссөн. Гадаад валютын нөөц 3,6 тэрбум

доллар болсон боловч хугацаа хэтэрсэн болон анхаарал хандуулах шаардлагатай зээлийн хэмжээ м2 мөнгөний 12-13 хувь болж өссөн байгаа. Өрийн үйлчилгээ 1.1 их наяд орчим төгрөгийг зарцуулсан байна. 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд 300 төсөл арга хэмжээг 11,7 их наяд төгрөгөөр санхүүжүүлнэ гэсэн боловч 30 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Ингээд бид өөрснөө хуримтлал үүсгэж бүтээн байгуулалт хийж чадахгүй байгаа. Бүтээн байгуулалт хийж болох зарим зүйлүүдийг зөвхөн гаднын зээл тусламжаар хийж байгаа. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой компаниудын гадаад өр 45 их наяд байснаа 53 их наяд болж, 8 тэрбум төгрөгөөр өссөн. Ийм л үр дүнтэй төсвийн гүйцэтгэлийг бид нар ярьж байна.

Үнэхээр төсөвт хэдэн төгрөг нэмэгдээд, цалин тэтгэвэр нэмж байгаа боловч цаад утгаараа Монгол Улсын эдийн засгийн байдал маш хүнд байдалтай байгаа. Энэ бол өнөөдөр энд ажиллаж байгаа хэдэн хүнийг шүүмжилж байгаа юм бол биш. Өнгөрсөн хугацааны алдагдал магадгүй энэ Засгийн газар хамгийн хүнд үед ажиллаж байхыг ч үгүйсгэхгүй байгаа юм аа.

Энэ бүхнээс ингээд дүгнэлт хийхэд Монголын хөгжлийн бодлого, хөгжлийн загвар нь буруу байгаад байгаа юм. Манай хөгжил хариуцсан хүмүүс дандаа либерал загвар яриад байдаг. Дан либерал загвараар бид яваад хөгжил ирэхгүй. Хуримтлал үүсгэж чадахгүй. Хуримтлалгүй болохоор бид нарын хийж байгаа бүх ажил амьсгүи болоод байгаа. Тэгэхээр бид баялаг дээрээ суурилсан төрийн оновчтой бодлого, хувийн хэвшилээ дэмжсэн, манлайлагч нараар манлайлуулсан, хурдтай хөгжлийн хуримтлал үүсгэдэг ийм хосолсон загвар бидэнд хэрэгтэй. Хөгжлийн загвараа эргэж үзэхгүйгээр бид юу ч хүрэхгүй. Энэ байдал цаашидаа улам даамжирна. Ийм учраас энэ дээр дүгнэлт хийх.../минут дуусав/

Г.Занданшатар: Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж хариулна.

Б.Пүрэвдорж: Баттөмөр дарга үнэхээр эдийн засагч хүнийхээ хувьд маш зөв дүгнэлтийг хийж байна. Танд талархаж байна. Тэгэх дээр ер нь сүүлийн 7 жилийн туршид Монголын эдийн засаг 12-15 тэрбум долларын хооронд л хэлбэлзээд байгаа. Төгрөгийн дүнгээр жишээ нь 2022 оны 1 сарын 1-нд 1 доллар 2800 байсан бол 3400 орчим болоод 600 төгрөгийн зөрүү нь л тэр эдийн засгийг төгрөгөөр өсгөж байгаа мэт харагдаж байгаа боловч 12-15 тэрбум долларын хооронд л эдийн засаг хэлбэлзээд байгаа. Тэгээд 2022 онд инфляц бол 19 хувьтай гэж Үндэсний статистикийн газар гаргаад байгаа юм. Яг тийм биш. Бид нарыг 2022 оны 2 сарын 1-ний өдөр улсын төсвийн тодотгол хийгээд тэтгэвэр нэмж байхад 1 шуудай гурил 50 мянган төгрөг байсан. Оны эцэс гэхэд 110 мянган төгрөг болсон байхгүй юу даа. Нэг дахин өсөөд цаашиа явсан. Тэгэхээр яг бодит амьдрал дээр бол 19 хувийн инфляц гэдэг байхгүй шүү. Тэрнээс өндөр байгаа шүү. Ард түмний хармааг хоослох энэ ажлыг Засгийн газар гаргууд хийсэн шүү гэдгийг хэлье. Нийт өр бол 2022 онд 5 их наяд төгрөгийн өр тавьсан байгаа шүү дээ. Энэ бол 2 Чингистэй тэнцэх мөнгө байхгүй юу даа. Тэгээд ямар бүтээн байгуулалт хийв. Юу хийсэн бэ тэрийгээ нэрлээд өгөөч гэхээр бүтээн байгуулалтын нэг ширхэг ч юм байхгүй байна сууж байгаа. Тэгээд гадаад өр бол 33,9 тэрбум доллар болж, түүхэндээ хамгийн өндөр хэмжээнд хүрсэн. 2016 онд 15 сая төгрөгийн өртэй, гэдсэнд байгаа хүүхэд чинь хүртэл 15 сая төгрөгийн өртэй гэж айлгаж байсан МАН өнөөдөр хүн болгоныг 33 сая төгрөгийн өртэй болгочоод сууж байгаа. Харамсалтай нь 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл нүдэнд харагдаж гарт баригдах тийм бүтээн байгуулалтын ажил хийсэнгүй. Хүмүүсийн амьдрал яг байдаг хэвээрээ нийт хүн амын 3-ны 1 нь

ядуурсан, 3 хүний 2 нь ажилгүй, нийт яг эд насны ажиллах хүчин нь ихэнх нь гадаад руу дүрвэж гарсан ийм орон болж хувирч байна шүү. Тийм учраас ялангуяа эдийн засгийн уул уурхайн бараа бүтээгдэхүүний үнэ өндөр байгаа энэ үед орж ирж байгаа орлогоороо жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрүүдийг байгуулах, ажиллах хүчний цалинг нэмэгдүүлэх тэр тодорхой ажлуудыг хийх зайлигүй шаардлага гарчхаж байна гэдгийг хэлье. Тэгээд хамгийн сүүлд нь хэлэхэд 5 их наяд төгрөгийн зөрчил 2022 онд гарсан шүү. Энэ чинь нийт төсвийн чинь бараг 30 хувь байхгүй юу даа. Нийт төсөв чинь 30 хувь. Тэгээд Монгол Улсын төсвөөр гүйцэтгэдэг тэр ажлуудыг 6618 төрийн албан хаагч дээрээсээ доор хүртэл тэр эмнэлгийн нягтлан хүртэл бүгдээрээ гарын үсэг зурдаг, сургуулийн нягтлан хүртэл гарын үсэг зурдаг. Тэр хүмүүс дээр тооцоод үзэхэд нэг хүн дээр 750 сая төгрөгийн зөрчил гарч байна шүү дээ. Үгүй ээ, энэ чинь юу болж байгаа юм бэ. Ямар хариуцлагагүй байна аа. Ийм хариуцлагагүй гүйцэтгэх засаглалын ажил дээр энэ парламент Хяналт шалгалтын тухай хуулиараа тодорхой ажлуудыг хийхгүй бол болохгүй байна шүү гэдгийг бас Их Хурлын удирдлагууддаа хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны саналаар “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Санал хураалт. 59,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Тогтоолыг уншиж танилцуулъя.

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай”

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.4 дэх заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь:

1. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ 10 их наяд 235 тэрбум 124 сая 600 мянган төгрөгөөр баталсугай.

2. Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийн зарлагын /тэнцвэржүүлсэн орлого нийцүүлсэн/ хэмжээг 11 их наяд 359 тэрбум 914 сая төгрөгөөр баталсугай.

Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу. Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.14 цаг

Дараагийн асуудалд оръё. Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд Боловсролын ерөнхий

хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасны дагуу хуулийн төслийн зарим зүйл, заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүйг нь үзсэн тул ажлын хэсгээс гаргасан 1 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж гишүүдийн олонх дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн

шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Санал хураалт явуулна. Ажлын хэсэг нь хааччихсан юм.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Зарчмын зөрүүтэй 1 санал байгаа. Дээд боловсролын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол. Дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу дахин санал хураагдсан. Байнгын хороо Лхагваад дахин сануулъя. Байнгын хороон дээр хэлэлцэгдээд дэмжигдсэн саналыг чуулганд оруулахдаа завсраар нь өөрчлөөд байдаг асуудлыг Үнэнбат дарга аа. Тэр Боловсролын ерөнхий хууль дээр 4 саналыг завсраар нь өөрчилчихсөн. Их Хурлын дарга хууль заслаа гэж цэц дээр дуудагддаг байсан бол одоо Байнгын хорооны референт дундаас нь засаад байдгийг яах юм бэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал.

1.Төслийн 5 дугаар бүлгийг 6 дугаар бүлэг болгож, төсвийн төслийн 23.1 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх бөгөөд” гэснийг хасаж, 23.1.4 дэх заалтын “зэрэг” гэсний дараа “, цол” гэж нэмж, мөн зүйлийн 23.1.3 дахь заалтыг төслөөс хасаж, төсөл дор дурдсан агуулгатай 23.1, 23.3, 23.4 дэх хэсэг нэмэх:

“23.1 Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.

23.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн

удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.

23.4.Энэ хуулийн 23.3-д заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Тогтохсүрэн дарга аа, нөгөө таны санал тусгагдсан байна уу энэ дээр. Энэ ингээд шинэ агентлаг байгуулаад байж болж байгаа юм уу. 23.3-д заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гэж байна шүү дээ. Сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэх нэгжтэй байх нь байна. Санал хураалт. 55,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүллээ.

11.18 цаг.

Зургаа.Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Зарчмын зөрүүтэй 9 саналтай.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай 42дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Байнгын хороо 9 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулахад, 8 санал дэмжигдэж, 1 санал дэмжигдээгүй болно.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь томъёолон та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан,

спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсэг орж ирсэн байна. Ингээд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганболдын Ганбаяр Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Хөжсөөгийн Тамир Дээд болон мэргэжлийн боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын дарга, Огнонгийн Хуягцогт Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Чимэдрэгзэнгийн Баярмаа Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч, Жамцын Нарантуяа Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Ариунбатын Халиунаа Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга, Дарьсүхбаатарын Билгүүдэй Боловсрол шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх, Ухнаагийн Туяа боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч, Шажинбатын Ариунаа Шинжлэх Ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор профессор.

9 санал хураалттай. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энэтэй холбоотой асуулт байна уу. Алга байна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Ганбат гишүүн нэрээ татсан байна. Тэгэхээр ингээд санал хураалтдаа оръё. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 9 санал байгаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу дахин боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт хийнэ.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийн “6.3” гэснийг, 6.14 дэх хэсгийн” “тусгай гэснийг тус тус төслөөс хасаж, 6.2 дахь хэсгийн “бие даан ажил” гэснийг “хувиараа” гэж /цаашидаа тохиолдол бүр/, 6.5 дахь хэсгийн “хэмжих ба багц цагийг дараагийн түвшний боловсролд тооцож дүйцүүлнэ” гэснийг “тооцох бөгөөд дараагийн боловсролын түвшинд дүйцүүлнэ” гэж, 6.6 дахь хэсгийн “багц цаг” гэснийг “”мэргэжлийн болон техникийн боловсролын багц цаг гэж, 6.8 дахь хэсгийн “ажил олгогчийн” гэснийг “түншлэлийн” гэж өөрчилж, 6.11 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд доор дурдсан агуулгатай 6.15 дахь хэсгийг нэмэх:

“6.11.Мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.15.Мэргэжлийн сургалтын хөтөлбөрт дүгнэлт гаргах, баталгаажуулах журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 63,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “Үнэлгээ, баталгаажуулалт” гэснийг “Чанарын баталгаажуулалт” гэж, 8.2 дахь хэсгийн “Хүний өмнөх мэдлэг, ур чадвар, чадамжийг” гэснийг “Эзэмисэн мэдлэг, ур чадварыг” гэж

өөрчилж, 8.1 дэх хэсгийн “суралцагч” гэсний өмнө “мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дахь хэсгийг нэмэх:

“8.3.Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журмыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

8.4.Магадлан итгэмжлэлийг Боловсролын ерөнхий хуулийн 17.12-т заасан байгуулга мөн хуулийн 30.1.12-т заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

8.5.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагыг таван жил тутам магадлан итгэмжилнэ.

8.6.Боловсролын ерөнхий хуулийн 29.1.8-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.

8.7.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага Боловсролын ерөнхий хуулийн 40.7-д заасны дагуу дотоод чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 66 хувийн саналаар санал дэмжигдлээ. Асуулт байхгүй.

3.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “63.1, 63.2, 63.3 дахь заалтад” гэснийг “63 дугаар зүйлд заасныг” гэж өөрчилж, төслөөс 11.6, 11.7 дахь хэсгийг хасах.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Санал хураалт. 70 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1 Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоонд Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д зааснаас гадна хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бүрдэнэ.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 64 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 22 дугаар зүйлийн гарчиг, 22.1 дэх хэсгийн “Үндэсний зөвлөл” гэснийг “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/” гэж, 22.2 дахь хэсгийн “төрийн захиргааны байгууллага” гэснийг “төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн хэсгийн “бүрдэнэ” гэснийг “бүрдсэн нийт 15 гишүүнтэй байна” гэж, 22.3, 22.5 дахь хэсгийн “Засгийн газар” гэснийг “Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, 22.6 дахь хэсгийн “Засгийн газарт” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 27.4-д заасан үндэсний зөвлөлд” гэж, төслийн 22.9.5 дахь заалтын “эдийн засгийн” гэснийг “эрэлттэй болон” гэж өөрчилж, мөн зүйлийн 22.8 дахь хэсгийг төслөөс хасаж, 22.4 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулах:

“22.4.Зөвлөлийн даргыг мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүний олонхын саналаар томилно.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Ер нь Засгийн газар гэсэн бүх эрх мэдлийг сайд дээр ингээд төвлөрүүлээд байж болж байгаа юм уу. Засгийн газар

гэснийг Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гээд л бүгдийг нь өөрчлөөд л байх юм. Санал хураалт 64,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.8 дахь заалтын “их сургууль, дээд сургуулийн” гэснийг “дээд боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, 23.1.4, 23.1.7 дахь заалтын “тусгай” гэснийг, 23.1.8 дахь заалтын “энгийн” гэснийг хасах. Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 68,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийн “хүрээнд” гэсний дараа “Боловсролын эрхийн хуульд зааснаас гадна” гэж, мөн зүйл доор дурдсан агуулгатай 24.1.7, 24.1.8, 24.1.9 дэх заалт, 24.2 дахь хэсэг нэмж, төслөөс 24.1.4, 24.1.5 дахь заалтыг хасах:

“24.1.7.багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг түншилэгч талуудтай хамтран зохион байгуулах;

24.1.8.багш, ажилтны мэргэжлийн зэрэг олгох ахиулах, сунгах;

24.1.9.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн захирлыг Төрийн албаны тухай хуульд заасан сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх.

24.2.Энэ хуулийн 24.1.7-д заасан чиг үүргийг Засгийн газрын тухай хуулийн 19.1-д заасан байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж болно.” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 68,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Үгүй ээ, аймгийн Засаг даргатай зөвшилцөж гэж оруулъя гэсэн яасан юм бэ. Тогтохсүрэн дарга тийм

санал гаргасан шүү дээ уг нь. Тэгээд гүйцээн боловсруулах чиглэл өгсөн чинь ингээд Байнгын хороо ер нь ямар учиртай юм бэ. Ер нь Үндсэн хуульд нутгийн удирдлагын хэвтээ, төрийн удирдлагын босоо тогтолцооны огтлолцол дээр нутгийн удирдлагыг хэрэгжүүлнэ гэж байгаа. Одоо бол хэтэрхий сургуулийн захирлыг сумын Засаг дарга томилдог болчихоод байгаа байхгүй юу. Тэгээд яах вэ мэргэжлийн удирдлага нь алдагдаад байгаа юм. Тэгтэл энийг мэргэжлийн удирдлага, нутгийн удирдлагын оролцоогоо хангахгүй бол тэр аймаг, сумд ямар чадалтай хүн байгаа гэдгийг Улаанбаатар хотоос 1 хүн яаж мэдэж шийдэх юм бэ гэдэг асуудал гараад байгаа. Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн захирлыг томилох гэж байгаа шүү дээ. Сонгон шалгаруулалтын дүнгээр үндэслэн томилно гэж байгаа юм. 68,6 хувийн саналаар санал дэмжигдсэн.

8.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.3.1 дэх заалтын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан” гэснийг “мэргэжлийн сургалтын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хуваарилсан хөрөнгө” гэж, 29.4.1 дэх заалтын “төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн, техникийн, боловсролын сургалтын байгууллагын” гэснийг “өмчийн хэлбэр үл харгалзан мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 29.3.3, 29.3.4 дэх заалт нэмэх:

“29.3.3.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын өөрийн болон туслах үйл ажиллагааны орлогын тодорхой хувь;

29.3.4.энэ хуулийн 19.4-д заасны дагуу төвлөрүүлсэн хөрөнгө.” Санал гаргасан Боловсрол, соёл,

шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Лхагваа энийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдтайгаа салбар дундын зохицуулалт учраас ойлголц гэсэн ойлголцсон уу. Ярьж тохирсон юм уу. Санал хураалт.

Мэргэжлийн боловсрол салбар дундын зохицуулалтын асуудал шүү. Хувийн хэвилийн ч оролцоог хангах ёстой.

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын байнгын хороо дэмжээгүй
санал:**

1.Төслийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчилж, төсөлд 26.5.3, 26.5.4, 26.5.5, 26.5.6 дахь заалт, 26.7 дахь хэсгийг нэмэх:

“26.4.Удирдах зөвлөл нь нийт арван нэгэн гишүүнтэй байх бөгөөд Төрийн захиргааны төв байгууллагаас гурав, нутгийн захиргааны байгууллагаас гурав, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх нэг, аж ахуйн нэгж, байгууллагыг төлөөлөх гурав, суралцагчийн нэг төлөөллөөс бүрдэнэ. Удирдах зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

26.5.3.мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тухайн жилийн төсвийн төслийг хэлэлцэх, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг батлах, үр дүн, чанар, гүйцэтгэлд хяналт тавих;

26.5.4.төсвийн хязгаарт нийцүүлэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт, цалингийн санг тогтоох;

26.5.5.төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын захирлыг энэ хуулийн

23.1.10-д заасан журмын дагуу сонгон шалгаруулж, томилох, хууль тогтоомжид заасан үндэслэлээр чөлөөлөх;

26.5.6.боловсролын сургалтын байгууллагын захиралтай байгуулсан гэрээг дүгнэх .

26.7.Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд томилно. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Энийг дэмжихгүй байвал Дэлгэрсайхан гишүүний санал босох юм байна. Үндсэн хуульд нь тэр байхгүй. Тэгээд удирдах зөвлөлгүй байна гэж. Дамдинням гишүүн ээ байхгүй шүү дээ. Удирдах зөвлөл гэж төслөөрөө үйлдэж байгаа юм. Төсөл дээр удирдах зөвлөл байгаа юм. Удирдах зөвлөл тэр удирдлагыг томилдог эрх хэмжээг л оруулсан тэр нэг заалтуудыг л байхгүй болгож байгаа юм. Төлөөлөх хангахыг байхгүй болгож байгаа юм. Удирдах зөвлөл нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд үүсгэн байгуулагчийг төлөөлөх нэг, тухайн сургалтын байгууллагын хамт олныг төлөөлөх 2, түншилэгчийг төлөөлөх 5, төгсөгчийг төлөөлөх нэг гишүүний бүрэлдэхүүнтэй байна гэсэн ийм агуулгаар үлдэнэ. Байнгын хорооны санал дэмжигдлээ. Саналыг дэмжье.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Ажлын хэсэгт хариуцлага тооцож болно. Хүндэтгэлгүй хандсан гэж.

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ.

Ер нь энэ Боловсролын хууль дээр дараа нь сайн нэг хяналт үнэлгээ хийлгэх ёстой л юм байна лээ. Ажлын хэсэгт баярлалаа. Явж болно.

11.39 цаг.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ ээ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Их Хурлын гишүүн Хишгээгийн Нямбаатар танилцуулна.

Х.Нямбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 109 дүгээр захирамжаар Гашуунсухайт- Ганцмод боомтын хил холболтын төмөр замын техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг цогцоор нь барих ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан.

Тус ажлын хэсэг Монгол Улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөлд зарчмын шинжтэй дараах асуудлыг тусгасан болно.

1 дүгээрт.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг судлах, хэрэгжилтийг эрчимжүүлэх;

2 дугаарт.Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганц мод боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлж холбогдох зардлыг Эрдэнэс Тавантолгой ХК-аас санхүүжүүлэх;

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ганц мод төмөр замын өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгч төрийн өмчит компани болон Эрдэнэс Тавантолгой компанийн хооронд үе шаттай жил бүр 20 сая тонн хүртэл нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх;

Таван толгой нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж, тайлагнахыг Засгийн газарт даалгасан болно.

Түүнчлэн уг тогтоолын дагуу байгуулах аливаа гэрээг ашигт малтмал, түүхий эдээр төлөх буюу оффтэйк нөхцөлөөр байгуулахгүй байхаар тусгалаа. Тогтоолын төсөл батлагдсанаар Таван толгойн бүлэг ордын үнэ цэн өсөх, тээврийн өртөг зардал буурах, уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтээс үүсэж буй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, төсвийн орлого болон валютын нөөц нэмэгдэх, эдийн засгийн өндөр ач холбогдолтой юм.

“Ганцмод-Гашуунсухайтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайдад баярлалаа. Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнэ танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр Улсын Их Хуралд нэн яаралтай горимоор өгөн мэдүүлсэн “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотой авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд боомтын сэргэлтийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын олон улсын гэрээнд өөрчлөлт оруулах, олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах, төмөр замын хилийн боомтын холболтын техник эдийн засгийн үндэслэл, зураг төслийн болон барилга байгууламжийг барих ажлыг эрчимжүүлэх, нүүрсний орд газрыг иж бүрэн ашиглах, эдийн засгийн үр өгөөж, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор тогтоолын төслийг боловсруулж өргөн мэдүүлсэн байна.

Тогтоолын төсөл батлагдсанаар улсын төсвөөс нэмэлт зардал шаардагдахгүй гэж төсөл санаачлагч

үзсэн бөгөөд тогтоолын төслийг D-Parliament.mn цахим сайтад байрцуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцсэн үед Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ж.Бат-Эрдэнэ нар Ганцмод өртөө хүртэлх төмөр замын суурь бүтэц өмчлөгчийн төрийн өмчит компани байх эсэх, төмөр замын бүтээн байгуулалт, хил дамнасан байгууламж, нүүрсний квотын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганд нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу. Байхгүй байна. Дэлгэрсайхан гишүүнээр тасаллаа. Энхтүвшин гишүүнийг нэмье. Ингээд Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Энэ зүйлийг бараг 7 жил хэдэн жил ярьж байна вэ. 7, 8 жил

ярьж байгаа байх. Тэгээд хэзээ холбогдох вэ. Хэр их хэмжээний мөнгө төгрөг гарах юм бэ. Тэгээд ингэж байтал I ажлыг хийнэ, барина гэж байтал хамгийн гол нь энэ боомт, төмөр замын цариг нь ямар байх юм бэ. Хаанаасаа яаж явах юм бэ гэдэг зүйлийг тодруулъя.

Тэгээд яг хэдэн онд ашиглалтад орох вэ. Ашиглалтад орж байтал энэ нүүрсний чинь үнэ уначих байх аа. Аягүй л бол. Тийм байдалтай байж магадгүй. Өмнө нь хийсэн ажлууд байгаа. Тэр Гашиунсухайтаас ийш тийшээ тавигдсан төмөр замууд байгаа. Тэр зам маань ашиглалтад хэзээ орсон. Ашиглалтад орсноос хойших хугацаанд ашиглагдаж байна уу. Яаж байна вэ. Ингээд сайн юм бол дандаа ингээд өөрсдөдөө наагаад ингээд ни ар-даад, шоудаад яваад байдаг. Тэгээд тааруухан юм болбол ямар нэгэн байдлаар Ардчилсан нам юм уу, Ардчилсан намын нэртэй хүмүүс рүү ингээд түлхдэг ээ та нар. Би төмөр замын асуудлыг ярих гээд байгаа юм. Тэгээд Засгийн газар нь байсаар байтал Засгийн газар нь ажлаа хийж чадахгүй, тэгээд манай Ардчилсан намаас сонгогдсон Монгол Улсын Ерөнхийлөгчийг байнга буруутгадаг. Тухайн үед нь та нар чинь олонх байж байгаад л Яам, Тамгын газрууд нь байж байгаад л хийсэн ажлууд. Тэгээд энэ төмөр замынхаа асуудлыг ер нь яаж шийдээд байна вэ. Бид бүхэн маань дайнаас болоод Украин-Орос 2-ын дайнаас болоод Оросын Холбооны Улс хоригт орчихсон байгаа. Тэгээд бид нарыг гадна дотно ярихдаа хойд хөршөөсөө нэлээн хараат ийм улс гэж ярьдаг. Төмөр зам, зам тээврийн хувьд. Тэгээд цаашидаа бол хойд хөрш маань урд хөршөөс маань маш их хамааралтай болчихлоо. Цаашидаа ч бүр их хамааралтай болно гэж ярьж байна. Тэгээд бид нарын өмнө авч байсан тэр Локмотив гэдэг байх, зүтгүүр тээ. Тэр нь 2 3-ыг авсан хэлтэй амтай. Тэр нь олон улсын царигт зориулсан ийм зүтгүүрийг дээд талыг нь солиод, доод талыг нь солиод ингээд ажил үүрэг

гүйцэтгэж чадахгүй ийм хэмжээнд очсон гэсэн ийм зүйл яриад байх юм. Өмнө барьсан замуудаа бид нар яаж ашиглаад байна вэ. Юу болж байна вэ. Нэг их сүртэй очоод л бүгдээрээ тууз хайчлаад л яваад байсан. Тэгээд ард түмний өмч хөрөнгийг, ард түмний татвараас орж ирж байгаа энэ бүх боломжуудыг ямар ч ашиг орлогогүй ийм зүйл рүү хийчхээд, дараа нь тэгээд хэн ч хариуцлага хүлээхгүй өнгөрдөг зүйл байна аа. Энэ зүйлийг юу гэж бодож байна вэ. Энэ тогтоол маань бас л ээлжит тэр нэг тогтоолын өмнө байсан алдаа дутагдлын үргэлжлэл болж байна уу. Юу болж байна. Энийгээ нэг тодорхой тайлбарлаад өгөөч ээ. Би бол мэдэж л байна. Гэхдээ энэ олон түмэн сонсог гэж бодож байгаа юм.

Л.Мөнхбаатар: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя.

Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн даргын үүргийг орлон гүйцэтгэгч Нармандахын Жамъянхүү, Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого, зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Хүчитбаатарын Итгэлт, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Хууль, эрх зүйн газрын дарга Эрдэнийн Түвшинжаргал, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Маркетинг, борлуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн Баянгийн Серикжан, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хувийн эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн Лувсанцэрэнгийн Пүрэвсүрэн нар оролцож байна.

Асуултад хариулъя. Хэн хариулах вэ. Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би Ганбат гишүүний асуултад мэдэж байгаа

асуудлуудаа хариулъя. Ганбат гишүүн маань их тийм цар хүрээтэй улс төрч хүн учраас геополитикийн асуудлыг хөндөж ярилаа. Би яг геополитикийн асуудал дээр хариулт өгч мэдэхгүй байна. Царигийн хувьд өргөн, нарийн царигаар Монгол-Хятадын хилийн 703 дугаар баганаар хил холболтын цэгт тохирч, өргөн, нарийн царигаар 2 улсын хил рүү 2 тийм цариг зөрж орно. Хугацааны тухайд техник эдийн засгийн үндэслэл боловсруулагдах ажил яг ид шатдаа явагдаж байна. Бид ирэх оны 1 дүгээр улиралд багтааж барилга угсралтын ажлыг эхлүүлэх ийм төлөвлөгөөтэй байгаа. Өнөөдрийн Улсын Их Хурлын тогтоол батлагдсаны дараа 8 дугаар сард Монгол-Хятадын төрийн өмчит компаниудын хооронд, мөн Засгийн газрын ажлын хэсгийн оролцоотойгоор ажлын хэсэг хуралдана. Өөр хоорондоо ерөнхий хэлэлцээрийг дагасан нарийвчилсан хэлэлцээрүүдийн төсөл дээр сууцгаана. Энэ ажлууд хэдий хурдан хийгдэнэ, төдий чинээ цаг хугацаа хожиж, ажил эхэлнэ гэдгийг товчхондоо хэлье.

Үнэ хэдийд яаж гарах вэ гэвэл ТЭЗҮ гарсны дараа, ажлын зураг гарсны дараа, нийт ажлын өртөг гарна. Бидний тухайд одоогийн Гашиунсухайтын боомт дээр аваачсан төмөр замын үзүүрээс Монгол Улсын хилийн 0 цэг хүртэлх тэр хоорондох зардлаа өөрсдөө хариуцна. Цааших зардлыг Хятадын тал хариуцна. Хятад-Монголын хилийг дамнан баригдах төмөр замын барилга угсралтын ажлыг үндсэндээ Чайна Энержи компаниар гүйцэтгүүлье гэдэг ийм асуудал дээр 2 талаас тохиролцсон байгаа. Энэ шийдвэрийг өнөөдөр албажуулахаар байгаа. Энэ шалтгаан нь хэд хэдэн шалтгаантай гэдгийг би дараа нь нэмэлт асуултад хариулъя.

Өмнөх ашиглалт яасан бэ гэхээр өнөөдөр нөгөө өмнө нь баригдсан Тавантолгой Гашиунсухайтын хооронд баригдсан 286км төмөр замаар нүүрс тээвэрлэлтийн процесс явагдаж байгаа.

Таны хэлж байгаачлан 1 дүгээрт хил холбогдоогүй, 2 дугаарт зүтгүүрийн тоо зэргээс шалтгаалж энэ төмөр замыг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж чадаагүй байгаа гэдэгтэй санал нэг байна. Бид нар 1955 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улстай төмөр замын хэлэлцээр байгуулсан. Тэгэхээр цаашид бид нар хэд хэдэн үзгээр Бүгд Найрамдах Хятад Ард Улстай хил дамнасан төмөр замын ажлууд, тээвэрлэлтүүд эхлэх гэж байгаатай холбогдуулж 2004 оны хил боомтын дэглэмийн хэлэлцээр, 1955 оны төмөр замын хэлэлцээрүүдэд өөрчлөлт оруулах асуудал давхар яригдана. Өмнөх 1955 оны хэлэлцээр буюу 1956 оноос хэрэгжиж эхэлсэн хэлэлцээрээр зөвхөн Замын-Үүд-Эрээн боомтын хооронд холбосон төмөр замын хэлэлцээрийг үйлчилж байсан. Тэгвэл энэ 10 дугаар сараас бид нар Шивээхүрэн, Сэхээ боомтын хооронд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт дуусах байх. Ингэхээр үүнээс өмнө хэлэлцээр явагдах ёстой. Энэ Ганцмод- Гашиунсухайтын боомтын асуудал холбогдохоор бас төмөр замын хэлэлцээрийг нарийвчлах шаардлагатай болж байгаа.

Дараагийн бид нарын нэг том амбиц бол ирэх жил бид нар багтаж, 2004 оны Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Монгол Улсын хооронд байгуулагдсан хил боомтын дэглэмийн хэлэлцээрт өөрчлөлт оруулж, Ханги мандлыг төмөр замын боомт болгон өргөтгөн зохион байгуулах хэлэлцээрийн ажил цаашаа үргэлжлэхээр урьдчилсан байдлаар ярианууд хийгдээд байгаа. Эхний ээлжид бид нар Ганцмод-Гашиунсухайт, Бичигтийн төмөр замын боомтуудаа холбох ажил бол бидний хамгийн чухал ажил.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Тодруулах уу та. Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Ингээд тогтоолын төслийг үндсэндээ дэмжиж байна. Энэ тогтоолын төсөл батлагдахаар энэ төлбөрүүд нь хаанаас гарах вэ. Ямар

компани шалгарч энэ ажлыг гүйцэтгэх гэж байна вэ. Тэгээд цаг хугацааны хувьд та нэг их тодорхой хэлэхгүй байх шиг байна. Хэдий орчим хугацаанд ашиглалтад ороод, ямар компани гүйцэтгээд, яаж төлбөрийг нь Эрдэнэс Монголоос л гэгчихсэн байна. Өмнө нь оффтейк-ээр нүүрсээр төлбөр хийгээд байдаг байсан. Одоо энийг яах юм бэлэн валютаар хийх юм уу, зээлээр хийх юм уу. Ямар маягаар хийх юм гэсэн ийм асуудлыг тодруулмаар байна.

Энэ дотор сууж байгаа хүмүүс байна уу. Өмнө нь оффтейк гэрээгээр баахан төмөр зам баруулаад, баахан мөнгө төгрөгийг нь өгөөд байгаа. Тэр гэрээ үргэлжилж байгаа юу. Өр, авлага нь ямар хэмжээнд үлдсэн бэ. Ямар үнээр өгөөд байна вэ. Зах зээлийн үнээр өгч байгаа юм уу, эсвэл яг тэр гэрээ дээрээ заасан үнээр өгч байна уу гэсэн энэ асуудлыг бас энэ ажлын хэсгийнхнээс тодруулаад өгчихвөл зүгээр байна.

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Баянхонгор аймгийн ерөнхий боловсролын “Номундалай” сургуулийн 2003 оны төгсөгчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхний ажил, амьдралд хамгийн сайн сайхан бүгдийн дээдийг хүсэн ерөөе.

Тодруулгад хариулъя. Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Засгийн газар дээр ярилцсан юм. Тэгээд энэ оффтейк нөхцөлүүд эдийн засгийн хувьд үр өгөөж муутай юм. Бид нар нүүрсээ зах зээлийнх нь үнээр зараад, түүнээсээ бэлэн мөнгөөрөө төлбөр тооцоогоо хийж явах нь эдийн засгийн тооцооллын хувьд ашигтай гарна гэдэг ийм саналыг Засгийн газрын зарим гишүүд гаргасан. Тэгээд энэ дагуу Засгийн газрын тогтоолын төсөл дээр 0 цэг хүртэлх төлбөр төмөр замын бүтээн байгуулалтын төлбөрийг Эрдэнэс Тавантолгойн борлуулалтын орлогоос

бэлнээр нь төлье гэдэг агуулгаар орж ирсэн. Хугацааны хувьд Ганбат гишүүн ээ, хугацааны хувьд ер нь ийм байгаа юм. Манай талд хийгдэх төмөр замын байгууламж нь нэлээн төвөгшил ихтэй. Яагаад гэвэл манай газрын хэвгий тал нь, нам доор тал нь манай талтай байгаа. Тэгээд ойролцоогоор 40 орчим метр өндөртэй 2 ийм хос стакадан гүүр барьж, байгуулах ийм.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Холболтын төмөр замыг хийх нь эдийн засгийн хувьд үнэхээр ач холбогдолтой. Энийг хийхгүйгээр бол өмнө нь бид нарын наана нь барьсан 1,4 тэрбум долларын төмөр зам бол өөрөө ямар ч ашиглагдахгүй, үр ашиггүй байгаа л даа. Тэгэхээр би Их Хурлын даргаас асуух гээд байгаа шүү. Өмнө бид нар нүүрсний хулгайгаар шалгалт хийгээд явж байхад Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр нууцад хамруулж байгаад баахан гэрээ хийсэн. Тэр нь нэг компанитай шууд гэрээ хийе гэсэн үг биш. Үүнээс болоод өмнө нь гэрээ хийсэн хүмүүс шалгагдаад, шорон оронд ороод явж байгаа шүү. Гэтэл энэ тогтоолын 2, 3, 4 дэх заалтуудыг хараадах даа. Бид нар Их Хурал сонгон шалгаруулалт хийж байх шиг л шийдвэр гарч байна даа. Тэр компанитай гэрээ хий, тэндээс санхүүжүүл гэдгийг нь зааж өгсөн байна шүү дээ. Бүр нэг ёсондоо компанийг нь заагаад өгсөн Их хурлаас. 3 дээр. Суурь бүтцийг эзэмшиж байгаа Хятадын компанитай гэрээ хий. Тавантолгой компаниас санхүүжүүл гэж байгаа юм.

4-д нь 1 компанид ингээд жилд 20 сая тонн нүүрсийг шууд гэрээ хий гэдгийг ингээд Их Хурлын тогтоолоор бид нар зааж өгч байна даа. Тэгээд Их Хуралд ийм тогтоол гаргаад явах нь хэр оновчтой бол. Дараа нь мэдээж хэзээ нэгэн өдөр бас өмнөх хэргүүд шиг шалгагдана. Одоогийн Эрдэнэс Тавантолгойн удирдлагууд тэр үед

шалгагдах үеэр яг манай Их Хурлын гаргасан тогтоол тэр хүмүүсийг аврах эсэхийг нь би бол эргэлзэж л байна. Өмнө нь бол Аюулгүйн Зөвлөлийн шийдвэрүүд гараад, тэгээд явсан ч гэсэн шууд гэрээ хий гэсэн үг байгаагүй л дээ. Одоо бол Их хурлын тогтоолоор иууд ийм шийдвэр гаргаад явах нь хэр оновчтой вэ гэдгийг би Их Хурлын удирдлагуудаас асуух гээд байгаа юм.

Тэгэхээр техник эдийн засгийн үндэслэлийг маш сайн хийж байж гэрээ хийгээрэй Засгийн газрын хувьд. Өмнө нь бол Гашиунсухайт чиглэлийн төмөр зам чинь төмөр замын техник эдийн засгийн үндэслэл нь одоогоороо Монгол хэл дээр орчуулагдаагүй явж байгаа. Гадаад хэл дээр. Тэр агуулгаараа дотоодын аж ахуйн хяналт тавьдаг аж ахуйн нэгжүүд нь техник эдийн засгийн үндэслэл нь Монгол хэл дээр орчуулагдаагүйгээс болоод хяналт тавьж чаддаггүй. Тэрнээсээ болоод төсөл хэрэгжих явцад нэлээн хүндрэл бэрхшээлүүд гарсан дутуу ажлууд хийгдсэн ийм зүйлүүд байгаа юм. Тэгэхээр техник эдийн засгийн үндэслэлийг нь холбогдох газрууд маш сайн хянаж баталсны дараа гэрээг хийж явах нь зөв шүү гэдэг ийм зүйлийг хэлэх гэсэн юм.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүний асуултад хариулъя. Нямбаатар сайд хариулах уу. 3, 4 дээр яагаад энэ компанийн нэр заасан бэ гэдэг асуудлаар ярьж байна шүү дээ. Энэ дээр нь тодорхой хариулт өгчих.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би хэдэн бичиг баримт та хэдэд үзүүлэе гээд авчирсан юм. Миний хугацааг хуралдаан даргалагч жоохон өгөөрэй. Энэ 2004 оны Монгол-Хятадын хил боомтын дэглэмийн гэрээ байгаа. Энэ дээр нийтдээ Монгол-Хятадын хиллэж байгаа 17 боомтын аль аль нь төмөр замын, аль аль нь авто замын боомт байх вэ гэдгийг тодорхойлсон. Дараа нь Монгол Улсын Засгийн газар, Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөгжил шинэтгэлийн хорооны хооронд хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг гээд, тэгээд ийм 2 царигаар харилцан зөрж байгуулахаар санамж бичиг байгуулагдсан. Дараа нь би түрүүн хар харуулсан. 2022 онд “Эрдэнэс Тавантолгой” Мөн “Чайна Энержи” компаниудын хооронд ерөнхий хэлэлцээрүүд байгуулагдсан байгаа юм. Энэ хэлэлцээрүүд дээр ямар арга хэмжээ дурдсан бэ гэхээр ерөөсөө нүүрс тогтвортой, саяын 4 дүгээр заалт дээр байгаа тогтвортой худалдах, худалдан авах гэрээ байгуулах 20 сая тонн нүүрс жил болгон тогтвортой худалдаж авах ийм санамж бичиг болон ерөнхий хэлэлцээрээр ийм гэрээнүүд байгуулагдсан. Гол нь энэ асуудал дээр улс төрийн шийдвэр гаргаж Их Хурлын тогтоолоор баталгаажуулж байж, төрийн өмчит компани тогтоолыг хэрэгжүүлэе гэдэг энэ агуулгаар тогтоол 1 дүгээрт орж ирж байгаа.

2 дугаарт яагаад Хятадын талын компаниар гүйцэтгүүлэхээр асуудал яригдаж байна вэ. Яг хил дамнасан хэсэг дээрээ гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр хэд хэдэн зүйл байгаа нь 2 улсын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил хийгдэнэ. Энэ нэлээн их инженерийн нарийн төвөгшил ихтэй зургаар зурагдсан ийм төмөр зам баригдах байгаа. Дээр нь 2 улсын хилийн болон бусад байгууллагуудаас олон зөвшөөрлүүд гарч ирэх, нөгөө талдаа энэ 2 байгууламж юм уу, хилийнхээ 2 талд байгаа төмөр замын үндсэн бүтээц бол нэг л ийм бүрэлдэхүүн хэсгээс бүрэлдэх учиртай учраас БНХАУ-ын төрийн өмчит “Чайна Энержи” гэдэг компаниар бид нар гүйцэтгүүлэе гэдэг саналаа тавиад, айлын тал уг асуудлыг хүлээн зөвшөөрсөн. Төлбөрийн нөхцөлийн хувьд оффтейк хэрэглэхгүй. Бид нар борлуулсан нүүрснийхээ зардлаас буцааж эргэж боомтын төмөр зам дамнасан боомтын төмөр замын зардлыг бэлэн төлбөр тооцоо хийе гэдэг ийм асуудал

байгаа. Юутай холбоотой Зам, тээврийн яамнаас ТЭЗҮ-ийг боловсруулах тендер зарлаад, тендерт нь төмөр замын 2 дугаар товчоо гэдэг компанид шалгарсан юм байна лээ. Нээлттэй тендерт. Энэ компани зургийн ажил болон ТЭЗҮ боловсруулах ажил яг ид дундаа хийгдээд явж байгаа. 2 талдаа 1 компаниар хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтынхаа ТЭЗҮ-г нэг компаниар гүйцэтгүүлж байгаа гэдэг ийм шалтгаан нөхцөлүүд байгаа.

Л.Мөнхбаатар: Та бүгддээ зочин танилцуулъя. Гоёмсог компанийн ажилтан, албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс аз жаргал, сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе.

Нямбаатар сайд аа, төмөр замын хэлэлцээр яригдаж байгаа. Энэтэй холбоотой тогтоолын төсөл, үзэл баримтлал нь батлагдсан юм байна. Энэ дээр Зам, тээврийн хөгжлийн яамны оролцоо үзэл баримтлалыг нь хамтарч батлах ёстой байсан уу, үгүй юу. Ер нь эдний эдний үндсэн асуудал яригдаж байгаа юм байна шүү дээ. Энийг дараа нь асуултад хариулахдаа оруулаад хариулчхаарай. Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Би саяхан Монгол Улсын Ерөнхий сайдтай албан ёсны айлчлалд Хятадад яваад ирсэн. Энэ айлчлалын үеэр яригдсан зүйл. Энийгээ хурдан шуурхай хийнэ гэдэг бол зөв. Тийм учраас энэ тогтоолын төслийг би дэмжиж байгаа. Тэгэхдээ тогтоолыг яасан орой гарч байна вэ гэдэг дээр би хэд хэдэн зүйлийг хэлэхгүй бол болохгүй байна. 2014 онд Таван толгойгоос Гашуунсухайт хүртэл төмөр замыг тавих Их Хурлын тогтоолын төсөл гарсан. Тэрүүгээр нарийн царигаар тавихаар тогтоолын төсөл гарсан юм. Тэгээд 2020-оод он, 2019 онд Гашуунсухайтын төмөр зам хууль бусаар эхэлсэн. Өргөнөөр эхэлсэн. Бүх гэрээ нь

байгуулагдсан. Төмөр зам нь тавигдаж эхэлсэн. Оффтейк гэрээ нь хийгдсэн. Тэгээд хууль бус үйлдлийгээ Их Хурал руу оруулж ирж чадахгүй яасан бэ гэхээр Үндсэн хуулийн цэцээр шийдвэр гаргуулсан. Өөрөөр хэлбэл 2020 оны 5 сард Үндсэн хуулийн цэцээр аль хэдийн төмөр замаа бариад явж байх хугацаандаа Үндсэн хуулийн цэцээр дүгнэлт гаргуулж, энэ хууль бус зүйлээ нуусан. Үндсэн хуулийн цэц хууль бус зүйлд оролцсон. Хэрвээ 2014 онд нарийн царигаар тавигдсан төмөр зам ашиглалтад орчихсон бол 2020 онд эд коксожсон нүүрс 600 долларын үнэтэй байж байх үед бид нар ганцхан машинистаар, төмөр замаар тээврээ хийгээд бид нар хангалттай ашиг олох боломжтой байсан юм. Өнөөдөр тэр нүүрсний хулгай 40 их наяд төгрөг гэж яригдаж байгаа. Энэ хулгай хийх суурийг Үндсэн хуулийн цэц хийж өгсөн байхгүй юу. Үндсэн хуулийн цэц Монгол Улсын иргэдийн эсрэг, Монгол Улсын эсрэг шийдвэр гаргасан. Аж ахуйн ажил Үндсэн хуулийн цэц дээр ямар ч хамаа байхгүй. Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн асуудлыг ярихаас өөр аргагүй болж байна. Хэрвээ энэ төмөр зам нарийн царигаар баригдчихсан байсан бол аль хэдийн Монголчууд яг эд өндөр үнэтэй байсан энэ үед бид нар хангалттай орлого олох боломжтой байсан юм. Монгол Улсын эдийн засаг 4, 5 нугалах тэр боломжийг Үндсэн хуулийн цэц дарга нарынхаа даалгавраар төмөр зам нарийнаар тавихгүй гэдэг тэр хүний даалгавраар хийцгээсэн шүү дээ. Үндсэн хуулийн цэц дээр минь хөх тэнгэр байхгүй гэж ярьчихаад доороо бүх юмыг будилуулдаг ийм газар болж хувирсан шүү дээ. Монголын ард түмний эсрэг ажилласан шүү. Бид нар өнөөдрийн байдлаар нүүрс 140 доллар л болчихсон байж байна. Дэлхийн зах зээлийн ханин. Гэтэл 400-600 долларын хооронд 2 жил болсон шүү дээ. Ямар их алтан боломж вэ. Ямар их сайхан хөгжих тэр боломжийг Үндсэн хуулийн цэц яаж хууль бусаар хаав аа. Ямар гайтай газар вэ. Хууль бус хүмүүс тэр Үндсэн хуулийн

цэцтэйгээ байцаагаарай. Шударга хүмүүс ард түмэнтэйгээ байна.

Л.Мөнхбаатар: Үг хэллээ. Жигжидийн Батжаргал гишүүн асуултаа асууя.

Ж.Батжаргал: Тогтоолын төслийн ерөнхий агууламж юмыг бол дэмжмээр байгаа юм аа. Энэ урьд өмнө нь ард түмний хөрөнгөөр, янз бүрийн арга хэлбэрээр барьчихсан төмөр замаа эдийн засгийн үр өгөөжийг нь дээшлүүлэе гэвэл хил, холболт давалтынхаа асуудлыг бид шийдэх ёстой. Тэгэхгүй мухар төмөр зам 1,4 тэрбум доллароор барьчхаад ингээд хэвтүүлээд байдаг юм гэж таарахгүй. Тэгээд тэр үед анх юм хийхдээ яахаараа ТЭЗҮ, зураг, төсөв, бүх юм нь эцэслэгдээгүй юм хийчихсэн юм. Аль болохоор саяын нүүрстэй холбоотой, түүнийг тойрсон хулгай булхайтай холбоотой юмнуудыг Их Хурал ямарваа нэгэн шийдлээр хүлээн зөвшөөрч гэдэг юм уу өгөшүүлж таарахгүй ээ. Тэр ямар шалгуураараа гүйцэтгэгч нь шалгардаг ёстой юм, ямар байдлаар үүнийгээ бүтээн байгуулдаг мөнгөө гаргах ёстой юм тэр л шийдлийг нь зааж өгөх ёстой. Тийм учраас нүүрсний тоо яриад л, тийм гүйцэтгэгчээр хийлгэе гэж яриад л, тэгээд л хэн нэгэнд давуу байдал олгосон шийдвэр эндээс гаргах гэж оролдоод бол дэмий. Тэр явдаг зарчмаараа явмаар байна. Нүүрсээ зар. Биржийнхээ үнээр. Орж ирсэн орлогоосоо төмөр замынхаа холболтын бүтээн байгуулалт руу зарцуул. Ийм л чиглэл өгөх ёстой. Тэр гүйцэтгэгч компанийг худалдан авалтынхаа үйл ажиллагаатай уялдуулж шалгаруулдаг зарчмаараа хийсэн нь дээр байх. Энэ улсуудын хийсэн хулгай булхайг өгөшүүлж байгаа юм шиг адилтгаж үзэх боломжийг бий болгож байгаа юм шиг шийдэл Их Хурал гаргаж таарахгүй ээ. Тийм учраас улс үндэстний аюулгүй байдалтай холбоотой заяагдмал баялгийг хэрэгтэй газар нь үнэ цэнтэй хүргэж өгөхөд тээвэр логистикийн өөрийн өртгийг бууруулахтай

холбоотой, төмөр замын бүтээн байгуулалт холболтын асуудлыг маш шуурхай хийх ёстой. Үүнийг нь үзэл баримтлалынх нь хувьд бол дэмжиж байна. Явдаг арга хэлбэрийг нь зөв хийх ёстой гэж.

Дараа нь хүмүүсийн хөрөнгөөр баахан юм хийлгээд яваа улс. Тэр төмөр замын энэ 1955 оныхоо хэлэлцээр, гэрээ юманд их тодорхой оруулмаар байна. Одоо энэ Хангийнхаа асуудлыг тэр гэрээ, хэлцэлдээ тодотголдоо нэмэлт хийгээд холболтынхоо цэгийг тодорхой болгоод явмаар байна. Бичигтээ бас төмөр замын холболт хийе гээд л зүүн чиглэлийн босоо төмөр замын тухай ярьцаагаад байгаа. Одоо тэр хөрөнгө оруулалтынх нь ажил эхлэхээс өмнө энэ ерөнхий гэрээ хэлцэлд нь оруулдаг юмаа оруулаад, холболтын цэгээ тохироод, тэгээд энэ улсуудын хөрөнгийг татаж оруулмаар байна шүү дээ. Хүмүүсийн хөрөнгийг түрүүлж оруулчхаад холболтынх нь цэг юмнуудыг шийдээгүй, тэгээд үхмэл хөрөнгө хэлбэртэй байлгаад байдаг эс үгүй бол дунд нь нэг дамжин ачдаг цэг бий болгож үүсгээд байгаа явдал чинь ерөөсөө бид нарын бодлогын их том алдаа болж хувираад байна.

Баруун талд бас тийм босоо замын тухай яриад байгаа. Гэхдээ энэ олон замуудыг бодож хийх ёстой шүү. Нүүрсний хэрэглээ хэчнээн жил, ямар хэмжээний юм байгаад байгаа юм. Түүнийг бид нар мөнхийн хангах юм уу, үгүй юм уу. Энэ тэр юмнуудаа нэлээн зөв тооцож байж энэ олон урагшаа холболтын цэгүүдийг Их Хурлын түвшинд ярьж, тов тодорхой юмнуудыг нь бий болгож өгөх нь дээр байх гэсэн ийм л бодолтой байна. Миний хувьд. Тийм учраас тогтоол гаргая, гаргахдаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт байгаа юм уу. Үг хэллээ. Нанзадын Наранбаатар байхгүй байна. Батсуурь гишүүн асуултаа асууя.

Ж.Батсуурь: Энэ хилийн боомттой холбоотой, төмөр замтай холбоотой асуудал. Энэ холболтыг хийхэд ер нь хэдий хэмжээний хөрөнгө мөнгө орох юм бол. Төмөр замыг нь тавихад 1,4 тэрбум доллар гээд байдаг. Тэгээд миний ойлгож байгаагаар, та бүхний ярьж байгаагаар цаашаага өргөн царигийн төмөр зам орж ирэх, цаанаасаа нарийн царигийн төмөр зам оруулж ирж ингэж л холбогдох юм шиг байгаа юм. Тэгээд өмнө нь ийм зүйл яригддаг байсан юм. Үүний өндөржилт нь нийлэхгүй ээ. Хэдэн метрээр ч гэнэ үү, хэдэн километрээр ч гэнэ үү өндөр нам 2-оор орчихсон. Солбицол нь нийлэхгүй байгаа гэсэн. Энэ нөхцөл байдал ер нь ямар түвшинд явж байгаа вэ гэсэн 1 дүгээр асуулт.

Саналын хувьд бол энэ ер нь төр, бизнесийн нөхцөл байдал руу арай хэт орж байгаа юм биш байгаа. Ер нь нэг мэдэх нь Монголын дотоодын нийт бүтээгдэхүүний чинь бараг 70-аад хувийг хувийн хэвшлийнхэн үйлдвэрлээд, зах зээлийн дэг жаягтаа орж байсан ийм цаг хугацаа бас бий шүү дээ. Гэтэл өнөөдөр 70, 80 байтугай бараг 90-ээд хувийг нь төрийн өмчит компаниуд төсөв рүү орчихсон. Тэгээд үүнтэйгээ холбогдуулаад авлига, хээл хахууль чинь бүр замбараагаа алдлаа. Дэлхийн улс орнуудын 70, 80-д явж байсан одоо 30, 40 байраар ухраад ингээд явж байна. Тэгэхлээр авлигын үндэс чинь бол ерөөсөө төрийн өмч байгаа. Төрийн мөнгө уйлдаггүй, улсын мөнгө уйлдаггүй гэдэгтэй л холбоотой зүйл л дээ. Тэгээд нөгөө оффтейк гэрээ гээд байсан. Ил болголоо, болголоо гэсэн гол юмнуудаа ил болгоогүй байгаа л даа. Нуугаад аваад үлдчихсэн. Яг үүнтэйгээ адилхан хаалттай гэрээ гээд явж байсан бол яг нээлттэй гэрээгээр зарчим нь адилхан байгаа юм биш үү гэсэн ийм зүйлийг хэлээд байгаа юм. Ер нь ийм том том бүтээн байгуулалт ч бай, Монгол Улсыг өөд нь дээшлэх зүйлүүд бол хувийн хэвшлээ дэмжих, бизнесийн өөрийнх нь зарчмаар нь явуулах асуудал юм биш үү.

Тэгээд энэ асуултад хариулт аваад, тэгээд би дахиж тодруулж асууя гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт хариулъя.

С.Бямбацогт: Батсуурь гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт нь Их Хурлын дэд дарга бас үзэл баримтлалыг нь яагаад Зам, тээврийн хөгжлийн сайд батлалцаагүй юм бэ гэж байна. Энэ үед би Оросын Холбооны улсад томилолттой ажиллаж байсан. Улаанбаатар төмөр замын дүрмийн санг нэмэгдүүлэх 167 тэрбум төгрөгөөр, Улаанбаатар төмөр замын 200 гаруй тэрбум төгрөгийн өрийг барагдуулах, хүчин чадлаа нэмэгдүүлж 5 зүтгүүр нэмэх энэ асуудлуудыг Тээврийн сайдтай хэлэлцээр хийх ажилтай явж байсан учраас амжаагүй юм гэдгийг хэлчихье.

2 дугаарт нь 2004 онд 2 улсын Засгийн газар хооронд Замын-Үүд Эрээнээс гадна сая яригдаж байгаа Ганцмод-Гашуунсухайт, Шивээхүрэн, Сэхээ, Бичигт, Зүүн хатавч гэсэн боомтуудыг холбооё гэсэн 2004 онд хэлэлцээр хийсэн байдаг. Энэ хэлэлцээрийн дагуу үндсэндээ Хятадын талаас Шивээхүрэн, Сэхээ дээр төмөр зам ирчихсэн, Ганцмод дээр төмөр зам ирчихсэн, Зүүн хатавч дээр төмөр зам ирчихсэн ийм байдалтай байж байгаа юм. Монголын талаас төмөр зам тавина гэж ярьсан бол тавигдаагүй. Гашуунсухайт, Тавантолгойгоос Гашуунсухайтын чиглэлд төмөр зам барьж эхэлсэн. Харамсалтай нь олон жил улс төржөөд, нарийн байх ёстой, өргөн байх ёстой гэж хэлж байгаад барьсан. Барихдаа нөгөө Хятадын талтайгаа ойлголцоод холболтын цэгээ тохиролцоогүйгээс хил холболтын цэг нь зөрчсөн. Таны хэлж байгаа үнэн. 2 улсын төмөр зам хоёулаа 2 талдаа зөрчсөн. Дээрээс нь холбох гэхээр дахиад өндөржилт зөрчсөн ийм асуудал байгаа. Тэгэхээр үүнийг яаралтай холбож байж

үндсэндээ 2 улсын хооронд төмөр замаар 2 талдаа экспорт, импортын ачаа бараа орж гарах бололцоо боломж бүрдэх юм. Энийг бүрдүүлэхэд бид нар өнгөрсөн 2022 оны 8 сард санамж бичиг байгуулсан. Үүний дагуу сонгон шалгаруулалт явуулаад Хятадын төмөр замын 2 дугаар хүрээлэн ТЭЗҮ, зураг төслийг хийгээд эхэлсэн байгаа. Нийтдээ гол замынх нь урт нь 7км-ийн гаруй, дэлгэмэл уртаараа буюу салаа, салбар замтайгаа нийлэх юм бол 20-оод километр төмөр зам баригдана. ТЭЗҮ-ийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Энэ оны 10 сар гэхэд үндсэндээ зураг төсөл, ТЭЗҮ дуусчихна.

Бидний ойролцоо зүгээр баримжаалж тооцож байгаа, урьдчилсан тооцоо шүү. Энэ бол 300 орчим сая долларт баригдчих болов уу гэсэн баримжаатай байгаа. Энэ ирэх оны 1 дүгээр улиралд барилга, бүтээн байгуулалтын ажил эхэлнэ. Ингээд үндсэндээ хил өндөржилт нь зөрчихсөн, холболт нь зөрчихсөн энэ төмөр замыг бүтээн байгуулахад үндсэндээ тиймэрхүү өртөг зардалтай, иймэрхүү цаг хугацаа шаардах нь. Болж өгвөл 2 жилийн хугацаа гэж байгаа, болж өгвөл 1 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлэх байх.

Шивээхүрэнгийн чиглэлийн төмөр зам бол нарийн царигаар эхэлчихсэн явж байна. Энэ 10 сард бид нар холболтын асуудлаа шийдчих бололцоотой болно гэж харж байгаа. Бичигт, Зүүн хатавчийн ажил бол 7 сард эхэлнэ. Ингээд үндсэндээ 10 сар гэхэд дуусчихна. Ингээд үндсэндээ Хятад-Монголын хил холболтын төмөр замууд баригдах бололцоотой болно.

Ингэхийн тулд 1955 оны хэлэлцээрт өөрчлөлт орох ёстой. Энэ ажлыг маш яаралтай хийж байгаа. Ерөнхий сайдын айлчлалын хувиар нэлээд том түвшинд нэлээд ахиц дэвшил гарсан. Тийм болохоор маш ойрын хугацаанд энэ асуудлууд явна. Үүнтэй зэрэгцээд нөгөө Ханги, Мандалын төмөр зам. Монголын

талаас төмөр зам нь оччихсон, Хятадын талаас төмөр зам нь ирчихсэн. Одоо ганцхан 2 улсын Засгийн газрын хооронд хэлэлцээрээ байгуулаад, хооронд нь холбох л үлдсэн. Энд үндсэндээ 300, 400 метр, километр биш Ганцмод-Гашуунсухайт дээр л 7, 8км-ийн асуудалтай өндөрсөн том асуудал яригдаж байгаа болохоос бусад боомтууд дээр үндсэндээ 300, 400 метр төмөр зам бариад л үндсэндээ 2 улсын төмөр замууд нарийн царигаараа холбогдоно. Мөн өргөн царигаар холбогдоно. Өргөн, нарийн хоёулаа холбогдох нь ямар учиртай юм гэвэл яг Замын-Үүд-Эрээнтэй адилхан гээд ойлгочхоорой. Цаанаасаа орж ирж байгаа ачаа нарийнаар орж ирдэг, Монголоос гарч байгаа ачаа өргөнөөр гардаг. Ийм байдлаар 2 талдаа өргөн, нарийн төмөр замын хил холболтын төмөр замууд холбогдоно. Ийм байдлаар Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсын Засгийн газар бодлогоо гаргаад ажиллаж байна. Ер нь бол энэ оны төгсгөлөөр бүх зүйл маш тодорхой болчихсон, ажлууд үндсэндээ ганцхан төмөр замаар холбогддог байсан бол бид нар 5 төмөр замаар Хятад улстай холбогдох бололцоо бүрдэнэ.

Л.Мөнхбаатар: Асуултад нь хэн хариулах юм. Ажлын хэсэг хариулах юм уу. Нямбаатар сайд хариулах уу. Нямбаатар сайд хариулъя. Оффтейк гэрээтэй холбоотой асуулт асуугаад байна.

Х.Нямбаатар: Баярлалаа. Би зүгээр Бямбацогт сайдын хэлсэн дээр нэмээд хэлэхэд хил холболтын цэгт тохирчихсон. Монгол-Хятадын 703 дугаар хилийн тэр тэмдэгтээр нэвтэрч орно. Манай талаас өргөн царигаар орж ирнэ. Цаанаасаа наашаа нарийн царигаар орж ирнэ. Өөрөөр хэлбэл 2 талдаа өргөн нарийн царигтай байна гэсэн энэ барилга байгууламжууд баригдана. Бямбацогт сайд сая хэлсэн. Ойролцоогоор ирэх оны 1 дүгээр улиралд бид нар багтаагаад эхэлчихвэл 1,6

жилдээ багтааж бид нар барилга угсралтын ажлыг дуусгаад, төмөр замын тээвэрлэлт бүрэн явах боломж нөхцөл бүрдэнэ. Өртөг зардлын хувьд урьдчилж хэлэхэд хэцүү. Тэр ТЭЗҮ боловсруулж байгаа компанийн тухай тодорхойлно. Зүгээр би сая гишүүний асуулт, Батсуурь гишүүн ийм зүйл хэлж байна. Төрийн оролцоо хэт их байгаа юм биш үү гээд. Харин бид нар эсрэгээрээ энийг сая Ерөнхий сайдын айлчлалын бүрэлдэхүүнд орж явж, бид нар Хятадын талын төрийн өмчит компанитай ойлголцлоо хийж байж, энэ замыг ашиглалтад оруулж чадвал энэ зам нийтдээ өөрийнх нь суурилагдсан хүчин чадал ойролцоогоор 40 орчим сая тонн нүүрс жилдээ тээвэрлэж гаргах боломжтой юм. Үүний 20 орчим нь Хятадын талын төрийн өмчит компани худалдаа авалт хийж бид нар тогтвортой тээвэрлэлтээ хийе гэж байгаа юм. Үлдсэн дээр нь бусад хувийн хэвшилүүд ижил жигд нөхцөлөөр экспортоо хийх ийм боломж нөхцөлийг л бүрдүүлэх гэж Ерөнхий сайд сая айлчлалынхаа хүрээнд хамгийн том уулзалтуудыг энд хийсэн гэдгийг хэлье.

Би тэгээд та хэдэд нэг жишээ хэлэхэд, одоо бид нарын энэ гэрээ хийх гээд байгаа компани маань жилдээ 750-800 орчим сая тонн нүүрс өөрсдөө ухааж болон худалдаж авч борлуулдаг айл юм билээ. Тэгэхээр бид нар жилд 30 сая тонн гэвэл бид нарын 20 хэдэн жил олборлох юуг энэ айл бол жилдээ л олборлож борлуулдаг л ийм том худалдан авагч айл байна лээ. Тэгэхээр бид нар зах зээлийнх нь жишгээр энэ айлтай тогтвортой худалдан авалт хийе. Нэг том нөхцөлд тохирсон нь юу вэ гэхээр одоогийн байгаа Шивээхүрэн Гашуунсухайт-Ганцмод, Ханги, Бичигт дээр байгаа энэ квотоос гадна эднийтэй хийх нүүрсний хэлэлцээр бол энэ квотод гаргахгүйгээр анлимтэд байдлаар явагдана гэсэн ийм хэлэлцээр аман байдлаар тохироод байгаа. Энийгээ бид нар 8 сард баталгаажуулах ийм асуудал яригдаж байгаа. Ингээд бид нар үндсэндээ зарж

байгаа нүүрсээ 1 дахин илүү нэмэгдүүлж чадвал манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн тэр чинээгээрээ нэмэгдэх ийм л нөхцөл байдал бүрдэх гээд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Батсуурь гишүүн тодруулж асууя.

Ж.Батсуурь: Ерөнхий мэдээллүүдийг авлаа. 2 зүйл тодруулъя. Энэ гарч байгаа тогтоол оффтейк гэрээнээс ямар ялгаатай юм. 1 нь нууцын зэрэглэлтэй, 1 нь ил л болохоос ялгаагүй юм биш үү гэсэн ийм мэдрэмж төрж байна 1 дүгээрт.

2-т яг энэтэй холбоогүй ч гэсэн би Бямбацогт сайдыг байгаа дээр 1 зүйлийг асуучихъя гэж бодож байна. Нөгөө Тамсагаас нефтийн үйлдвэр рүү явах түүхий нефтийн шугам хоолойг хийнэ гээд ингээд зам тавиад эхэллээ. Энэ ямар эх үүсвэрээр тавиад эхэлчэв. Яг бодит тооцоо байна уу. Лав л улсын төсөв дээр яригдаагүй, зээл тусламж дээр яригдаагүй. Тэгсэн мөртөө Тамсагаас Матад, Сүхбаатар аймгийн нутгаар өмнө нь төмөр зам тавьж байгаа нь гээд баахан сэндийлээд жалга дов.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Та гүйцээгээд асуучих. 1 минутад багтаагаад. Батсуурь гишүүний микрофоныг өгье.

Ж.Батсуурь: Өмнө нь төмөр зам тавьж байгаа нь энэ гээд 2, 3 аймгийн нутаг дэвсгэр, хэчнээн сумыг ухаад баахан хөрс сэндийлээд хаячихсан. Одоо дахиад нефтийн хоолой тавих гэж байгаа гээд зам хусаад эхэлчихлээ. Тэгээд би нэг зүйлийг ойлгохгүй байгаа юм. Төсөв дээр яригдаагүй, зээл тусламж дээр яригдаагүй. Ямар эх үүсвэрээр ингээд энэ хоолойг тавина. Яг энэ хоолойгоор явна, үгүй бол төмөр замаар явна, авто тээврээр явна гэсэн үзэл баримтлал нь батлагдсан юм уу. Тэгээд шууд ямар үүрэг даалгавраар, ямар хэлэлцээрээр, ямар эх үүсвэрээр энэ ажил

эхэлчэв. Гэтэл нөгөө талдаа нефтийн үйлдвэр нь ажиллана, ажиллахгүй, бүтнэ, бүтэхгүй л гэсэн л юм яриад байх юм. Ингээд хээр талыг хэдэн 10 тэрбум доллароор сэндийчиж сэндийчиж төмөр зам ч үгүй, хоолой ч үгүй, авто зам ч үгүй нэг хачин юм болох юм биш байгаа гэсэн ийм эмзэглэл байна. Энд маш тодорхой хариулт өгөөч.

Л.Мөнхбаатар: Нямбаатар сайд хариулъя.

Х.Нямбаатар: Би эхнийх нь асуултад хариулъя. Нөгөө нууцалсан оффтейкээс юугаараа ялгаатай юм бэ.

1 дүгээрт энэ тогтоол дээр оффтейкээр ямар нэгэн төлбөр тооцоо хийхгүй гэдгийг тогтоолын төсөлд дурдсан байгаа.

2 дугаарт бид урд хэлэлцээр хийх явцдаа Хятадын талын төрийн өмчит компаниар цаад талдаа эднийх суурь бүтцийг эзэмшиж байгаа. Эднийх нийтдээ 4500 орчим километр ийм төмөр замын суурь бүтэц эзэмшиж байгаа юм байна лээ. Үүний үргэлжлэл болоод Ганцмодноос цаашаа. Тэгэхээр энэ компаниар бид нар хил холболтынхоо төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж хийлгээ гэдэг ийм зарчим барьж байгаа.

2 дугаарт инженерийн тэр зураг түвэгшилйн хувьд их өндөр 40 гаран метр өндөр тийм хос стакадан гүүр барина. Дараа нь хариуцлагын асуудал яригдахад хариуцлагатай туршилагатай компаниар нэгэнт гүйцэтгүүлээд, бид нар бэлэн төлбөр тооцоогоо гүйцэтгэлээр нь санхүү.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн. 2 дахь асуултад хариулах уу. Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Алтан ширээ дээр байгаа газрын тос боловсруулах

үйлдвэрээс Петрочайна гээд Дорнодын чиглэлд үндсэндээ газрын тос дамжуулах хоолойн ажил эхэлж байгаа юм байна лээ. Энэ ажлыг үндсэндээ Эрдэнэс Тавантолгой компаниас санхүүжүүлээд, оффтейк гэрээгээр Норинко гэж компани гүйцэтгэж байгаа гэсэн. Энэ хоолойн бүтээн байгуулалтын ажлыг барьж байгуулахад технологийн зам тавих шаардлагатай. Технологийн зам. Тэр зам хийгдэж байгаа. Бусдаар юу гэдэг юм Зам, тээврийн хөгжлийн яам, Монгол Улсын төсвөөс болон бусад гадна, дотнын зээл тусламжаас энэ замд ямар нэгэн хөрөнгө оруулж, санхүүжилт хийж байгаа зүйл байхгүй. Энэ бол Эрдэнэс Тавантолгой, Норинко компанийн хооронд байгуулагдсан гэрээний дагуу хийн тэр газрын тос зөөх хоолойн технологийн замыг барих ийм ажил бүтээн байгуулалт явагдаж байгаа. Зүгээр Засгийн газраас дараагийн ээлжид бид нар Сайнишандаас Баруунурт, Хөөтийн чиглэлд хөндлөн чиглэлийн төмөр зам бүтээн байгуулах ажлыг сонгон шалгаруулалтыг удахгүй зарлана. Энэ замаар үндсэндээ дахиад Бичигтийн.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Зочин танилцуулъя. Үндэсний аврах бригадын Ахмадын хорооны гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Эрхэм хүндэт аврагчид та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс сайн сайхан бүгдийг хүсэн ерөөе өө.

Борхүүгийн Дэлгэрсайхан гишүүн асуултаа асууя.

Б.Дэлгэрсайхан: Энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Энэ тогтоолын төслийг ер нь манай Их Хурлынхан маш сайн ойлгож байгаа байх гэж итгэж байна. Яагаад вэ гэхээр ер нь бид өмнөд хөрштэйгөө ярьж тохирсноо биелүүлдэггүй 10 хэдэн жил ингэж аль аль талдаа өөрсдийн буруу шийдвэрээс болоод ингээд хохирол амссан ийм байдлаас болоод саяын айлчлалаар

гацааг гаргалаа. Тийм учраас энэ гацаа гарсан дээр нь хурдан түргэн энэ тогтоолыг гаргаад, тэгээд зураг төсөл болоод ажлыг эхлүүлэхгүй бол бид нар ингээд цаашидаа бахь байдгаар яваад байх юм байна. Дээрээс нь бол сая манай Хууль зүйн сайд ярилаа. Үнэндээ бол “Чайна Энерджи” компанийн хувьд бол цаанаас барьж ирсэн зам дээрээ бараг манайхаас болж 10 хэдэн жил хохирсон. Дээрээс нь манайх чинь өөрөө хохирлыг нь амсаад явж байгаа учраас энийг хурдан түргэн шийдвэр гаргаад, тэгээд зураг төсөл болон бүтээн байгуулалтын ажлыг нь 1 жил, 1 жил 6 сар, 2 жил гэлгүй богино хугацаанд барих энэ асуудал дээр нэлээн шахаж ажиллах нь Засгийн газар энийг анхаарах байх гэж бодож байгаа юм. Ер нь Ганцмод-Гашуунсухайт 2-ыг аль болохоор хурдан холбож байж нүүрсний экспорт нэмэгдэнэ. Сая Нямбаатар гишүүн маш тодорхой ярьсан учраас энийг давтан яриад яах вэ. Тэгээд хамгийн гол зүйл бол манайхны өөрсдийн алдаа хэлсэндээ хүрдэггүйн улмаас өнөөдөр өөрсдөө ч хохироод, тэгээд урдаа ч ингээд хохирол үүсгээд, энийг удаан цаашаа үргэлжилбэл байдал нэлээн хэцүү болох юм байна. Тэгээд энэ тогтоолыг бүгдийг нь саяын тэр тогтоолд оруулж ирсэн концепц дээр нь дэмжээд явах нь зүйтэй байх гэж бодож байгаа юм.

2 дугаарт би сая Батсуурь гишүүний ярьж байгаа асуусан асуулт дээр нэмж ярих гээд байгаа юм юу гэхээр нефтийн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг явж байгаа юм уу, үгүй юм уу, босох юм уу, босохгүй юм уу гээд маш олон гишүүд ингээд улс төр хийдэг ээ. Энэ нефтийн үйлдвэр баригдаад сайн явж байгаа. Яагаад вэ гэхээр орон нутагт нь байдаг Энхтүвшин гишүүн бид 2-ын хувьд үргэлж энийг бүр байнга очих болгондоо үзэж хардаг. Энэ маш эрчимтэй явж байгаа. Та нарыг бас нэг би очиж үзээсэй гэж бодож байгаа юм. Тэгэхгүй нүдээр үзээгүй мөртөө тэр чинь худлаа юм гэнэ лээ энэ тэр гээд янз бүрийн худлаа, үнэн юм яриад. Саяхан

Бямбацогт сайдын хэлснээр хоолойн асуудал бол өнгөрсөн бараг сарын өмнө эхэлсэн. Тэгээд түрүүчийн 2 7 хоногийн өмнө очиход бараг 10 гаран километр хоолойгоо тавиад явж байна лээ. Бүр бодитой. Тийм учраас нефтийн хоолойг аль болохоор хурдан тавиулаад, тэгээд нефтийн үйлдвэрийн түүхий эд ирэх тусам нефтийн үйлдвэр ашиглалтад орох хугацаа улам нааших юм. Тийм учраас энэ дээр манай улс төрчид янз бүрийн санаатай санаагүй ийм ни ар битгий хийгээч. Бид бол яаж ийгээд нефтийн үйлдвэртэй болж тусгаар улс чинь өөрийн гэсэн нефттэй болох асуудал бол хамгийн чухал шүү гэдгийг албан ёсоор хэлье гэж бодсон юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Дэлгэрсайхан гишүүний хувьд асуулт байхгүй. Төслийг дэмжиж үг хэллээ. Одоо Энхтүвшин гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдана. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Энхтүвшин гишүүн асуултаа асууя.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Бид нар Таван толгойгоо, Тавантолгойн нүүрсээ эдийн засгийн эргэлтэд оруулъя л гэж бодож байгаа бол яаралтай энэ Ганцмод-Гашуун сухайтын төмөр замаа л яаралтай барьж ашиглалтад оруулах хэрэгтэй. Олон жил ярилаа шүү дээ. Төмөр зам барьж байгаа, барих гэж байгаа, холбох гэж байгаа гээд. Тийм учраас энийг яаралтай барьж, барьсан төмөр замаа эдийн засгийн эргэлтэд оруулах, одоо байж байгаа нүүрсээ их хэмжээгээр гадагшаа гаргах асуудал хамгийн чухал байгаа юм. Сүүлийн жилүүдэд яригдаж байгаа асуудал бол ерөөсөө л тээвэр логистик, дэд бүтэцтэй холбоотой асуудлыг л ярьж байгаа шүү дээ. Үнэхээр дэд бүтцээ яаралтай шийдээж чадах юм бол бид ахиу ашиг олох ийм бололцоо боломж байж байгаа юм. Тийм учраас энийг дэмжиж байгаа юм. Бид тэр гадна дотнын компани барина уу, дотоодын компани барина уу гээд энэ дээр нэг их цэц

булаацалдаад байх нь гол нь биш, яаралтай энийгээ л барьж дуусгах хэрэгтэй. Тийм учраас энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа юм.

2 дахь асуудал дээр энэ тогтоолын төслийн 4 дэх заалт байж байна л даа. Эрдэнэс Тавантолгой компани хооронд үе шаттай, жил бүр 20 сая тонн хүртэлх тонн нүүрсийг харилцан ашигтай, тогтвортой, зах зээлийн зарчимд нийцүүлэн урт хугацаанд худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрөх гээд ийм заалт байж байгаа юм. Үгүй ээ, заавал бид энийг 20 сая гэж ингэж квотлох шаардлага байна уу. 20-оос дээш гэдэг байдлаар оруулах хэрэгтэй шүү дээ. Өнөөдөр юу гэдэг юм Алтанбулагаас Замын-Үүд хүртэлх 1100 км дээр Улаанбаатар Төмөр зам 28 сая тонн ачааны эргэлт хийж байна шүү дээ. Тэгээд яахаараа бид нар 200 хэдэн километр төмөр зам дээрээ 20 сая хүртэл гэж оруулаад байгаа юм. 20 саяас дээш гэдэг байдлаар оруулаад явбал яасан юм. Тийм учраас энэ дээр бас тогтоолын төсөл боловсруулсан хүмүүс энэ дээр яагаад 20 сая хүртэл гэж оруулж байгаа юм бэ гэдэг дээр асууж байгаа юм. Энэ 20 сая гээд оруулчихаар чинь 5 сая ч байж болно, 10 сая ч байж болно, 15 сая ч байж болохоор ийм л заалт оруулж ирсэн байна шүү дээ. Тийм учраас энэ тогтоолын төсөл дээрээ өөрчлөлт оруулаад 20 саяас дээш гэдэг заалтыг оруулаад явах нь зөв байх гэсэн ийм зарчмын зөрүүтэй саналтай байж байна.

Тэгээд бид нар цаашидаа бол энэ төмөр замын бодлогын бичиг баримт батлагдсан байж байгаа. Бичигт, Хөөт, Чойбалсан Эрэнцав энэ төмөр замаа ч гэсэн яаралтай эхлүүлээд явах хэрэгтэй. Хэн барих нь чухал биш. Хэний хөрөнгө оруулалтаар барих нь чухал биш шүү дээ. Монгол Улс цаашидаа эдийн засгийн хувьд хүчирхэг байя л гэж бодож байгаа бол бид энэ төмөр зам, дэд бүтцийнхээ асуудлыг л яаралтай шийдэх хэрэгтэй.

Шийдсэний дараа бид нар юу гэдэг юм гаргаж байгаа түүхий эдээ их хэмжээгээр гаргаж, орлого олох ийм бололцоо боломж гарна шүү дээ л гэдгийг хэлмээр байна. Баярлалаа. Тэгээд 20 сая тоннд хүртэл гэдгийг 20 саяас дээш гэдэг үгээр сольж оруулах шаардлагатай байна. Зарчмын зөрүүтэй саналтай байна гэдгээ хэлмээр байна.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулах юм уу. Одоо бол хэлэлцэх эсэхийг ярьж байгаа. Одоо Байнгын хороо дээр анхны хэлэлцүүлгээ хийнэ. Энэ үед Энхтүвшин гишүүний саналыг Байнгын хороо руу хэлэлцээд явах боломжтой байна. Баагаагийн Баттөмөр гишүүн асуултаа асууя.

Б.Баттөмөр: Энэ тогтоолын төслийг дэмжиж байна. Дэмжиж явуулах ёстой. Бид нар чинь бодлоготой, бодлогогүй, янз бүрийн арга замаар, янз бүрийн үнэтэй, хэл амтай баахан төмөр зам бариад, мухар төмөр зам барьчихсан. Энийгээ тодорхой эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд энэ оруулж ирж байгаа холболтын асуудлыг шийдэхээс өөр арга зам бол байхгүй. Тэгээд энд хэд хэдэн асуулт байна л даа. Энэ Таван толгойн орд газар бол бас л дэлхийд ховор тооцогдох 6,4 тэрбум тонн нүүрсний нөөцтэй ийм хосгүй орд. Харамсалтай нь Монголчууд энийг маш их олон хуваагаад, 4, 5 хуваагаад ашиглаж байгаа учраас энэ дунд тэр хулгай нүүрлэдэг, тэгээд тэр цаашаагаа нөгөө удирдлага, зохион байгуулалт байхгүй, нэгдсэн тийм бодлого, төлөвлөлт байхгүй, тэгээд үнэ дээрээ нэгдсэн бодлого байдаггүй, дур дураараа хийгддэг ийм л замбараагүй байдал явчихсан л даа. Тэгээд энд хамгийн ноцтой нэг асуудал юу вэ гэхээр энэ ордын тэр 3, 4 дэх үе гэж байгаа шүү дээ. Хамгийн чанар сайтай, жинхэнэ яг цэвэр коксжих. Энийг сурталчилж ашиглаад бараг 90-ээд хувийг нь ашиглаад хаячихсан гэж байгаа шүү дээ. 92 хувийг нь. Үгүй ээ, тэгээд энэ чинь ер нь цаашидаа тэгээд энэ 92 хувийг яаж,

ямар үнээр гэхээр нөгөө л аман дээр нь нэг хэсгийг нь аман дээр нь тэгээд 60, 62, 66 доллароор, 1 хэсгийг нь нааш цааш нь зувчуулж эрчим хүчний нүүрс гээд ингээд хулгайгаар гаргачихсан явж байгаа шүү дээ. Үгүй ээ, ер нь тэгээд Тавантолгойн орд маань цаашидаа эдийн засгийн үр ашиг нь ер нь ямар байдаг юм бэ. Энэ дээр ер нь тооцоо судалгаа байна уу. Сорчлоод авчихсан 92 хувийг нь ашиглачихсан. Одоо тэгээд энэ ингээд цаашаа нэг эрчим хүчний нүүрс, хагас коксжих, зөөлөн энээ тэр гээд нэг тийм хэсэг нь л үлдэж байгаа юм байна л даа. Тэгээд ер нь яг ийм хагас коксжих, зөөлөн эрчим хүчний нүүрсний цаашидын хэрэглээ, чиг хандлага дээр ер нь ямар тооцоо судалгаа байна гэсэн эхний асуулт байна. Энэ бол яагаад ингэж асууж байна гэхээр барьж байгаа төмөр зам энэ их хэмжээний хөрөнгө гарч байгаатай холбогдуулаад аливаа зүйл бол дандаа эдийн засгийн тооцоотой хийгдэх ёстой шүү дээ. Нэг дэх асуудал ийм юугаар асууж байгаа юм.

2 дахь нь юу гэхээр яг шилжүүлж ачих байгууламжийг барихад яг ойролцоогоор хэд орчим сая долларын хөрөнгө орох вэ. Ямар нэгэн тоогүйгээр энийг хийж болохгүй шүү дээ. Зүгээр миний сонсож байснаар бол 160 орчим гэж сонсож байсан, 300 орчим сая доллар шаардлагатай гэж сонсож байсан. Хэрвээ 300 орчим сая доллар гэж тооцох юм бол энийг ямар юунаас хийх юм бэ. Энд оффтейк гэрээ хийхгүй. Бараа солилцоогоор хийхгүй гэж байгаа юм. Тэгээд энэ мөнгийг яаж гаргахаар тооцож байгаа юм бэ гэсэн ийм асуултуудад хариулт авъя.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишгээгийн Нямбаатар хариулъя.

Х.Нямбаатар: Би Эрдэнэс Тавантолгойн тэр уулын ажлын төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа эсэх талаар би бол мэдээлэл өгөхөд зохимжгүй байх. Энэний дараа Эрдэнэс

Тавантолгой компанийг төлөөлсөн удирдлагуудаас нь энэ талаар хариулт өгөх байх. Зүгээр нэг үнэн гэвэл яг Баттөмөр гишүүний хэлсэн үнэн. Энэ юу вэ гэвэл энэ 12 жилийн хугацаанд Эрдэнэс Тавантолгой 100 сая тонн нүүрс борлуулаад байгаа. Үүнийхээ 92 хувийг нь буюу 92 сая тонныг нь нөгөө сайн чанарын коксжих нүүрсээ зарсан. Үлдсэн 8 орчим хувийг нь эрчим хүчний нүүрс болон хагас исэлдсэн нүүрснүүдээ зарсан. Өөрөөр хэлбэл энэ нь нэг талаасаа харах юм бол бид нар энэ ордоо сорчилж ашиглаж байна гэдэг ийм дүгнэлттэй би бол Их Хурлын гишүүний хувьд санал нийлж байна. Үнийн хувьд юу гэж хэлэх гэж байна вэ гэвэл Баттөмөр гишүүн ээ, энэ юу байгаа юм. Одоо энэ бид нарын тогтоолоор орж байгаа юмны нэг агуулга нь ерөөсөө нүүрсээ 20 сая тонн нүүрс гэдэг бол хольж зарна л гэсэн агуулга орж байгаа юм. Өөрөөр хэлбэл эрчим хүчний нүүрс зарна, нөгөө Сэми коксоо ч зарна, коксоо ч зарна. Ингэхдээ зах зээлийнх нь бөөний том гэрээ хийж байгаа. Ингэхдээ нөгөө нэг аль Хөрөнгийн биржийн үнэ Бенч марк тогтоож нарийвчилсан гэрээг 8 дугаар сард байгууль л гэсэн санаа хийж байгаа юм.

2 дугаарт би Их Хурлын гишүүддээ хэлэхэд яагаад Хятадын талын “Чайна Энерджи” компаниар төмөр замын хил холболтыг бүгдийг нь гүйцээлгэх гээд байна вэ гэвэл энэ өөрөө 2 талдаа баригдаж байгаа байгууламж хэдий ч нийлж нэг байгууламж болно. 2 талдаа хилийн болон бусад тусгай байгууллагуудаас олон төрлийн зөвшөөрлүүд шаардагдана. Худалдан авах ажиллагааны хүндрэл, түвэгшилүүд гарна. Хамгийн гол нь манайд ийм 40 метр хос гүүр төмөр замын даацын гүүр барьж байсан туршилагатай, ийм туршилага дутна л гэсэн санаа байгаа. Тийм учраас хариуцлагаа ч нөгөө талдаа үүрэг. Бид нар бол зөвхөн төлбөрөө Тавантолгойн борлуулалтын орлогоос гүйцэтгэлийнх нь дүнгээр барилга угсралтынх нь дүнг төлнө. Энэ нь хилийн 0 цэгээс наашаа манай нөгөө тавигдсан

төмөр замын төгсгөл хүртэлх энэ хоорондох зардлаа л манайх хариуцна л гэж байгаа юм. Эдийн засгийн үр өгөөж тооцооллын хувьд юу гэж үзэж байгаа вэ гэвэл Тавантолгой төмөр замын ТЭЗҮ-ээр 40-50 сая тонн нүүрс жилдээ хил дамнасан төмөр замаар барина, тээвэрлэнэ гэсэн ийм ТЭЗҮ-тэй. Одоогоор бид нар энэ мухар зам дээрээ ийм хэмжээний ачаалал авч чадаагүй явж байгаа. Цаашид энэ холболт хийгдээд богино хугацаанд хийж дуусгаж чадсанаар манай экспортын орлогод тодорхой хэмжээнд өөрчлөлт гарна. Экспортын биет хэмжээнд тодорхой хэмжээний өөрчлөлтүүд гарна гэдэг ийм тооцооллыг манай Эрдэнэс Тавантолгой болон бусад ажлын хэсэгт орсон хүмүүсээс тооцооллуудыг гаргаж ирсэн. Мэдээж хэрэг та өөрөө эдийн засагч хүний хувьд мэдэж байгаа. Автомашинаар тээвэрлэх тээвэрлэлтийн өртөг, төмөр замаар тээвэрлэх тээвэрлэлтийн өртөг 2-ын хооронд бол тэнгэр газар шиг зөрөө байгаа. Ингээд ирэхээр манай нүүрсний Хятадын зах зээл дээрх өрсөлдөх чадвар үнийн хувьд өрсөлдөх чадвар маань эргээд нэмэгдэнэ гэдэг ийм олон зүйлүүдийг харж яаралтай энэ ажлыг дуусгая. Алийн болгон олон жил Хятадын талдаа ч тэр 8 жил гаруй, манай талдаа ингээд үндсэндээ 1 жил гаруй төмөр замаа барьчхаад, хил дамнасан төмөр замаа байгуулж чадалгүй, энэ төмөр замынхаа үр өгөөжийг харж чадахгүй байгаа явдал нь нэл нэг талдаа эмгэнэлтэй. Тийм учраас яаралтай барьж байгуулах 2 талын улс төрийн тохиролцоонууд сая урд хийгдсэн. Энэ нь үр өгөөжтэй байх талаасаа.../минут дуусав/

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу. Алга байна. Санал хураалт явуулъя. Байнгын хорооны саналаар “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний

тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураая. Санал хураалт. 65,4 хувиар санал дэмжигдлээ.

Төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

12.43 цаг.

Дараагийнхаа асуудлаар явъя. “Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагааг хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье ээ.

Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг танилцуулъя. Таныг индэрт урьж байна.

М.Оюунчимэг: Улсын Их Хурлын дарга, дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатар нарын 19 гишүүнээс 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ. Төсөл санаачлагч нь төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компаниуд ялангуяа төрийн өмчит “Эрдэнэс Тавантолгой” ХК, орон нутгийн өмчийн оролцоотой “Таван толгой” ХК-уудад гарсан Монгол Улсад хохирол учруулсан байж болзошгүй гэмт хэргийн шинжтэй асуудлуудыг тодорхой болгох, хууль хяналтын байгууллагуудад

шалгагдаж байгаа нүүрсний асуудалтай холбоотой хэргүүдийн мөрдөн байцаах ажиллагааг хугацаа алдахгүй яаралтай явуулахад Улсын Их Хурлын зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах шаардлагатай байгаа тул үүнтэй холбогдуулан Хянан шалгах түр хороог байгуулж, нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах, нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах зорилгоор уг тогтоолын төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явууллаа.

Хэлэлцүүлгийн үеэр Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг түр хорооны бүрэлдэхүүнийг сонгохдоо анхаарах саналыг хэлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүнд баярлалаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух, үг хэлэх гишүүн байна уу.

Ганбаатар гишүүнээр тасаллаа. Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асаая.

Г.Ганболд: Үгүй ээ, би дахиад түр хороо байгуулж байгааг бүр ойлгохоо болилоо. Дуугүй яваад байхаар ер нь дуугүй байгаа хүмүүсээ дээрэлхдэг ийм хандлага Их Хурлын удирдлагуудаас ер нь гардаг болчихлоо шүү. Үгүй ээ, бид нар чинь Нүүрсний түр хороо гэж түр хороо байгуулаад бүтэн жил ажиллаад, сонсгол зохион байгуулъя гээд өчнөөн удаа хүсэлт өгсөн шүү дээ. Тэгээд яагаад хийлгэхгүй байж байгаад хугацаа нь дууссан гэж татан буулгаад, дахиад түр хороо байгуулахаар болж байгаа юм. Үгүй ээ, ядаж би тайлангаа тавих гээд сууж байна шүү дээ. Тайлангаа эхлээд, өмнөх түр хорооныхоо тайланг сонссоны дараа дараагийн түр хороо байгуулах эсэхээ ярьдаггүй юм уу. Эхлээд ядаж та нар тайлангаа сонс л доо. Дарааллыг нь ядаж эхэнд нь оруулаад, тайлан дээрээ юу ярихыг нь сонсож байж үнэхээр муу ажилласан бол та нар татан буулгаж байгаад дараагийнх нь түр хороог байгуул л даа. Тэгээд ийм дарааллын хувьд ч гэсэн ингээд яваад байх юм. Их Хурлаас ажлын хэсэг байгуулсан. Би ажлын хэсэгт нь орсон. Сонсгол зохион байгуулах ажлын хэсэг сонсгол зохион байгуулах ямар ч боломжгүй гээд би гарын үсэг зураагүй. Гэтэл тухайн ажлын хэсэг Баттөмөрийн Энхбаяр эд нар ямар шийдвэр гаргасан гэхээр танай түр хороо хугацаа нь дууссан 1 дүгээрт. 2 дугаарт танай түр хороо бол нүүрсний хулгайн түр хороо биш, хил боомтын асуудлаар байгуулагдсан түр хороо гэж ярьж байгаа байхгүй юу. Үгүй ээ, өмнөх түр хороо чинь яг энэ уул уурхайн салбарт төр болон хувийн хэвшлийнхний нүүрс экспортлохтой холбоотой гэрээ, эрх зүй, үнийн зохицуулалт, нүүрсний тээвэр логистикийн үйл ажиллагаа, хил боомтын асуудал гээд бүх асуудлууд нь энэ өмнөх түр хорооны шалгалтын ажилд, тусгай шалгалтын сэдвийн хүрээнд бол бүгд орчихсон зүйл ээ. Гэтэл энийг байхгүй гээд, тэгээд хугацаа нь

дууссан гэдэг байдлаар энэ түр хороог татан буулгаад, дахиж түр хороо байгуулж байгаад би үнэхээр хардах, нөгөө талаасаа гомдох сэтгэл төрж байгаа юм. Яагаад гэхээр бид нар энэ сонсголоо 4 сарын 10, 11, 12-ны өдрүүдэд хийнэ гээд нийтэд зарлачихсан байсан чинь боломжгүй шүү гэдэг байдлаар ингээд зогсоосон шүү дээ. Тэгээд дахиж хийе гээд удаа дараа бид нар хүсэлтүүдээ тавьсан шүү дээ. Тэгээд ийм байдлаар ингээд яваад байж болох юм уу. Энэ зүйлүүдийг ярихгүй бол өмнөх түр хорооны 13 гишүүний бүтэн жилийн хөдөлмөр, дээр нь 5 хянан шалгагч, 5 шинжээч томилоод өчнөөн олон асуудлуудаар оффтейк гэрээнүүд, төрийн өмчит компаниудын худалдан авалттай холбоотой гэрээнүүд, нүүрсний бодит хулгайчийн асуудлаар бүтэн жил ажилласан шүү дээ. Тэгээд ядаж дарааллын хувьд нь эхлээд тайланг нь сонсчихоод дараагийн энэ асуудалд оруул л даа.

Л.Мөнхбаатар: Нүүрсний чиглэлээр байгуулагдсан Гочоогийн Ганболд гишүүнээр ахлуулсан түр хороо бол олон ажлуудыг хийсэн. Холбогдох мэргэжилтнүүдийн хамтаар нэлээн их ажилласан юм байгаа юм. Энэ тайланг нь сонсож байж энийг хэлэлцэх нь зарчмын зөв байна. Тийм учраас хэлэлцүүлгийг хойшлууллаа.

Түр хойшлуулаад Ганболд гишүүний түр хорооны тайланг сонсчихъё. Ингээд ийм дарааллаар дараалалд өөрчлөлт орууллаа шүү.

12.50 цаг

Ганболд гишүүн одоохон байж байгаарай.

Дараагийн асуудалд оръё. Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны тайланг сонсоно.

Тайланг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Гочоогийн Ганболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Ганболд: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.3, 34 дүгээр зүйлийн 34.2, 34.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор Хянан шалгах түр хороог байгуулж, хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хянан шалгалтын ажлыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хороо нь хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс тээвэрлэх, нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох ажлыг Монгол Улсын Их Хурлын 31 дүгээр тогтоолоор тогтоосон дараах чиглэлээр зохион байгууллаа. Үүнд:

Хилийн боомтуудаар нүүрс нэвтрүүлж байгаа ажлыг газар дээр нь танилцах, хил боомтын ажилд оролцож байгаа мэргэжлийн хяналт, гааль, хил хамгаалах, цагдаа, хилийн боомтын үндэсний зөвлөлийн ажлын уялдаа холбоо, мэдээ, мэдээлэл солилцож байгаа явц, Гаалийн хяналтын бүсийн зохион байгуулалт, боомтод үйл ажиллагаа явуулж байгаа ажн ахуйн нэгжийн үйл ажиллагаа, нүүрсний тээвэр логистикийн үйл ажиллагаа, бүртгэл хяналт, экспортод гаргаж байгаа нүүрсний гаалийн бүрдүүлэлт, тээврийн хэрэгслийн бүртгэл, уул уурхайн салбарт төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн нүүрс экспортлохтой холбоотой гэрээ, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн худалдааны үнэ тарифын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт. Энэ хүрээнд түр хорооны бүрэн эрхийн хүрээнд 5 шинжээч, 5 хянан

шалгагчийг томилон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Түр хороо нийт 6 удаа хуралдаж, хорооны үйл ажиллагаа, зохион байгуулалттай холбоотой 10 тогтоолыг баталсан. 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр түр хороо Ховд аймгийн хилийн Булган боомт, Баян-Өлгийн Цагааннуур чөлөөт бүс, 2022 оны 10-12 дугаар сард Өмнөговь аймгийн Гашиунсухайт, Дорноговь аймгийн Ханги боомтын үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан.

Хянан шалгах түр хорооноос тайлант хугацаанд нийт 77 албан бичгийг холбогдох газруудад хүргүүлж, 45 албан бичиг, ирүүлсэн материалтай танилцсан. Нотлох баримт цуглуулах нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, тэмдэглэл үйлдэж, баримт цуглуулсан болно.

Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооны 2023 оны 11 дүгээр тогтоолоор түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын товыг баталж, 2023 оны 4 дүгээр сарын 10, 11, 12-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэхээр олон нийтэд зарлан бэлтгэл хангасан. Гэвч сонсголд гэрчээр дуудагдахаар товлосон 100 гаруй этгээдийн 50 орчим хувь нь Авлигатай тэмцэх газар болон цагдаагийн байгууллагад нэгэнт шалгуулж, гол гэрчүүдийн хувьд таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нь Түр хорооны сонсголыг зохион байгуулахад хүндрэлтэй нөхцөлийг бий болгосон.

Мөрдөн байцаах ажиллагааны нууцыг хамгаалах, үр дүнг дээшлүүлэх шаардлагаар Авлигатай тэмцэх газраас 2023 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 06/5464 дугаартай албан тоотоор түр хорооны сонсголыг хойшлуулах хүсэлт тавьсныг анхааран үзэж, сонсголыг хойшлуулах шийдвэр гаргасан болно.

Нэг.Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн талаар:

Нүүрсний мэдээллийг Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Монгол Улсаас импортлосон нүүрсний тоо хэмжээг гаргадаг систем Бүгд Найрамдах Хятад Ард Улсын SXCoal нүүрсний албан ёсны тоон мэдээлэл, Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын тоон мэдээллүүдийг ашигласан болно. Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу экспортод гаргаж буй нүүрсний болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Монгол Улсаас импортлож буй чулуун нүүрсний тоо хэмжээг 2008-2022 онд дараах байдлаар гаргасан болно. 2008-2022 онд Монгол Улс Хятадын Гаалийн ерөнхий газрын импортын мэдээг зэрэгцүүлэн үзэхэд 6,9 сая тонны зөрүүтэй байна. Үүнээс Түр хорооны хяналт шалгалтын хамрах хүрээнд 2018-2022 онд Монгол Улс Хятадын Гаалийн ерөнхий газрын экспорт, импортын мэдээг зэрэгцүүлж үзэхэд 3,2 сая тонны зөрүү гарсан гэж шинжээчдийн дүгнэлтэд гарсан болно.

Уг мэдээллийг баталгаажуулах зорилгоор Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос Гаалийн ерөнхий газрын даргад “Гашиунсухайтын боомтод ажиллаж байгаа нүүрс ачиж, буулгах талбайд 2018-2022 оны хооронд экспортлогдсон нүүрсийг шалгах” хүсэлт гаргасны дагуу ажлын хэсэг томилон, шалгалтын ажиллагааг зохион байгуулж Эрдэнэс Тавантолгой компани, Тавантолгой компанийн нүүрс худалдах, худалдан авах 381 гэрээгээр 121,6 сая тонн нүүрс борлуулах гэрээ бүрээр гаалийн талбайд тулгалт хийж шинжилсэн.

“Эрдэнэс Тавантолгой” компаниас 36, Тавантолгой компанийн 10 нийт, 46 гэрээгээр 31,8 сая тонн нүүрс худалдан авах гэрээ байгуулж, уурхайгаас 16 сая тонн нүүрс буусан байна. “Энгүүнболор хуяг” компанийн гаалийн хяналтын талбайд 4,1 сая тонн

нүүрс буусан боловч үүнээс 3,5 сая тонн нүүрсэнд гаалийн бүрдүүлэлт хийж экспортлогдсон нь 0,6 сая тонн нүүрс зөвхөн нэг гаалийн талбайгаас дутуу бүрдүүлэлт хийгдсэн.

“Ханбогд инженеринг” компанийн гаалийн хяналтын талбайд 1,9 сая тонн нүүрс буусан. Үүнээс 1,4 сая тонн нүүрс гаалийн бүрдүүлэлт хийж, 0,5 сая тонн нүүрс гаалийн дутуу бүрдүүлэлт хийсэн байна.

Бусад талбайд 8,5 сая тонн нүүрс бууж, 10,5 сая тонн нүүрс гаалийн бүрдүүлэлт хийж, 2 сая тонн нүүрс эх үүсвэргүй гарсан байна. Энэ тоо баримтыг гаалийн байгууллагын ажлын хэсэг гарган баталгаажуулсан бөгөөд зөвхөн 2 нүүрс ачиж, буулгах талбайд шалгалт хийхэд 1,1 сая тонн нүүрс дутуу байгаа нь татвараас зайлсхийсэн, бусад талбайгаас 2 сая тонн нүүрс илүү бүрдүүлэлт хийж гаргасан нь эх үүсвэргүй буюу уурхайгаас алдагдсан нүүрс гэж дүгнэсэн шинжээчийн дүгнэлтүүд гарсан болно.

Шалгалтын хүрээнд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэгэн иргэн гадаадын хөрөнгө оруулалттай “Качфлов Энержи” компанийг байгуулан, Гашуунсухайт боомтод охин компани байгуулж, нүүрс ачиж, буулгах талбайн үйл ажиллагаа эрхэлдэг. “Энгүүнболор хуяг” компани, “Говийн мөнгөн жолоо” нүүрс тээврийн үйл ажиллагаа явуулдаг “Камелнис ложистик” компани дээр 59, “Качнес” компани дээр 126, “Төмөр туурай” компани дээр 102, дээр “Адали Инк” компани дээр 102” “Силвер Титан Интернэшнл” компани дээр 128, нийт зөвхөн нэг компани 517 автомашинаар “Эрдэнэс Тавантолгой” компанитай 2019 онд 4, 2020 онд 2, нийт 6 гэрээг хийж, өөрийн гэрээгээр өөрсдийн тээврээр, өөрсдийн нүүрс ачиж, буулгах талбайг ашиглан нүүрс гаргасан байна.

Гаалийн 2022 оны шалгалтаар илэрсэн Гашуунсухайт боомтоор нэвтрэхдээ гаалийн хилээр нэвтэрсэн тээврийн хэрэгслийн бүртгэлд бүртгэгдээгүй 22664 бичлэг буюу 12189 тээврийн хэрэгслийн бүртгэлээс зөвхөн саяын миний дурдсан “Качфлов” компанийн охин компанийн 517 автомашины дугаарыг шалгуулаад байна.

Уг мэдээллээс харахад гаднын хөрөнгө оруулалт нэрийн доор нэг компани гаалийн баталгаат талбай, өөрийн 517 автомашин, их хэмжээний нүүрсийг гаалийн байцаагчидтай хуйвалдан гаргах боломжийг бүрдүүлсэн байна гэж дүгнэхээр байна.

Зөвхөн уг компанийн тээврийн хэрэгсэл 2021 оны 7 дугаар сарын 15-ны өдөр 71 тээврийн хэрэгсэл бүртгэгдээгүй хоосноор хил нэвтэрсэн нь тогтоогдсон болно.

Хоёр.Нүүрсний ангиллын талаар:

Нүүрсний ангилал шинжлэх лабораторийн дүнгийн зөрүү байгаа нь сайн чанарын нүүрсийг үнэгүйдүүлэх эрсдэл өндөр байгааг шалгалтын дүнгээс харуулж байгаа юм. 2008 оноос хойш 7 сая тонн нүүрсийг чанаргүй буюу эрчим хүчний нүүрс нэрийн доор 9-18 доллароор борлуулсан нь Монгол Улсад асар их хэмжээний хохирол учруулсан байх магадлалтай байна.

Шалгалтын хүрээнд Тавантолгой компанийн өмнөх дээжид хийсэн шинжилгээний хариуг өөр лабораторид шинжлүүлэхэд энэ дүнгийн зөрүү нь батлагдаж байгаа юм. Эдгээр зөрчлүүд гарсан нь дараах шалтгаантай байна гэж үзэж байна.

Гаалийн ерөнхий газраас өөрийн дотоод хяналтын шугамаар илрүүлж Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газарт шилжүүлсэн зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй мэдээллийн зүйлчлэлийг нь өөрчлөн дарж

байгаад хэрэгсэхгүй болгодог нь нүүрсний хулгай хавтгайрч, үүний төлөө хариуцлага хүлээдэггүй гэсэн ойлголтыг бий болгоход тэр үеийн Монгол Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газрын үйл ажиллагаа хариуцаж байсан албан тушаалтнуудтай шууд холбоотой гэж дүгнэхээр байна.

2. Нууцад хамруулсан гэрээний талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор улсын нууцаас гаргасныг доорх хүснэгтэд дурдсан 9 гэрээ, түүнтэй холбоотой материалыг судалж танилцан, дүгнэлт гаргасан бөгөөд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эрдэнэс Тавантолгой компанийн эрх бүхий албан тушаалтнуудаас үүнээс өөр нууцлагдан үлдсэн гэрээ байхгүй тухай мэдээллийг эш үндэс болгож, гэрээнүүдэд шинжилгээ хийж, хэрэгжилтийг тооцон гаргасан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 449 дүгээр тогтоолоор нууцаас гаргаж Улсын Их Хурлын түр хороонд ишлжүүлсэн 9 гэрээнээс Тавантолгой-Гацуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлтэй холбоотой 2, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам төсөлтэй холбоотой 2, Богд Хаан Төмөр замын төсөлтэй холбоотой 3, усны болон далд уурхай төслийн тус бүр 1 гэрээ байна.

Шалгалтын явцад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Чалко”, “Норинко” компанитай холбоотой 2 гэрээг ил болгож, олон нийтэд дэлгэх боломжгүй байна. Энэ нь гэрээ хийхдээ аль нэг талын зөвшөөрөлгүйгээр гэрээг ил болговол их хэмжээний торгууль төлөх заалтыг тусгасан нь хүндрэл учруулж байгаа болно.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн талаар

Төмөр зам нь Монгол Улсын стандартаар 3 дугаар зэрэглэлийн төмөр зам бөгөөд гол замын урт нь 416,1км, дэлгэмэл урт нь 486,6км. Төслийн нийт өртөг 1 их наяд 392,2 тэрбум төгрөг буюу 488,5 сая долларыг “Эрдэнэс Тавантолгой” компаниас мөнгөн хөрөнгөөр ишлжүүлсэн компанийн санхүүгийн байдал болон 1072 хувьцааны ноогдол ашиг хуваарилах боломжид сөргөөр нөлөөлсөн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажлыг “Монголын Төмөр зам” төрийн өмчит компани, Зэвсэгт хүчний жанжин штаб, “Улаанбаатар төмөр зам” ХНН байгууллагууд ерөнхий гүйцэтгэгчээр ажиллаж, нийт 200 орчим компани байгууллага, хувь хүн туслан гүйцэтгэгчээр ажилласан байна.

Уг төслийг хэрэгжүүлэхэд гарсан зөрчлүүдийн талаар.

Тавантолгой төмөр зам тусгайлан хийгдсэн ТЭЗҮ-гүйгээр ажлыг эхлүүлсэн, Зэвсэгт хүчний жанжин штабаар ажлыг гүйцэтгүүлэхээр нууцад авсан боловч Зэвсэгт хүчний анги нэгтгэлүүд нийт ажлын 7 орчим хувийг хийж гүйцэтгэсэн. Нийт 96 гэрээний 81-ийг аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлсэн. Тухайн аж ахуйн нэгжүүд төмөр зам барих тусгай зөвшөөрөлгүй байсан бөгөөд нөхөн тусгай зөвшөөрлийг олгосон. Уг төслийг гүйцэтгэх зорилгоор 60 орчим тэрбум төгрөгийн машин техник худалдан авсан боловч цаашид яаж ашиглах нь тодорхойгүй.

Ажлын хэсгийн хуралдаанууд тухайн үеийн Ерөнхийлөгчийн албан өрөөнд хуралдаж шийдвэр гаргадаг байсан нь протоколуудаас харагдаж байгаа юм. Төслийг гүйцэтгэсэн Зэвсэгт хүчний жанжин штаб, Улаанбаатар Төмөр зам ХНН нь нэмэгдсэн өртгийн албан татвар төлдөггүй байсан нь

туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учруулсан.

Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг яаран барьсан нь эдийн засгийн хувьд ач холбогдол бага байгаа нь ашиглалтад орсноос хойш 2 жилд хийгдэж байгаад тээвэрлэлт хийгдээгүйгээс харагдаж байна. Улаанбаатар төмөр замын ачаалал их, 100 хувь ачаалалтай байгаа замд хажуугаас нь хөндлөн төмөр зам холбосон нүүрс зөөх боломж бага байгааг харуулж байна.

Богд хаан төмөр замын төслийн талаар

Тавантолгой төмөр зам компанийн захиалгаар “Урбан Девелопмент Консалтинг” групп компаниас боловсруулж Зам, тээврийн хөгжлийн төв төрийн өмчит компанийн 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 243/2021 магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлагдсан Богд Хаан Төмөр зам төслийн ТЭЗҮ-г ЗТХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2022 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр шийдвэрээр дэмжсэн байна.

2022 оны 5 дугаар сарын 22-ны өдөр ТЭЗҮ-д нэмэлт, өөрчлөлт орж, мөн эрх бүхий байгууллагууд баталгаажуулсан. Төслийн нийт өртөг нь 1.4 тэрбум ам.доллар байна. Суурь Бүтцийн нийт 670,2 сая амдолларын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр Улаанбаатар төмөр зам ХНН, мөн Зэвсэгт хүчний жанжин штаб, нийт 736,2 сая долларын төсөвт өртөгтэй Тунел, стакадан гүүрийн бүтээн байгуулалтын ажлын ерөнхий гүйцэтгэгчээр “Бодь интернэйшнл” компани сонгогдож, санхүүжилтийг Эрдэнэс Тавантолгой компаниар хийхээр гэрээнүүдэд байгуулагдсан байна. “Бодь интернэйшнл” компанийн гүйцэтгэх ажлын санхүүжилтийг нүүрсээр санхүүжүүлэх гэрээг ажил гүйцэтгэгч болон “Эрдэнэс Тавантолгой” компанийн

хооронд 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан ба Монгол Улсын Засгийн газраас төслийг ажлыг түр хугацаанд зогсоосон хэдий ч 2023 оны эхний улирлын байдлаар “Эрдэнэс Тавантолгой” компаниас “Бодь интернэйшнл” компанид 26,3 сая ам.долларын нүүрсийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нэр бүхий 11 худалдан авагчид нийлүүлсэн байна.

Гацуунсухайт-Тавантолгой төмөр замын төслийн талаар

Тавантолгой-Гацуунсухайт төмөр замыг анх Ухаа-Худаг-Гацуунсухайт чиглэлээр барих эрхийг “Энержи ресурс” компанид барих, ашиглах, шилжүүлэх концессын гэрээний хүрээнд 30 жилийн дараа Монгол Улсын Засгийн газарт тодорхой хувийг буцаан шилжүүлэх нөхцөлтэйгөөр 2008 оны 6 дугаар сарын 18-нд өгсөн. Төслийн бүтээн байгуулалтын ажлыг “Энержи Ресурс Риал” компани хэрэгжүүлж байх явцад Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр төр хэрэгжүүлэхээр болж Монголын Төмөр зам компанид төмөр зам барих эрхийг өмнө нь хийгдсэн ажлын хамтаар шилжүүлэн өгсөн. “Энержи Ресурс Рел” компанийн хийсэн ажилд нийт 76,4 сая ам.долларыг нөхөн олговрыг олгосон бөгөөд, Хөгжлийн банкны 200 сая ам.долларын санхүүжилтээр Монголын Төмөр зам компани үргэлжлүүлэн гүйцэтгэсэн байна. Балансаас баланст шилжүүлэх хөрөнгийн дүнг баталгаажуулах аудитыг Монголын Төмөр зам төрийн өмчит компанийн захиалгаар аудитын “Гранд Торнтон Аудит” компани 2017-2019 онуудад хийж гүйцэтгэн, дээрх 276,4 сая ам.долларын дүнг баталгаажуулжээ. Уг ажлыг “Гранд Торнтон аудит” компани үнэлэхдээ ажлын хэмжилт шинжээчдийн дүгнэлт гаргахгүй, тухайн компанийн нягтлан бодогч, эдийн засагчдаас асуулга асуух байдлаар баталгаажуулсан нь хэт өндөр үнээр үнэлэгдэхэд хүргэсэн гэж шинжээчдийн дүгнэлтээр дүгнэсэн байна.

Санхүүгийн болон хуулийн зөвлөх үйлчилгээ үйлчилгээ авахад нийт АЕСОМ ТЭЗҮ-д 1 сая ам.доллар зарцуулахаар тусгасан боловч 11.041.568 ам.долларын болон 746,6 сая төгрөгийн 7 зөвлөх үйлчилгээг авсан нь зөвхөн зөвлөх үйлчилгээнд зарцуулсан санхүүжилт нь ТЭЗҮ-д батлагдсан санхүүжилтээс даруй 11 дахин их санхүүжилтийг компаниудад олгосон байна гэсэн дүгнэлтийг гаргасан болно. Тухайн төмөр замын бүтээн байгуулалтын гүйцэтгэгчдийг шалгаруулахдаа сонгон шалгаруулалт хийгээгүй, нууцад хамруулахаас өмнө 2019 оны 4 дүгээр сард санамж бичиг байгуулсан. Гэрээ хийгдэх үед “Бодь Интернэйшнл” компани тусгай зөвшөөрөл байгаагүй бөгөөд гэрээ хийгдсэний дараа нөхөн олгосон. Тагнуулын ерөнхий газрын зөвлөмжөөр суурь бүтцийн ажлыг нууцад хамруулах боловч явах анги, засварын тоног төхөөрөмж зэрэг 216 сая ам.долларын гэрээг хууль бусаар хийсэн, ТЭЗҮ-д 18 зүтгүүр төлөвлөсөн боловч 16 зүтгүүр нийлүүлэхээр гэрээ хийгдсэн. Зүтгүүрийг ТЭЗҮ-д заасан сонголт хийгээгүй. Өмнө нь ашиглаж байгаагүй хэт өндөр үнэтэй зүтгүүрүүдийг нийлүүлэхээр шийдвэрлэсэн. АЕСОМ-ны ТЭЗҮ одоогоор Монгол хэл дээр орчуулагдаагүй байгаа нь хяналт шалгалт хийх дотоодын аж ахуйн нэгжүүд хяналтыг бүрэн хийх боломжийг одоогоор олгоогүй. Төмөр замын рейс төмрийг ТЭЗҮ-д тусгаснаас бага килограммтай төмрөөр хийсэн. ТЭЗҮ-д тусгагдсан 120 сая ам.доллар үйлчилгээний 1,1 сая ам.доллар санхүүгийн хяналтын 1 сая ам.доллар зэрэг 200 орчим сая ам.долларыг өөр зүйлд зарцуулсан гэх боловч “Бодь Интернэйшнл” компанийн бидэнд гаргаж өгсөн тайлангаар 54,7 сая ам.долларын тайланг гаргаж өгсөн байна. Бүгд Найрамдах Солонгос улсын “Домион” компаниар ТЭЗҮ хийлгэж, нийтдээ Гашуунсухайт-Тавантолгойн боомтууд дээр 1300 айлын орон сууцыг барихаар ТЭЗҮ-д тусгаж гэрээ хийсэн боловч, төслийг хэрэгжүүлэх явцад 1300

айлын орон сууцыг барилгүйгээр өөр нүүрс буулгах талбай руу тухайн хөрөнгийг шилжүүлсэн нь 1300 айлын орон сууц болон нийгмийн дэд бүтэц барих ийм гэрээний заалтыг зөрчсөн гэж үзэж байгаа юм.

Тус компани нь гадаадаас хөрөнгө босгон бүтээн байгуулалт хийх зорилгоор төлбөрт авах нүүрсний үнийн дүнгийн 13 хувиар хөнгөлөлт эдэлсэн. Нийт гэрээнд авч байгаа нүүрс дээр 13 хувийн хөнгөлөлт эдэлсэн. Гэвч Тавантолгой компаниас 110 сая ам.долларыг бэлнээр, 90 сая ам.долларыг нүүрсээр урьдчилж аваад, нийтдээ 200 сая ам.долларыг урьдчилгаа авч, цаашид хөнгөлөлттэй үнээр буюу 13 хувийн хөнгөлөлттэй үнээр нүүрс авч барьсан зэрэг нь тухайн компанид хэт давуу байдалд олгосон нь дараах баримтуудаас харагдаж байна.

2017 онд Бодь компани 115 сая төгрөгийн ашигтай ажиллаж байсан компани. 2018, 2019 онуудад алдагдалтай ажиллаж байсан бол 2020 онд татварын байгууллагад гаргасан тайлангаар 133,6 тэрбум төгрөгийн ашигтай, 2021 онд 140 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан нь нэг компанид хэт өндөр ашиг олох ийм боломжуудыг олгосон гэрээ байсан гэж шинжээчдийн дүгнэлтэд гарсан болно.

Төрийн өмчит компаниудын худалдан авалтын талаар

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой компаниудын худалдан авалтын үнийн дүн зах зээлийн үнээс хэт өндөр. Төлөөллүүдэд удирдах зөвлөлийн гишүүд гүйцэтгэх удирдлагын хамаарал бүхий хүмүүс сонгон шалгаруулалтад ихээр нөлөөлж байсан нь тогтоогдсон болно. Эрдэнэс Тавантолгой компани 2018-2022 онд нийт дотоод худалдан авалтад 9,8 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 665 тендер зарлан хэрэгжүүлжээ. Эдгээр гэрээнүүдээс шинжээчдийн дүгнэлтээр

анхаарал татсан зарим худалдан авалтуудыг танилцуулж байна.

1. “Өвөр Монголын Хуа Еэ Аж Үйлдвэр” компани болон “Өвөр Монгол Хуа Еэ барилга, машин механизм” компанийн хамтарсан Хуа Еэ түншлэлтэй байгуулсан ЭТТ-2022/573 дугаар бүхий уул уурхайн авто самосвал, авто грейдэр худалдан авах гэрээний үнийн дүн нь 881.664.733.800 төгрөг байна. Зөвхөн нэг компанитай байгуулсан гэрээ. Уг техникийг худалдан аваад нийлүүлсэн зөрчлийг нь шинжээчдийн дүгнэлтээс танилцуулах юм бол тухайн үнийн дүнгээр нийлүүлэгдсэн техникүүд нь 13 төрлийн зөрчил илэрсэн. Тухайн ирсэн техникүүд нь техникийн шаардлагууд хангаагүй, зарим техник нь ажилласан мото/цаг нь техникийн шаардлагад зааснаас илүү гүйлттэй байсан. Зарим нийлүүлэгдсэн техник, тоног төхөөрөмжүүд нь үйлдвэрлэсэн он нь тодорхойгүй, тухайн үйлдвэрлэсэн компанийн марк тодорхойгүй зэрэг олон дутагдлууд илэрсэн байна.

2. “Эйч Эл Кэй Эм Эн” гээд компанийн хооронд байгуулсан хүнд машин механизмын дугуй худалдан авах гэрээ ЭТТ-2022/569 дугаартай гэрээнд 5.227.200.000 мянган төгрөгийн гэрээ хийгдсэн. Гарсан зөрчил нь хүнд даацын техникийн дугуйг нийлүүлэхдээ дугуйны даацын тодорхойлолтыг хэмжэдэг хурдны индексийг хэмжэдэг дугуйны бөөрөнд байдаг мэдээллүүдийг арилгаж, хуурамч дугуй нийлүүлсэн нь хяналт шалгалтаар тогтоогдсон. Уг дугуйг хүлээж авсан байсан.

3. Бүгд Найрамдах Хятад Ардын Улсын “Hong kong hengde” компанитай байгуулсан хагас коксжсон түши худалдан авах, нүүрс нийлүүлэх ЭТТ-2022/518 дугаар бүхий арилжааны гэрээ 500 мянган тонн хагас коксжих түши нийлүүлэх ийм гэрээ байгаа. Зөрчил нь нийтдээ 10.381 тонн хатуу коксжих нүүрсийг нийлүүлсэн боловч, эсрэгээрээ

Хятадаас авах хагас коксожсон түшиээ аваагүй ийм зөрчил гарсан.

4. “Элгэн” компани “Эрдэнэс Тавантолгой” компанийн хооронд байгуулсан далд уурхайн хайгуул, судалгааны ажлыг Гүйцэтгэх ЭТТ-2022/946 дугаартай гэрээ. Гэрээний дүн 69.763.999.500 төгрөг. Зөрчил нь “Эрдэнэс Тавантолгой” компани гэрээнүүдийг Тагнуулын ерөнхий газраас бичиг явах журмаар нууцад хамруулан зөвхөн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хийгдсэн гэрээнүүдээс гадна томоохон тендерүүдээ нууцад хамруулах замаар шууд гэрээ хийж байсан нь олон гэрээнүүдээс илэрч байгаа юм.

Орон нутгийн Тавантолгой компанийн талаар

Орон нутгийн Тавантолгой компани 51 хувийг орон нутгийн өмч, 49 хувь нь хувийн өмчийн компани бөгөөд сүүлийн жилүүдэд компанийн гүйцэтгэх удирдлагын 49 хувийн төлөөллүүд удирдаж ирс ирсэн. Үүнтэй холбоотой компанийн төлөөлөн удирдах зөвлөлд Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид орж ажилладаг бөгөөд компанийн хувь эзэмшигчид, ТУЗ-ийн дарга, гишүүд гүйцэтгэх удирдлагын хамаарал бүхий аж ахуйн нэгжүүд нүүрсний гэрээ болон дотоод худалдан авалтад оролцдог байсан нь шалгалтаар олон гэрээгээр илэрсэн болно.

Боомт нүүрс тээвэрт учирч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд авто тээврийн хэлэлцээр болон түүнийг хэрэгжүүлэх яамд хоорондын протоколын дагуу олон улсын “С” зөвшөөрлийг 2023 оны 1 дүгээр улирал хүртэл Автотээврийн үндэсний төв олгож байсан бөгөөд энэ үед “С” зөвшөөрөлтэй холбоотой давуу байдал олгох үйл ажиллагаанд авлига, хээл хахуулийн асуудал гарч, хуулийн

байгууллагуудаар шалгаж шийдвэрлэгдсэн байна. Энэ зөвшөөрлийн хувьд боомттой холбоотой бөмбөлөг тээврийн нөхцөл байдал, “С” зөвшөөрөл олголт зэрэг үйл ажиллагаанууд нь тухайн гамшиг гарсан үед Засгийн газар шуурхай байдлаар тусгайлан журам гаргаж яваагүйгээс тухайн хил боомттой үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүд дур зоргын олон төрлийн журам гаргаж байсан нь шалгалтын явцад илэрсэн болно. Өнөөдрийн байдлаар Засгийн газрын 362 дугаар тогтоол, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 01 тоот тогтоолын дагуу “С” зөвшөөрлийг олгох асуудлыг олборлогч аж ахуйн нэгжүүд шилжүүлсэн болно.

Түр хороо хяналт шалгалтын хүрээнд илэрсэн зөрчлүүдийг тухай бүр нь хуулийн байгууллагууд, Төмөр замын цагдаагийн байгууллага, Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн ерөнхий газарт шалгуулахаар олон албан бичгүүдээр зөрчлүүдийг өгч шалгуулж байсан гэдгийг энд хэлэхийг хүсэж байна.

Дээрх шалгалтын хүрээнд Улсын Их Хурлаас байгуулсан Түр хорооноос дараах санал, дүгнэлтүүдийг танилцуулж байна.

1.Төрийн өмчийн эдийн засаг төсвийн салбар дахь авлигатай тэмцэх үндсэн арга бол төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой томоохон компаниудыг олон улсын нээлттэй компани болгон өөрчлөн байгуулж, түүнд хамаарахгүй төрийн өмчийн компаниудыг эрчимтэй хувьчлах замаар төрийн үүрсэн ачааллын ихээхэн хэсгийг хувьд шилжүүлэх.

2.Ашигт малтмалын экспорт, тээвэрлэлтийн мэдээллийг гааль, боомт, хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг хамааруулсан мэдээллийн нэгдсэн цахим сүлжээ байгуулж, импортлож байгаа ерөнхий мэдээллээ

тогтмол солилцож байх гэрээ хэлэлцээр байгуулах.

3.Зөрчил, гэмт хэргийн шинжтэй мэдээллийг цаг тухайд нь шалгаж шийдвэрлэгдээгүй, ойлгомжгүй шалтгаанаар хэрэгсэхгүй болгосон хууль хяналтын байгууллагын удирдлагатай хариуцлага тооцож, цаашид ийм байдал үргэлжлэх нөхцөл байдлыг таслан зогсоох шаардлагатай байна.

4.Цаашид боомтын үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагуудын нэгдсэн урилгаар ханган, мэдээ тайланг улирал бүр тулган дүгнэлт гаргаж, Боомтын зөвлөл Засгийн газарт тайлагнаж байх.

5.Аж ахуйн нэгжийн аливаа ажлыг төрийн нууцад авсан тохиолдолд үйлчлэх тусгай журам гаргах, худалдан авах ажиллагааг зохицуулдаг журамтай байх.

6.Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг идэвхжүүлж, ажлын албыг тухайн нутаг дэвсгэрт ажиллуулах шаардлагагүй гэж үзэх юм бол Цагаан нуур зэрэг зарим чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг татан буулгах.

7.Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын хил холболтын асуудлыг яаралтай шийдвэрлэж, эдийн засгийн эргэлтэд оруулж, тээвэрлэлтийн үнийг бууруулах.

8.Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян зэрэг төслүүдэд хөндлөнгийн аудит оруулан, төслийн санхүүжилт, өртөг, чанар, үр дүнгийн талаар Улсын Их Хурал тайланг сонсох.

9.Онцгой нөхцөл байдал үүссэн /тухайлах юм бол цар тахал, байгалийн гамшиг/ нөхцөлд боом, хил, гаалийн ажиллах тусгай журам гаргаж, мөрдөх шаардлагатай байна гэсэн ийм дүгнэлтийг гаргаж байгаа юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд
ээ,

Хилийн боомтоор ачаа тээвэр, нүүрс тээвэрлэх боомт болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч байгаа хүндрэлийг шалган тогтоох үүрэг бүхий Хянан шалгах түр хорооноос хийсэн хяналт шалгалтын ажлын явцын тайлангийн танилцуулгыг та бүхэнд танилцууллаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна.Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Гочоогийн Ганболд гишүүний ахалсан түр хороо бол ер нь овоо сайн ажиллачихсан юм байна гэж энэ тайлангаас үзэхээр байна л даа. Богино хугацаанд 6 удаа хуралдаж, түр хорооноос 10 тогтоол гаргаж, холбогдох байгууллагуудад 77 албан тоот илгээж, 45 албан тоот холбогдох материалуудыг бусад газраас хүлээж авч ажилласан ийм дүнтэй байна. Яах вэ, ажлын хэсэг, түр хороо байгуулаад Их Хурлаас бид нар боломжийн олгогдсон хуулийн эрх зүйн боломжийнхоо хүрээнд сайн л ажилладаг л даа. Тухайлах юм бол бид нар Хөгжлийн банкны асуудлаар ажлын хэсэг байгуулахыг бид шаардаж байгаад, ажлын хэсэг байгуулаад бид нар чинь 56 хоног өдөр, шөнөгүй ажилласан. Ингээд түр хороо байгуулсан. Түр хороо 1 жил ажиллаад, одоо энэ шүүхийн асуудлууд нь явагдаж байна. Тэгээд хамгийн гол нь шалгасан асуудлууд маань яг шалгах явцад болоод ингээд ерөөсөө бүх процесс дунд нь хаягдаад, орхигдоод, нэг үгээр хэлэх юм бол дундуур нь гэмт этгээдүүд ял завшаад, зувчуулаад сугараад үлддэг нэг аюул гэм бий. Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр нүүрсний хулгайтай холбоотой асуудал бол бас л

ийм замаар л явахаар шинжтэй байгаа юм. Тийм учраас дахиад шинээр яг “Эрдэнэс Тавантолгой”, орон нутгийн төрийн өмчтэй “Тавантолгой” компаниуд үүнийг тойрсон нүүрсний хулгайтай холбоотой асуудлыг онцгойлон анхаарч, хяналт шалгалтын түр хороо байгуулъя гэж ингэж үзэж байна шүү дээ. Тийм учраас энэ дээрээ их онцгой анхаарахгүй бол болохгүй ээ. Ганболд гишүүний ахалсан түр хороо бол үүргээ биелүүлсэн байна. Тодорхой асуудлуудыг гаргаад ирсэн байна гэж үзэх гээд байна л даа. Тийм учраас юу юутай холбоотой, сая Хөгжлийн банкны асуудлаар ч гэсэн тийм л байна шүү дээ. Шүүх дээр очоод ингээд замхруулаад, тэгээд эрх мэдэл, эд хөрөнгө тааруухан шиг нэг иймэрхүү юмнуудыг нь тэгээд цааш нь түлхээд, тэгээд энд нь цувчхаад гардаг нөхдүүд нь ихэнх нь сугараад тэгээд зувчуулаад гарчихсан ийм л дүнтэй байна. Тэгэхээр нүүрсний хулгайтай холбоотой энэ асуудлыг эцсийг нь хүртэл явж, энийгээ бүр тодорхой болгох хэрэгтэй.

Тэгээд тийм учраас би түр хорооны дарга Ганболд гишүүнээс юу гэж асуух гээд байна вэ гэхээр саяхан хэдхэн сарын өмнө хоёрхон сарын өмнө яригдаж байсан улсад учирсан хохиролтой холбоотой 40 хэдэн их наяд төгрөгийн тухай асуудал яригдсан. Таны сая танилцуулга дээр гарч байгаа 6,9 сая тонн нүүрс Хятад-Монголын хил.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Гочоогийн Ганболд гишүүн, Түр хорооны дарга.

Г.Ганболд: Би түр хороо бол үүргээ гүйцэтгэсэн гэж ойлгож байгаа. Түр хороо байгуулагдаад Засгийн газар ч гэсэн энэ нүүрсний хулгайтай холбоотой асуудал явуулаад, бид нар хяналтын ерөнхий сонсгол хийсэн. Энэ хүрээнд нөгөө олон жил хардаж байсан бүх нууц гэрээнүүд, оффтейк гэрээнүүдийг бид нар ил болгосон. Энэ хүрээндээ бид нар шалгалтаар оффтейк гэрээнүүдийг ямар

үнийн дүнтэй, тэр гэрээнүүдийг яаж хийснийг бид нар бүгдийг нь тогтоогоод, тайлан дотор чинь уг нь тавьчихсан байгаа шүү дээ. Ямар хэмжээний хохирлууд учирсан юм. Ямар өндөр үнэтэй гэрээнүүд хийгдсэн юм. Энийг л бид нар нотлох баримтыг шинжлэн судлах сонсголын хүрээнд 2 талын манайхаас томилогдсон шинжээчдийн дүгнэлтийг нөгөө оролцсон аж ахуйн нэгжүүдийг нотлох баримтаар ингэж мэтгэлцэж явах ёстой юм маань хийгдээгүй учраас би хэт нэг талыг барьсан юм ярьчих гээд байна. Тэгэхээр уг нь бол энэ Хяналт шалгалтын хуульд бид нар цаашидаа жсоохон өөрчлөлт оруулж, заавал нотлох баримтын сонсголыг хийдэг болгох, тэгээд хяналт шалгалтын хуульд процессын хуультай болгох ер нь олон асуудлууд байгаа юм. Би таны асуултад бол 44 их наядын тухай асуудлуудыг яригдаж байсан. Тэгэхээр бид нар ер нь зүгээр алдагдсан боломж, бид нарын гаргаж ирсэн нүүрс дээр бид бүхэн зөвхөн танд хулгайд алдагдсан нүүрс гэхээс гадна өнгөрсөн хугацаанд бид нар 7 сая тонн нүүрсийг 9-18 доллароор л зарсан байгаа юм. Энэ бол би хамгийн том хулгай гэж ойлгож байгаа юм. Ангиллын зөрөө. Тэгээд энийг бодож үзэх юм бол тэгээд оффтейк гэрээнүүдийн үнийн дүн, тэгээд нүүрсний бид нарын батлагдаж байгаа зөвхөн 2 гаалийн баталгаат талбай дээр шалгалт хийгээд гаалийнхантай тулгаад бүтэн сар ажлын хэсэг гаргаад үзэхэд 2-хон гаалийн нүүрс ачиж буулгах талбайгаас 1,1 сая тонн нүүрс дутаж байгаа шүү дээ. Бусад хэдэн талбай дээр нь 4 жилээр шалгалт хийхэд 2 сая тонн нүүрс илүү гарч байгаа байхгүй юу. Илүү гарна гэдэг нь наанаасаа эх үүсвэргүй нүүрс гэсэн үг шүү дээ. Эх үүсвэргүй. Нөгөө мөргөцөг янз бүрийн уурхайн амнаас алдагдсан нүүрс. Энэ болгоныг тооцоод үзэх юм бол ер нь ямар ч дүн гарч болох юм байна лээ. Энийг бүгдийг нь тооцох юм бол 40 их наядар тоологдох ийм хэмжээний нүүрсний хулгай гарсан гэдэг дээр нэг их маргаад байх зүйл ер нь байхгүй. Хамгийн гол нь сонсгол хийлгээгүйд л би

харамсаад байгаа юм. Сонсгол хийж бид нар нотлох баримтаар энэ зүйлүүдийг хийх байсан. Зүгээр харамсалтай нь дахиад түр хороо байгуулж сонсгол хийх юм байна. Чухам ямар сэдвээр хийхийг нь би мэдэхгүй байна Бат-Эрдэнэ гишүүн ээ.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Б.Бат-Эрдэнэ:

Тэгэхээр Их Хурал Засгийн газар гээд уялдаатай ажиллахаар тодорхой үр дүн гарч, тухайлах юм бол нүүрсний хулгайтай холбоотой асуудлаар түр хороо байгуулаад Ганболд гишүүн өөрөө ахлаад түр хороонд орж ажилласан гишүүд чинь асуудлыг нэлээн доргиогоод гаргаад ирсэн. Яг үүн дээр нь Засгийн газар бол энэ асуудлуудыг нэг мөр нэг талд нь шийдээд, ангилалтай холбоотой өчнөөн нүүрсийг зарж борлуулж дундаас нь ашиг олж байсан бүх асуудлыг хил нөхцөлөөр, биржээр худалдаалах энэ арга хэмжээг авсны үр дүнд чинь төсвийн орлого 1 их наядар давж биелж, тэгээд цалин, тэтгэврийн зөрүүг арилгах, нэмэгдүүлэхээс өгсүүлээд тулгамдсан олон асуудлууд шийдээд явж байна.../минут дуусав/

Г.Занданшатар:

Асуулт, үг хамт явж байгаа. Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа:

Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 26 гишүүнээр гарын үсэг зуруулж, Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу энэ хороог би байгуулсан юм. Энэ түр хороо бол ажиллах хугацаандаа төрийн өмчит Эрдэнэс Тавантолгой, бусад газруудад байгаа нүүрсний хулгай, луйврыг илчлэхэд шударгаар ажилласан гэж үзэж байгаа. Энэ хяналт шалгалтын тухай хуулийн дагуу нотлох баримтын сонсгол хийх гээд 4 сард Улсын Их Хуралд энэ тухай

саналаа тавихад, хууль хяналтын байгууллага зөвшөөрөхгүй байна гэдэг нэрийдлийн доор түр хорооны үйл ажиллагааг гацаасан. Гацаасаар байгаад хугацаа нь дууссан гэдэг үндэслэлээр тэр нотлох баримтын сонсголыг хийгээгүйд харамсаж байна. Харамсаж байна. Энд олон булхай луйвар илэрсэн. Тэр оффтейк гэрээг хөндөгдөөгүй. Гэмт хэргийн замаар төрийн өмчийн эд хөрөнгийг завиш хамгийн том луйврын схем энд байсныг энэ түр хороо илрүүлсэн шүү. Хамгийн наад захын жишээ гэхэд л хэний санаанд ч оромгүй юм байгаа юм шүү дээ. Бид өнөөдөр Улаанбаатар хотыг утаагүй түлшээр хангана гээд л хэдэн 10 тэрбум төгрөг. Улаанбаатар хотын утаагаа түлш зөрүүлж байна гээд л 2, 3 үйлдвэр байгуулаад ингээд явж байтал Хятадаас утаагүй түлш авна гээд оронд нь нүүрс өгнө гэсэн ийм гэрээ хийсэн шүү дээ. Үгүй ээ, энийг ер нь юу гэж ойлгох юм бэ. Тэгээд энэ асуудлыг Улсын Их Хуралд оруулахгүй, хугацааг нь хойшлуулсныг нь би их хардалт үүсгэж байна гэж бодож байна. Хардалт үүсгэж байна гэж бодож байна. Үнэхээр тийм шаардлагатай байсан юм бол дахиад Улсын Их Хурал энийг хуульдаа өөрчлөлт оруулаад энэ түр хорооны үйл ажиллагааг сунгах байсан юм шүү дээ. Одоо шинээр түр хороо байгуулах гэж байна. Хөгжлийн банкны асуудал дээр түр хороо байгуулаад, зарим зүйлийг нь дараад, зарим зүйлийг нь ил гаргаад тийм будаг шунх түрхээд өнгөрсөн ийм гишүүн туршлага байгаа гэж би боддог. Гэтэл өнөөдөр шинэ түр хороо байгуулж, ямар юмыг далдлах гээд байна. Ямар юмыг өнөөдөр авч үлдэх гээд байна гэсэн ийм хардалттай байна. Энэ нотлох баримтын сонсголыг яагаад хийж болоогүй юм. Гэтэл өнөөдөр хугацааг нь дуусгачхаад, дахиад яах гэж түр хороо байгуулж нүүрсний асуудлыг хийх гээд байгаа юм гэдэг дээр би их хардалттай байгаа. Энэ нүүрсний нотлох баримтын сонсголыг хийгээгүйн төлөө өнөөдөр Ганболд гишүүнийг бүх талаас барьж идсэн. Гэм буруутан нь Ганболд болсон шүү дээ. Гэтэл энийг

оруулж ирэхийг саатуулсан, энийг хугацааг дууссан ийм асуудлууд өнөөдөр энэ Их Хурал дотор байна. Энэ нотлох баримтын хэмжээнд олон гэмт үйлдлүүдийн баримтууд олон улс төрчтэй холбогдсон олон юмнууд энд байгаа шүү. Дараагийн түр хороо гэдэг байгууллага чинь юу хийх гээд байгаа юм гэдэг дээр би их эргэлзэж байгаа. Бас их гайхаж байгаа. Ийм учраас.../минут дуусав/

Г.Занданшатар: Яагаад та түр хорооны даргаа болиод, яагаад сонсгол хийгээгүйг та хэдтэй л ярих асуудал. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Нүүрсний асуудал том асуудал. Би Оюутолгой гээд 20-иод жил ярьсан. Цаашид ч ярина. Арай гэж нэг Монголын ард иргэддээ нэг ойлгож, ухаарч ер нь ямар том хулгай, луйвар хийчихсэн юм бэ гэж харж байсан бол дахиад араас нь нүүрс гараад ирлээ. Нүүрс бол нарийн яривал нүүрсний хулгай бол увайгүй хулгай. Оюутолгойн хулгай бол супер мэргэжлийн түвшинд Улсын Их Хурлын гишүүдийн бүгдийг нь авлигалдаж байгаад хийсэн аймшигтай хулгай. Тэгэхээр нүүрсний энэ хулгай дээр анхаарахгүй бол болохгүй ээ. Занданшатар дарга энэ Их Хурал бол авлигын эсрэг Их Хурал байна гэж хэлж байсан. Яг тэрнийхээ дагуу энэ Их Хурал дээр шүгэл үлээж, Адьшаа гишүүн бланк дээрээ санаачилж, Ганболд гишүүн ахалж, бүтэн 6 сар ажиллаад, дараа нь дахиж сунгаад 6 сар ажилласан. Бид нар өдөр, шөнөгүй ажилласан. 8 удаа хуралдсан. Түр хороо маш сайн ажилласан. Шинжээчид байна. Тэр олон Тамгын газрын ажилтнууд. Авлигатай тэмцэх газраас ганцхан бичиг ирсэн. Буянтүмэн, Удаанжаргал, Ганхуяг эд нарыг яг бариад, хориод ерөөсөө яг үр дүн гарах гээд байна. Та нар битгий садаа болооч гэсэн бичиг байна. Та нар дуугүй байж байгаач ээ. Одоо миний асуулт энэ Буянтүмэнд хариуцлага байна уу. Энэ Буянтүмэн яг ард түмний төлөө энэ том нүүрсний хулгайг илрүүлэх гээд

явж байгаа бидэнд садаа болсноороо энд хариуцлага байна уу? Энэ хүмүүс нь үнэхээр тэгээд үр дүн гарсан уу. Ард түмэнд хэдэн төгрөгийн төлбөр төлүүлчихсэн юм. Хэдэн хүн тэр хариуцлага тооцсон юм. Энэ 1 дүгээр асуулт миний.

2 дугаарт би хүсэлт гаргаж байгаад дараагийн ажлын хэсэгт нь орно гэсэн. Харин Ганболд, Адъяаа гишүүн болон энэ дээр бүтэн жил нойр хоолгүй ажилласан шинжээчид болон гишүүд энэ ажлын хэсэгт орох ёстой шүү. Би л лав хүсэлт хийж орсон. Манай Баттөмөр доктор, гишүүн маань энэ дээр маш хүчтэй ажилласан. Маш их шинжлэх ухааны үндэстэй дүгнэлтүүдийг гаргаж ирсэн. Баттөмөр гуай энэ дээр орох байх гэж би найдаж байгаа. Ингээд миний асуулт бол төр бол залгамж чанартай байх ёстой. Төрийн үйл ажиллагаа залгамж чанартай. Энэ өмнөх түр хорооны үр дүнг замруулах гэж замхруулах гэж дараагийн түр хороо байгуулагдаж байна гэж би бодохгүй байна. Улам сайжруулах гэж байна гэж би ойлгож байгаа. Энэ орно биз дээ. Орох уу. Оруулах уу гэж би асууя 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт. Энэ гүйцэтгэлийн аудитын тайлан гээд аудитын материалыг би их унидаг юм. Занданбат даргатай аудитын материалууд их сайн гарсан байна. Одоо би та нарт аудитын материал дээр нэг дүгнэлт хэлье. 47 дугаар хуудас дээр. 3.7-д энэ компанид Эрдэнэс Тавантолгойг хэлж байгаа юм шүү. Энэ компанид сайн засаглалын зарчим хэрэгжээгүй. Зөвхөн том хувьцаа эзэмшигч буюу Засгийн газар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Эрдэнэс Монгол компани зэрэг шийдвэр гаргагчдын гарах эрх бүхий этгээдийн эрх ашигт нийцсэн шийдвэр гаргаж, тэдгээрийг төлөөлж удирдлагаар томилогдсон нөхдийг нөхцөлийг бүрдүүлж байна.

3.9-д нь ийм жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг, ард иргэдийн эрхийг хамгаалах ямар ч боломжгүй болсон байна.

3.10-д нь Эрдэнэс Тавантолгой компанийг засаглалын хувьд зах зээлийн зарчмаар ажиллуулахгүй, төр, Ерөнхийлөгч, Засгийн газар, сайд нарын шийдвэрээр үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлж, компанийн орлого ашигаар ТЭЗҮ-д тусгасан ордыг цогцоор нь үр ашигтай ашиглах энэ үнэ цэнийг бууруулж, насжилтыг нь богиносгож, сорчилж ингэж будаа болгож байна. Энэ чинь Ганбаатар хэлсэнгүй шүү дээ. Аудит дээр та нар, сайд нар, дарга нар.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганбаатар гишүүн 1 минут.

С.Ганбаатар: Тэгэхлээр миний хэлэх гээд байгаа зүйл гэвэл сайд нар энэ түр хороог даргалж болохгүй шүү. Сайд гишүүд даргалж болохгүй. Энэ дээр сөрөг хүчин даргалах ёстой. Сөрөг хүчин дотроо 20 жил Оюутолгойтой зодолдсон, тэднийхээ нүүдлийг би мэддэг учраас надаар даргалуулж өгөөч. Би хариуцлага үүрье гэж байна. Та нар бодоод үз. Өнөөдөр дарга, цэрэгтэй биш. Энийг барьж авсны төлөө Оюутолгой дээр хэдэн ухаантай нийтлэлчид 20 жил намайг балбасан. Намайг улам ухаантай болгосон, улам хатуужилтай болгосон. Одоо энэ рүү орсон. Энэнээс идэж уудаг, нам дамжсан аймшигтай идээчин уугаачингууд дахиад балбана. Зүгээр надаас илүү балбалт даах хүн ховор доо. Намайг толгойлуулаад хамгийн гол нь үр дүн гаргамаар байна. Ард иргэдэд хохиролгүй болгомоор байн.

Гуравт нь ийм хулгай бүү үзэгдэг. Дахиж битгий гараасай гэдэг эрх зүйн орчныг бүрдүүлэхэд.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуулт, үг хамт явж байгаа. 13 цагаас Төсвийн байнгын хороо Жанжин Сүхбаатар танхимд хуралдана. 13.30-аас Эдийн засгийн

байнгын хороо Их засаг танхимд хуралдана. Гишүүд асуулт, хариултын цаг дуусаж, санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай. Асуулт хариултын цаг дээр цөөхөн гишүүд байна. Асуулт хариулт дуусаж байгаа учраас одоо санал хураалт явуулахад чуулганы танхимд цуглаарай. Цэндийн Сандаг-Очир гишүүн. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ хяналт шалгалтын хорооны тайлан гээд хаваржингаа таг байж байгаад гэв гэнэтхэн өнөөдөр чуулган завсарлахын өмнөх 2 дахь өдөр орж ирж байх юм. Сая Ганболд даргын тайланг хальт сонслоо. 20 гаруй минутын нэлээн олон хуудас тайлан уншиж байна. Гишүүдэд ерөөсөө огт тараагдаагүй. Ер нь асар их олон зөрчил, луйвар байгааг сая сонслоо л доо. Юун тэр Хөгжлийн банк, юун тэр ЖДҮ-ийн хажууд хэдэн сая доллароор яригдах хэмжээний зөрчлүүд яригдаж байна шүү дээ. Тэгээд хяналт шалгалтын түр хорооны үндсэн үүрэг бол энэ. Энэ хийгдсэн гэрээнүүдийг, борлуулалтыг, тээвэрлэлтийг хэрхэн яаж хийгдсэн юм, зах зээлийн үнийн дүнтэй харьцуулахад яаж хийгдсэн юм. Тэгээд энэ ажлаа ямар ч байсан хийсэн юм байна. Харин харамсалтай нь яагаад нөгөө хяналт, нийтийн сонсгол хийх асуудлыг хийгээгүй юм бэ? Би Ганболд гишүүнээс асууж байна. Хэн хийлгээгүй юм бэ. Танай хороо өөрсдөө хүсээгүй юм уу. Хийх гээд байхад нь хэн нэгэн этгээд, эрх дархтнууд хааж боогоод, зогсоогоод, гацаагаад, цаг хугацаа хожоод ингээд байгаа юм уу. Энийг нь хэлж болдоггүй юм уу. Энийг тодорхой асууя.

Нөгөө талаар нүүрсний асуудал чинь ер нь явж явж энэ авлига, хээл хахуулийн асуудал ерөөсөө хамгийн том үүр уурхай нь энд л байгаа юм байна. Ерөөсөө улс орон авлигатай тэмцье, хээл хахуультай тэмцье гэж байгаа бол нүүрсний асуудлыг л ил гаргах ёстой юм байна. Энийг зүгээр нэг жирийн иргэд хийчихгүй. Өндөр дүнтэй, олон жилийн

хулгай луйврыг. Энд дандаа эрх мэдэлтэн, дархтнууд, улс төрчид, түүний гар хөл бологсод, хил, гааль, татвар, мэргэжлийн хяналт, цагдаа өөр юу байдаг юм. Холбогдох мэргэжлийн бүх байгууллагууд оролцож байж, түүний хамсаатнууд оролцож байж хулгайг хийнэ. Энэ олон жил татвар, хил, гаалийн хяналт шалгалтаас, аудитын хяналт шалгалтаас хэзээд нь хаагуур нь мултраад гарна гэдэг бол энэ чинь өөрөө оролцчихоод байгааг бэлхнээ харуулж байна. Энэ бас нийтийн сонсголыг хийлгэхгүй байгаа цаг хугацаа хожоод байгаа нь үүнтэй холбоотой л гэж би харж байна. Хувь гишүүнийхээ хувиар хардах эрхийнхээ хүрээнд ингэж бодож байна. Ард түмэн 30 гаруй хоног хөхөө өвлийн хүйтнээр Сүхбаатарын талбайдаа нүүрсний хулгайн асуудлаар зүгээр нэг жагсаагүй шүү. Энийг Монголын ард түмэн мартаагүй байгаа. Тийм учраас энэ хяналт шалгалтыг тайланг нь бүр заримдаа бүр хийхгүйгээр, сонсохгүйгээр дараагийн түр хороог оруулж ирэх гэж байна шүү дээ. Энэ чинь цаанаа нэг юм хэлээд байна. Хэлээд байна. Дараагийн хяналтын хороо яах юм. Одоо дахиад л саяынх шиг та нар шиг бөөн цаг хугацаа гаргаж, бөөн шинжээч нарыг томилж байгаад дахиад ажиллуулах юм уу, яах юм. Тэгээд дүгнэлтээ гаргаад ирэхээр нь нийтийн сонсголыг нь хийлгэхгүй байх юм уу. Янз бүрийн шалтаг шалтгаанаар. Энд ямар нэг эрх ашиг, сонирхлын юм байна шүү. Гацаах сонирхол байна шүү. Тийм учраас хувь гишүүнийхээ хувьд ч гэсэн энийг нийтийн сонсголыг хийлгэхийн төлөө, энэ хээл хахууль, авлигыг илрүүлэхийн ч төлөө байна. Энэ дээр анхаарна аа. Энэ асар том хулгай луйвар байгаа юм байна гэж ингэж бодож байна.

Тэгээд Ганболд гишүүнээс нийтийн сонсголыг хэн хийлгэхгүй байгаа юм. Хэн үүрэг чиглэл өгөөд байгаа юм. Яагаад өдий болтол хийгээгүй юм гэдэг дээр хариулт авъя.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн хариулъя.

Г.Ганболд: Сонсгол хийхийг бол манай түр хороо хуралдаад 4 сарын 10, 11, 12-нд зохион байгуулна гэдгээ зарласан шүү дээ нийгэмд бид нар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр зарласан. Тэгээд 4 сарын 3-ны өдөр дуудах гэрчүүдээ зарлах хурлаа хийх явцад түр хорооноос яг гол оффтейк гэрээнүүдтэй холбоотой “Эрдэнэс Тавантолгой” компанийн захирлаар ажиллаж байсан Ганхуягийг оролцуулж өгөөч. Мөн Монголын Тавантолгой төмөр замын захирал Удаанжаргал, өмнөх хяналтын ерөнхий сонсгол дээр гадаадаас манай ажлын хэсэг рүү холбогдож, цахимаар сонсголд оролцъё гэдэг хүсэлт тавьсан. Энийг оруулах боломжтой юу гэдэг асуудлаар Авлигатай тэмцэх газраас бид нар тэр хүмүүсийг хэрэв оруулах боломжтой гэх юм бол нэрсээ зарлах гэж байсан. Гэтэл харамсалтай нь тэр хүмүүсийг оруулж болохгүйгээс гадна Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн 33.9-д заасны дагуу танай түр хорооны нотлох баримт шинжлэн судлах сонсгол маань мөрдөн байцаалтын нууц задруулах, мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд саад учруулах ийм нөхцөл байдал үүсэж байгаа учраас хойшлуулж өгөөч гэдэг хүсэлт тавьсан. Энэ нэг хүсэлтийн дагуу бид нар би ганцаараа шийдвэр гаргаагүй. Түр хорооны 13 гишүүн хуралдаад энэ бол үндэслэлтэй байна гэж үзээд хойшлуулсан. Хойшлуулсны дараа Их Хурал дээр Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудал яваад өөр юм хэлэлцээгүй. Тэгээд явж байгаад түр хорооны хугацаа дууссан гэдэг байдлаар Их Хурлын дарга 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг дээр нь би саналаа хэлсэн. Ажлын хэсэг сонсгол хийхгүй хуулиараа. Заавал түр хороо байгуулж байж сонсгол хийнэ гэсэн, тэрэнд нь би хуралд нь оролцоогүй. 4 гишүүн нь дахиж түр хороо байгуулъя гэдэг зүйлээр шийдсэн. Шийдэхдээ манай түр хороог өөр асуудлаар боомтын асуудал танайх бол яг нүүрсний

хулгайтай хамааралгүй гэдэг байдлаар шийдвэр гаргаж байгаа юм. Үгүй л дээ. Манайх яг энэ бид нар ямар тухайн үедээ Улсын Их Хурлаас нүүрсний хулгайн түр хороо гэж байгуулалтай биш гэж үзээд нэрийг нь бол хил, гаалийн боомтын асуудлаар гээд дотор нь бол тусгай шалгалтын хүрээндээ бүгд орсон. Энэ гэрээнүүдийн асуудал орсон. Нүүрс тээврийн асуудал орсон. Гаалийн асуудал ингээд бүх шалгагдаж байгаа зүйл орсон. Сонсголыг бид нар 3 янзаар хийх байсан юм. 1 дүгээрт нь ерөөсөө нууц гэрээнүүдтэй холбоотой оффтейк нууц гэрээнүүдтэй холбоотой гарсан зөрчлүүд, үнийн дүнтэй холбоотой бүх гэрээнүүд дээр сонсгол хийх байсан.

2-т нь яг нүүрсний бодит хулгайтай холбоотой. Тэр 2 сая, 3 сая тонн нүүрс гарсан гээд байгаа.

3-д нь бид нар төрийн өмчит компаниудын худалдан авалттай холбоотой ямар хүмүүсийн ямар хамааралтай компаниуд гэрээ хийж вэ гэдгээр. Бид нар сонсголд бэлдэж Улсын бүртгэлийн ерөнхий газраас олон гэрээнүүдийн ард байгаа компаниудын хамаарлыг шалгуулах гэж өчнөөн олон хоног болсон. Одоо бол энэ тайланд нэгэнт тэр сонсгол хийгээгүй учраас тэрийг ярих боломж алга. Боломжтой гэсэн зүйлүүдээ л ерөнхий байдлаар ингээд хийж байгаа юм. Тэгэхээр би ямар нэгэн сонирхол байна гэдэгт би тантай санал нэг байна. Нүүрсний хулгай түр хороог бол нийгэмд намайг муу муухайгаар дуудаад л, намайг сүүлдээ нүүрсний хулгайч гэдгээр нь зарлаад өөрөө бараг нүүрсний хулгайд шалгагдаж байгаа гэдэг байдлаар сошиалаар дайралт өгөөд л ингээд дуусах гэж байна л даа би. Ямар ч гэсэн Их Хурлын индрийг ашиглаад нэг ч нүүрсний хулгайн асуудлаар би хууль хяналтын байгууллагад шалгагдаагүй. Нэг ч нүүрсний хулгайтай холбоотой асуудал байхгүй. Гэтэл энийг ингээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Би хэвлэл мэдээллийн байгууллагуудад нэг зүйлийг уриалах гэж байгаа юм. Олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллагууд тухайн аливаа асуудлыг олон нийтийн хяналтыг хангах, оролцоог хангах, олон нийтийн байдалд шилжүүлэхэд бол хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоо хувь нэмэр их юм байна лээ. Тийм учраас Ганболд гишүүний саяын тавьсан тайланг хэвлэл мэдээллийн байгууллагууд олж аваад, тэгээд үнэхээр улс төрчид нь улс төрийн намуудад худалдагдчихаагүй бол ёстой тэр шүгэл үлээх ийм байдлаар нүүрсний хулгай луйврын асуудал дээр үнэхээр тэр шүгэлээ жинхэнэ бодитоор нь үлээгээч ээ, хамтарч ажиллаач ээ. Хувь хүний хүний эрх, эрх чөлөөг их ярьцаадаг юм байна лээ. Нүүрсний хулгайн асуудлаар улс орны эрх ашгийн асуудал яригдаж байгаа шүү. Өнгөрсөн болон ирээдүйн ард түмний үр хүүхдүүдийн бололцоо.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Дараагийн асуудлаар Хяналт шалгалтын түр хороо байгуулах асуудлыг хэлэлцэнэ. Тийм учраас энэ дээр энэ асуудлууд нэлээн үр дүнтэй их ийм шаардлагын үүднээс энэ ажил хийгдэж байгаа гэж ойлгож байгаа.

Ингээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 33.8-д хяналт шалгалтын түр хороог 6 сар хүртэл хугацаагаар байгуулна. Шаардлагатай бол мөн хугацаагаар нэг удаа сунгаж болох бөгөөд Хянан шалгах түр хорооны ажиллах хугацаанд тухайн Улсын Их Хурлын бүрэн эрх дуусгавар болсон бол түр хороог татан буугдсанд тооцно. Хянан шалгах түр хороо тайлан санал, дүгнэлтээ Улсын Их Хуралд танилцуулснаар уг хороо татан буугдсанд тооцно гэж заасны дагуу Хилийн боомтуудаар ачаа тээвэр, нүүрс нэвтрүүлэх болон чөлөөт бүсийн үйл ажиллагаанд учирч буй хүндрэлийг

шалган тогтоох үүрэг бүхий Хянан шалгах түр хороо татан буугдсанд тооцлоо.

13.49 цаг.

Дараагийн асуудалд орно. Хянан шалгалтын түр хороо байгуулах тухай асуудлаа хэлэлцэнэ.

4 гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэхээр байгаа. “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспорт, бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагааг хянан шалгах түр хороо байгуулах тух”ай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч байгаа. Ширнэнбандийн Адъяаа гишүүн алга байна. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн алга байна. Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглуулаарай. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн алга байна. Баагаагийн Баттөмөр гишүүн алга байна. Санал хураалт.

Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

2 байнгын хороо зэрэг хуралдаж байгаа учраас санал хураалт давхцаад, гишүүдийн ирц хангалтгүй байна. Энийг Тамгын газар анхаарч санал хураалт зохион байгуулъя.

Улсын Их Хурлын дэд дарга Лхагваагийн Мөнхбаатарын өрөөнд байгаа гишүүд ору ирье.

Санал хураалт явуулна. Бейсен гишүүн ээ, санал хураалт явуулъя. Боловсролын байнгын хорооныхныг

дуудчих. Хуралдах гээд суугаад байгаа юм байна. Үг, санал дуусчихсан, одоо санал хураалт л үлдсэн. Боловсролын байнгын хорооныхныг дуудаадхаач. Асуулт, үг хамт яваад дуусчихсан. Тэгээд хаагаад алх цохичихсон. Тэгээд ахиад буруу жишиг тогтоочихно л доо. Санал хураалтаа явуулъя.

Санал хураалт. Байнгын хорооны саналаар “Түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Суудалдаа сууцгаая санал хураалт явуулна. Доржханд гишүүн суудалдаа сууя. Санал хураалт явуулна. Ингээд байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дээр нь хүн нэмэгдэх бол яриад нэмж болох байлгүй дээ. Шууд ингээд бичихэж болдог юм уу. Үгүй ээ, нэмээд л оруулчихъя. Энэ чинь тэгээд байнгын хорооноос орж ирсэн дээр нэмчхэж болох юм уу Үнэнбат аа.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн горимын санал гаргая гэсэн.

Д.Тогтохсүрэн: Дарга аа, манай олонхыг төлөөлсөн гэдэг дээр 2 санал байна. Батжаргал гишүүнийг гаргаад, Ганболд гишүүнийг оруулмаар байгаа юм. Өмнөх түр хороонд нь ажиллаж байсан, ажлаа мэдэж байгаа оруулах хэрэгтэй гэж гишүүд үзээд байгаа юм. 2 дахь нь манайх 7 гишүүн оруулах эрхтэй юм олонх. Тийм учраас жендерийг хараад Оюунчимэг гишүүнийг оруулмаар байна. Ингээд 7 нь манайхаас, 4 цөөнхөөс байх ёстой юм. Ийм байдлаар дэмжээд саналаа хураагаад явчихвал яасан юм бэ гэсэн ийм зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа юм.

Г.Занданишатар: Ганболд гишүүн, Оюунчимэг гишүүн 2-ыг нэмье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя. Үг байхгүй. Батжаргал гишүүнийг

хасаад тийм ээ. Ингээд горимын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. 56,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төслийг баталъя гэсэн Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Байнгын хорооны саналаар “Хянан шалгах түр хороо байгуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хянан шалгалтын хууль чинь 6 сарын хугацаатай байгуулна гээд заачихсан. Тэр нь ноднингийн 6 сард жил 2 сар болчихсон. 57,1 хувийн саналаар санал дэмжигдэж дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

14.22 цаг.

Дараагийн асуудалд оръё. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Тариалангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл Ж.Бат-Эрдэнэ нарын 5 гишүүн санаачилсан. Хууль санаачлагч байхгүй байгаа учраас хуулийн төслийг хойшлуулъя.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Дарга аа, Ж.Бат-Эрдэнэ нарын гишүүдийн санаачилсан Газрын тухай хуулийг энэ удаагийн чуулганаар хэлэлцүүлэхийг хойшлуулъя гэж байгаа. Тийм учраас хойшлуулах санал хураалт явуулж энийг хойшлуулаад, оронд нь Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойн тогтоолын асуудлыг оруулж хэлэлцээд батлуулчих ийм горимын санал гаргаж байна.

Г.Занданишатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Дарга аа, үдээс хойших чуулганы хуралдааны хэлэлцэх асуудалтай холбогдуулаад 1 горимын санал гаргах гэсэн юм. Төсвийн байнгын хорооны хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн 3 хууль, 2 тогтоолын төсөл байгаа. Би нэрсийг нь уншаад танилцуулаадахъя. Тэгэхээр энэ 5 асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын хамгийн сүүлийн 5 асуудал болгож оруулж нэмж өгөөч ээ л гэсэн саналыг гаргаж байгаа юм.

Нэгдүгээрх нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг

2 дахь нь “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Гуравдугаарх нь Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэг.

4 дүгээрт “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

5 дахь нь Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг хийсэн 5 асуудал байгаа. Тэгээд энэ 5 асуудлыг өнөөдрийн хэлэлцэх асуудлын хамгийн сүүлийн 5 асуудал болгож оруулж өгөөч ээ гэсэн горимын саналыг гаргаж байна.

Г.Занданшатар: Нөгөө Засгийн газраас өргөн барьсан 5 хуулийг хэлж байна уу. 2 хуулийг, дагалдсан тогтоолтой нь хэлж байна уу тээ. Эрүүл мэндийн сайд Чинзориг сайд. Одоо горимын санал боллоо. Энэнээс олон асуудал нэмэхгүй.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар

санал хураалт явуулъя. Тэгээд энэ асуудлыг хойшлуулаад, Үндсэн хуулийн 100 жилийн тогтоолыг хэлэлцье гэсэн. Санал хураалт. Байнгын хорооны дарга, намын бүлгээс санал оруулдаг. 58,1 хувийн саналаар санал дэмжигдэж Тогтохсүрэн даргын санал дэмжигдлээ.

Та 2 түр хүлээж байгаарай. Дахиад санал хураалт явуулна. Дараагийн санал хураалт Ганзоригийн Тэмүүлэн гишүүний саналаар Төсвийн байнгын хороо хуралдаад 3 асуудлаа хэлэлцсэн учраас эцсийн хэлэлцүүлгээ явуулъя. 3 хууль, 2 тогтоолыг нэмэх горимын саналаар санал хураалт явуулъя. 58,1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд нөгөө маргаашийн чуулганыхаа ачааллыг л багасгаж урагшлуулж оруулж байгаа шүү дээ. Маргааш хэлэлцэх байсан асуудлыг л өнөөдөр нэмж байгаа. Даргын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцээд шийдсэн учраас энийг нэмэж байгаа юм.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё. Саяын асуудал хойшлогдсон учраас “Төрийн төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай” 100 жилээс шууд орох уу, бэлэн байгаа юм уу.

“Анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Ингээд байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүнийг индэрт урьж байна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 2003 онд баталсан Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтад Бүгд Найрамдах Улс тунхагласан 11 дүгээр сарын 26-ны

өдрийг жил бүр нийтээр тэмдэглэх баярын өдөр болгон тэмдэглэхээр заасан. Мөн “Төрийн ёслолын журам батлах тухай” Ерөнхийлөгчийн 2015 оны 119 дүгээр зарлигаар тэгш ой тохиосон жил Үндсэн хуулийн өдрийг тусгай хөтөлбөрөөр тэмдэглэхээр заасан байдаг.

Анхдугаар Үндсэн хуулийн нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, түүхэн ач холбогдлыг тэмдэглэж, Үндсэн хуулиа дээдлэн сахих үзлийг түгээн дэлгэрүүлэх нь зүйтэй хэмээн үзэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Бүгд Найрамдах Улсын тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төсөл 6 заалттай бөгөөд анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ой 2024 онд тохиож байгаатай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг иргэн бүр эрхэмлэн дээдлэх, үзэл санааг олон нийтэд нь түгээн тайлбарлан таниулах, иргэдэд сурталчлах ажлыг улс орон даяар зохион байгуулах, дээрх ажлыг зохион байгуулахад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газарт, түүхэн ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх талаар төлөвлөгөө боловсруулж холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгаж байна.

Байнгын хорооны хуралдаанаар Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тогтоолын төслийг дэмжсэн болно.

Их хурлын эрхэм гишүүд ээ,

“Бүгд Найрамдах Улсын тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ишидвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: “Бүгд Найрамдах Улсын тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулж Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ бол маш чухал зүйл ээ. 1919 оны 11 сарын 17-нд тухайн үеийн 2 танхимтай парламентын дээд танхим нь ишидвэр гаргаад автомат эрхээсээ татгалзаж, нэгдэх ишидвэр гаргаад, тэгээд Засгийн газар нь тэр өдрөө хуралдаад, ингээд автомат эрхээсээ татгалзаж нэгдсэн байдаг юм. Тэгээд 11 сарын 27-нд Хятадын ерөнхийлөгчийн зарлиг гараад. Тэгээд энэ муухай үйл явдлыг таслан зогсоосон юм бол ардын хувьсгал. Ардын хувьсгал гарснаар энэ нөхдүүдийн тухайн үеийн эрх мэдэлтнүүдийн хийсэн тусгаар тогтнолоо бусдад зарсан энэ бузар булай явдлыг өөрчилж чадсан юм байгаа юм. Тэгэхээр анхдугаар Үндсэн хуулийг эсэргүүцдэг хүмүүс бол үндсэндээ аягүй бол гамингуудын үлдэгдлүүд байж магадгүй. Үүнийгээ баталгаажуулж чадсан юм бол 1924 оны анхдугаар Үндсэн хууль. Тэгээд бид нар энэ том алдааг манай ард түмэн, ардын хувьсгалын партизанууд ишидвэрлэж чадсан юм. Тийм учраас энийг бүдгэрүүлэх гэдэг юм байдаг. Энийг бүдгэрүүлэх гээд л 1911 оныг тодруулах

гээд л, 1911 оны тэр үед Богдын Засгийн газар энэ шийдвэрийг гаргасан байхгүй юу. Тэгээд Богдын Засгийн газрыг нэг их магтаад л, тэмдэглээд л байдаг чинь бас ч нэг их тийм таатай зүйл биш. Яагаад гэвэл тэд биднийг бусдад нэгтгэсэн. Тэр Засгийн газар. Харин энэ алдааг засаж ядсан юм бол 1924 он, 1921 оны ардын хувьсгал. Тэгээд 1924 оны анхдугаар Үндсэн хууль батлагдсанаар Монгол Улс тусгаар тогтнолын эрхээ сэргээж чадсан юм. Тэгэхээр энийг бүдгэрүүлэх гэж их оролддог. Энэ нэг гаднын нөлөө, коминтерны нөлөө байсан юм шиг ингээж ярьдаг. Түүхийн сурах бичигт ч гэсэн иймэрхүү хандлагууд оруулаад түүхийг гуйвуулчихсан байгаа. Энэ бүгдийг бид засах ёстой. Бид нар Ардын хувьсгалын 100 жилээ тэмдэглэж чадаагүй өнгөрүүлсэн. Яах вэ Ковид гэсэн нэрээр. Тэгээд шар тууз барьсан баахан нөхдүүд гарч ирж жагсаад, ингээд гаминг хөөснийхөө 100 жилийг тэмдэглэж чадаагүй. Тэгэхээр одоо харин Монгол Улсаа Үндсэн хуульд тусгаар улс болгон зарласныхаа өдрийг бид нар тэмдэглэх ёстой. Зайлигүй тэмдэглэх ёстой. Үндсэн хууль гэдэг тусгаар тогтнолыг баталгаажуулж байгаа гол баримт бичиг. Тийм ч учраас би Үндсэн хуулийн өөрчлөлтийг эсэргүүцээд байдаг нь тэр. Тэгээд энэ 100 жилийн ойгоо тэмдэглэх асуудлыг бид нар маш өргөн хүрээнд, маш сайн хийх ёстой. Энэ анхдугаар Үндсэн хууль, НҮБ-д элссэн 2-ыг бол Монголын ард түмэн байнга тэмдэглэдэг байх ёстой. Энэ бол Монголын ард түмний баярын өдөр байх ёстой. Тусгаар тогтнолын баярын өдөр байх ёстой. Зарим улс төрийн хүчин гарч ирэхээрээ 11 сарын 26-ыг тэр битгий хэл бүр байхгүй болгодог. Баярын өдөр биш болгодог. Анхдугаар Үндсэн хуулиа тусгаар тогтнолоо тунхаглан зарласан өдрөө бүдгэрүүлэхийг оролддог. Энэ бол байж болохгүй зүйл. Тийм учраас харин энэ хуулийг санаачилж оруулж ирж байгаа явдалд талархаж байна. Тэгэхээр энэ баяраа үнэхээр сайн зохион байгуулалттайгаар тэмдэглэх ёстой шүү гэдгийг хэлье ээ. Энэ бол Монголын

ард түмний тусгаар тогтнолоо баталгаажуулж, тунхаглан зарласан өдөр юм аа.

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Үнэхээр Цэрэнпилийн Даваасүрэн гишүүний хэлснээр Ардын түр Засгийн газар 2021 оны 7 сарын 8-нд Нийслэл хүрээнд орж ирээд, 7 дугаар сарын 10-нд Ардын түр Засгийн газрын анхны тогтоолуудыг гаргаад, дараа нь гарсан Ардын түр Засгийн газрын анхны тогтоолуудын нэг бол Үндсэн хууль боловсруулах ажлын хэсэг байгуулах тухай тогтоол батлаад Магсар, Хурц Цэвээнжамсран, Бат-Очир гүн нарын бүрэлдэхүүнтэй байгуулаад, Англи мэт хэмжээт цаазат, ардын эрхт улсуудын Үндсэн хуулийг нарийвчлан судлаад, эдүгээ цагийг нөхцөл байдалд тохируулан хэрэглэхийг үүрэг болгосон байдаг. Тэр нь хэмжээт цаазат, ардын эрхт Засгийн газар байгууллаа гэж заадаг нь хаана нь хэмжээт эрхтэй Англи мэтийн, тэгээд Англи, Швед, Норвег гэх мэтийн ийм улсуудын Үндсэн хуулийг судалж, анхдугаар Үндсэн хуулийг боловсруулж байсан байдаг юм аа.

Ингээд санал хураалт явуулна. “Бүгд Найрамдах Улсын тунхаглаж, анхдугаар Үндсэн хууль баталсны 100 жилийн ойг тэмдэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 53,6 хувийн саналаар санал дэмжигдэж санал хураалт батлагдлаа. Тогтоол батлагдлаа.

14.34 цаг.

Дараагийн асуудалд орно. Тэр хооронд нөгөө бусад юмнуудаа бэлдэж байгаарай.

“Төрийн аудитын байгууллагын тайланг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна. Батсуурь гишүүнийг индэрт урьж байна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдөр төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай саналаа ирүүлснийг Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023 оны 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг нэмсэн бөгөөд уг асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 56 дугаар тогтоолд холбогдох өөрчлөлт хийгээгүй болно.

Дээрх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан журмын дагуу “Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Төрийн аудитын байгууллагын албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Нанзадын Наранбаатар гишүүнээр тасаллаа. Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд нааш ирнэ үү.

Н.Наранбаатар: Та бүхэндээ өдрийн мэнд хүргэе ээ.

Тогтоолын төслийг дэмжиж байна. Төрийн аудитын байгууллагын албан хаагчдын цалинг нэмэх асуудал орж ирж байгаа асуудал бол зүй ёсны асуудал байх гэж бодож байна. Их Хуралд харьяалагддаг байгууллагын зарим албан хаагчдын цалин нэмэгдээгүй, бусад төрийн албан хаагчдын, байгууллагуудын цалин бас тодорхой үе шаттай нэмэгдсэн. Сая төсвийн тодотголоор нэлээд дорвитой цалинг нэмэгдүүлсэн байгаа. Тийм учраас зарим Улсын Их Хуралд харьяалагддаг байгууллагуудын албан хаагчдын цалинг нэмэх нь зүйтэй гэж ингэж бодож байна. Яагаад гэвэл төрийн аудитын байгууллага гэдэг бол хараат бус, хөндлөнгийн хяналт хийдэг, аудит хийдэг ийм байгууллага байгаа учраас энд байгаа ажилчдын цалинг нэмэгдүүлэх шаардлагатай. Ялангуяа хөдөө орон нутагт бас төрийн албанд ялангуяа хяналт шалгалтын байгууллагад ажиллах боловсон хүчин дутагдалтай байдаг. Тийм учраас нийгмийн асуудлыг тодорхой хэмжээнд авч үзэх шаардлагатай гэж үзэж, дэмжиж байна.

Г.Занданшатар: Дэмжиж үг хэллээ. Ажлын хэсэг Монгол Улсын тэргүүлэх аудитор бөгөөд Үндэсний аудитын газрын дарга Доржсүрэнгийн Занданбат, Цэвэгсүрэнгийн Наранчимэг Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Содномцэрэнгийн Цэрэнбаяр Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга, Буянтогтохын Бундхорол Үндэсний аудитын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн газрын захирал, тэргүүлэх аудитор, Үндэсний аудитын газрын Захиргаа, хууль, эрх зүйн газрын Ерөнхий санхүү Пүрэвдоржийн Батцэцэг нар байна.

Одоо байнгын хорооны саналаар “Төрийн аудитын байгууллагын цалин шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцсон л доо. Учир нь Эдийн засгийн байнгын хороо дээр 12 гишүүн орчихсон. Санал хураалт явуулаад байна. Одоо санал хураалт явуулъя. Санал хураалт. 52,6 хувийн саналаар санал дэмжигдэж санал батлагдлаа. Тогтоолын төсөл батлагдлаа.

14.41 цаг.

Дараагийн асуудалд орно. Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл. Соёрхон батлах эцэслэн батлах санал хураалт юм байна. Ийм учраас энийг маргааш болгож хойшлууллаа. Эцэслэн батлах санал хураалтын цагийг ирц хангалттай үед 5 дахь өдрийн өглөөний 10 цагаас зохион байгуулна гэж заасан байдаг. Тийм учраас Дэгийн тухай хуулийн 44.2-т заасны дагуу үүнийг хойшлуулж байна.

14.42 цаг.

Төсвийн асуудлууд руугаа орёе. Төсвийн 4 асуудлыг хэлэлцэхээр нэмэлт горимын санал олонхын саналаар дэмжигдэж орж ирсэн.

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн зарлагын дэд хорооны санал дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед ялангуяа төсвийн гүйцэтгэлийг хэтрүүлэх, замбараагүй зарцуулах, зөрүүтэй гаргах ийм асуудлууд маш их байна.

Өөрөөр хэлбэл 5 их наяд төгрөгийн зөрчил 2022 онд гарсан байна. Нийт 18 их наяд төгрөгийн зардлаас 5 их наяд буюу 30 хувь нь зөрчилтэй гарч байна. Яг төсвийн ерөнхийлөн захирагч яамдын сайдаас авхуулаад хамгийн бага

түвшиний тэр сургуулийн нягтлан хүртэл нийтдээ 6618 төсвийн гүйцэтгэл дээр гарын үсэг зурдаг албан тушаалтнууд байгаа. Энэ хүмүүст хувааж үзэх юм бол нийтдээ нэг албан хаагч дээр 770 сая төгрөгийн зөрчил гарч байна. Энэ бол төсвийн гүйцэтгэлийг замбараагүй, хуульд нийцүүлэхгүй, өөрсдийн эрх ашигт сувдаг сэтгэлээр хандах, зарим нөхдүүд ийм байдлыг бий болгож байна.

Тийм учраас төсвийн гүйцэтгэл дээр тодорхой хяналт тавих, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, харцуцлагажуулах зорилгоор энэ тогтоолын төслийг өргөн барьж байгаа. Тийм учраас энэ асуудлыг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хэлэлцээд, нэгдсэн хуралдаанд оруулахаар дэмжсэн.

Монгол Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, шийдвэрлэж өгөхийг хүсье ээ.

Их хурлын тогтоолын төслийг нь уншидаг юм уу.

Г.Занданшатар: Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

“Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол”-ын төслийг анхны хэлэлцүүлгээр нь батлах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

52,6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа. Дэд хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд

оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулна. Жавхлан сайд сууя. Санал хураалт. Төсвийн гүйцэтгэл чинь батлагдсангүй дээ. Дэд хорооноос гаргасан горимын саналыг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын саналаа дэмжчихсэн. Одоо дэд хорооноос гаргасан горимын саналыг гишүүд дэмжсэн учраас тогтоолын төслөө баталъя гэдэг санал хураалт явуулж байгаа. Одонтуяа гишүүн. Эдийн засгийн байнгын хороон дээр 12 гишүүн байна. Боловсрол дээр 10 гишүүн байна. Бямбацогт сайд, Болорчулуун сайд, бүх сайд нар эсрэг өгчихсөн байна шүү дээ энэ чинь. Та л дэмжсэн байна даа. Үгүй ээ, та ирцэд ерөөсөө байхгүй байгаад байна л даа. Үгүй ээ, эсрэг гарсан дээр та байхгүй байгаа. Дэд хорооны гаргасан горимын санал. Батлаагүй. Тэр чинь анхны хэлэлцүүлгээр нь батлах. Анхны хэлэлцүүлгээ баталчихсан, одоо тогтоолоо батлах гэж байгаа юм. Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Энэ саяын Төсвийн хяналтын дэд хорооны тогтоолын төсөл би уг нь дэмжиж дарсан юм. Пүрэвдорж гишүүний дүгнэлтийг сонсоод. Тэгсэн эсрэг гарчихлаа. Санал хураалтыг хүчингүй болгоод, дахин явуулж өгнө үү.

Г.Занданшатар: Одонтуяа гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. 53,8 хувийн саналаар Одонтуяа гишүүний горимын санал дэмжигдсэн учраас санал хураалтыг дахиж явуулъя аа. Санал хураалт. 51,3 хувийн саналаар санал дэмжигдэж тогтоолын төсөл батлагдлаа.

14.51 цаг.

Дараагийн асуудалд оръё. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгээ явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь танилцуулна.

Ж.Батсуурь: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн болно.

Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлын Тамгын газраар эрх зүйн дүгнэлт гаргуулах нь зүйтэй гэсэн санал гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн бөгөөд эрх зүйн дүгнэлтийг 2023 оны 7 сарын 5-ны өдөр Байнгын хороонд ирүүлсэн.

Уг дүн дүгнэлтэд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль бусад хууль тогтоомжид нийцсэн бөгөөд хуулийн төсөл нь батлагдсанаар хэрэгжих бүрэн боломжтой гэж дүгнэсэн байх тул Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Д.Өнөрболор, Ж.Батсуурь нар санал хэлсэн болно. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсан явдалд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд Дамдинсүрэнгийн Өнөрболор, Сайнхүүгийн Ганбаатар гишүүнээр тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна.

Д.Өнөрболор: Энэ хууль бол бас энэ нөхцөл байдал нь өнөөдөр Үндсэн хуулийг тодорхой хэмжээгээр зөрчиж байгаа. Ард иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчны эрх зөрчигдөж байгаа ийм хууль байгаа учраас өнөөдөр маш их

мэтгэлцэж байгаа юм. Тэгээд ийм мэтгэлцээний боломжуудыг гаргаж өгч байгаад талархаж байна.

Нөгөөтээгүүр ер нь Занданшатар дарга аа, дэгийнхээ хуульд бас тодорхой хэмжээний уян хатан дэгийн хууль дээр нөгөөтээгүүр гэх юм бол зөвхөн мэтгэлцээний асуудлыг зөвхөн анхны хэлэлцүүлэг дээр л хийдэг асуудлыг ч гэсэн ер нь цаашидаа халах нь зүйтэй юм байна гэж бодож байна. Тийм учраас бас энэ дээр бид нар анхаарлаа хандуулах юм байна гэж бодож байна.

Энэ баяр наадмын уур амьсгалтай, ард иргэдийн анхаарал сарнисан яг ийм үед ард иргэдийн эрхийг зөрчсөн хуулийг хүч түрж батлуулах батлуулах нь ээ. Тэгээд энэ хуулиар дамжуулаад би дахиад хэлэхэд шинэ сэргэлтийн бодлогын ард гуя дагаж хүзүү гэгчээр өнөөдөр Улаанбаатар хотод хорт утаа үйлдвэрлэх түүхий нүүрсний 1000 ширхэг яндан байрлуулах ийм хууль орж ирж байгаа юм. Тэгээд эхнээсээ миний хувьд аж үйлдвэр, хөдөөгийн сэргэлт, эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх асуудал дээр шинэ сэргэлтийн бодлогыг дэмжээд байгаа. Ганцхан хот хөдөөд энэ нийслэлийн иргэдийг хордуулах хууль үндсэндээ болохгүй юм. Энэ нь өөрөө би 1 дэх өдөр энэ дүгнэлтийг гаргах хүсэлт тавьсан. Энэ дүгнэлт бол нийслэлийн иргэдийг хордуулах хууль үндсэндээ ямар ч зөрчилгүй Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн гэсэн ийм асуудалгүй гэсэн Байнгын хорооны дүгнэлт гарсан. Тэгээд энэ дүгнэлтийг гаргасан хүмүүс ер нь дарга нарын даалгавар лоббигоор иргэдийнхээ эсрэг улайм цайм би үгүй гэж хэллээ гэж бодож байна. Энэ Монголын төр ер нь төрийн албанд дарга засагладаггүй, хууль засагладаг байх ёстой. Энэ дүгнэлтийг гаргасан албан хаагчид улс оронд ард иргэдийнхээ төлөө өргөсөн тангаргаасаа буцаж байна. Үүнийг дэмжсэн Тэмүүлэн дарга болон Төсвийн байнгын хорооны гишүүдэд үнэхээр харамсаж байна.

Дүгнэлтээс харахад хууль санаачлах өргөн барихтай холбоотой зөвхөн процессын хувьд зөрчилгүй гэж дүгнэснийг бүхэлдээ Үндсэн хууль бусад хуульд нийцсэн гэж үзэж болдог юм уу. Тэгээд энэ хууль 2029 он хүртэл үйлчлэхээр байгаа. 6 жилийн хугацаанд утаанаас болж хохирсон иргэдийн хохирлыг хэн төлөх вэ. Иргэдийн эрүүл мэндийн эсрэг энэ хуулийг зүтгүүлж байгаа Тэмүүлэн дарга, Чойжилсүрэн та 2 энэ асуудлыг хариуцах уу. Одоогийн Ерөнхийлөгч 2018 онд Ерөнхий сайд байх үедээ түүхий нүүрсний хэрэглээг халсан ийм түүхэн шийдвэр гаргасан. Энэ шийдвэр 5-хан жилийн настай байгаад би үнэхээр харамсаж байна. Тэгээд яг энэ ойн дээрээ МАН-аас нэр дэвшүүлсэн том зорилт, намын сайд Чойжилсүрэн сайд ард иргэдийнхээ эрүүл мэндийг хохироон, хохироон түүхий нүүрс рүү ухарч байгаад би илүү харамсаад байгаа юм. Тэгээд гэр хорооллын 200 гаруй айл, өрхийн ард иргэдээс сайжруулсан түли түлэхийг өнөөг хүртэл шаардаж байгаа. Тэгээд өнөөгийн технологиор бол 1,5мвт-аас дээш 15-аас доош станцад зөвхөн түүхий нүүрс төлөх ийм шийдэлтэй байгаа юм. Тэгэхээр 1,5мвт-аас дээш 1000 яндан өнөөдөр Улаанбаатар хотод босохоор, ард иргэдээ хордуулахаар ийм нөхцөл байдал үүсэж байгаа юм. Тэгээд би бас өнөөдөр яг энэ танхимд ёс зүйтэй, хариуцлагатай, ард иргэдийнхээ эрүүл мэнд, аюулгүй байдалд санаа тавьж байгаа гишүүд дэмжинэ гэж би итгэж найдаж байгаа. Ард иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж тэдний дуу хоолойг дэмжсэн гишүүддээ баярлалаа. Тийм учраас энд бас иргэний зориг гаргаж, ард иргэдийнхээ эрүүл аюулгүй байдлын эсрэг ийм дэмжээгүй хуулийг та бүгдийг битгий дэмжээсэй. Энэ хуулийг эхний ээлжид буцаагаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуултад Ганзоригийн Тэмүүлэн дарга хариулъя. Байнгын хороо хариуцна.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Засгийн

газрын 6 сарын 2-ны өдөр нэн яаралтай горимоор хэлэлцүүлэхээр эрчим хүчний салбарт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх үүднээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх энэ хуулийн төслийг оруулж ирсэн. Тэгэхээр Өнөрболоор гишүүн ээ, та энэ дээр бас уг нь бид нар танд хүндэтгэлтэй хандаад, тодорхой хэсэг хугацаанд эрх зүйн дүгнэлт хийгээд холбогдох хууль Тамгын газраас гаргуулаад, ингээд энэ асуудал чуулган дээр өнөөдөр орж ирж байгаа юм. Тэгэхээр эрх зүйн дүгнэлтийнхээ хүрээнд ямар нэг хууль тогтоомж зөрчсөн, хууль хоорондын зөрчил үүсгэсэн, Үндсэн хуультай зөрчилдөж байгаа асуудал угаасаа энд байхгүй. Тэгэхээр татварын хуульд өөрчлөлт оруулах, татварын тэр хуулийг өргөн барих, санаачлах эрх нь Засгийн газар дээр байгаа. Түүнийг батлах тухайн асуудлыг судалж оруулж, хэлэлцэн батлах үүрэг нь Улсын Их Хурал дээр байгаа. Тэгэхээр бид нар энэ хүрээндээ л асуудлыг судлаад орж ирж байгаа. Энэ бол эрчим хүчний салбарынхаа аюулгүй байдалтай холбоотой, тогтвортой үйл ажиллагааг хангахтай холбоотой, дээрээс нь олон жилийн хугацаанд энэ салбарт ямар нэг шинэ технологи нэвтрээгүй, тоног төхөөрөмжийн шинэчлэлүүд хийгдээгүй, асар хоцрогдсон салбар байгаад байгаа юм. Энэ дээр үндсэндээ Засгийн газар өөрсдөө нэн яаралтай горимоор бодлогынхоо хүрээнд энэ салбарынхаа эрх ашгийг хамгаалах үүднээсээ дотоодынхоо аж ахуйн нэгжүүддээ тодорхой хүчин чадлаа нэмэгдүүлж байгаа Монголд үйлдвэрлэдэггүй тоног төхөөрөмжийг импортоор оруулж ирэх юм бол тэр дээр нь тодорхой хөнгөлөлт, дэмжлэг туслалцааг үзүүлье ээ л гэдэг ийм бодлогын асуудлууд байгаад байгаа юм. Энэ бол зөвхөн Улаанбаатарын ч асуудал биш шүү дээ. Монгол Улс өөрөө 330 сумтай, 21 аймагтай. Энд байгаа асуудлуудыг эрчим хүчнийх нь, дулааных нь асуудлуудыг шийдэх үндсэн дээр Засгийн газар өөрсдөө нэн яаралтай

бодлогоор оруулж ирж байна. Бид нар энийг нь зөв гэж харж байгаа. Төсвийн байнгын хороо энэ үндсэн дээр энийг дэмжсэн. Тэгэхээр та хувь хүнийхээ үүднээс ингэж тодорхой мушгиж, буруу зөрүү ойлголт төрүүлж болохгүй ээ. Энэ ямар нэг яндантай холбоотой асуудал байхгүй. Энэ бол зөвхөн татварын асуудлууд байгаа. Татварын харилцааг зөвхөн бид нар оруулж ирсэн асуудлыг нь дэмжээд ингээд явж байгаа асуудлууд байгаа шүү. Тэрнээс энд тэр яндангийн асуудлууд тусдаа бусад өөр хууль тогтоомжийнхоо асуудлуудаар шийдэгдэж байгаа. Монгол Улсын Их Хурлаас 2020 онд батлагдсан “Алсын хараа 2050”-ын хүрээнд мөрдөгдөөд, шийдэгдээд явж байгаа асуудлууд байгаа. Таны асуудлыг бид нар ойлгож байгаа. Уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулаад түүхий эдийн стандартыг дээшлүүлэх санаачилгыг дэмжиж байгаа. Энэ чинь бусад хууль, тогтоомжоороо шийдэгдээд явж байгаа юм аа. Үе шаттайгаар хэрэгжүүлж ирж байгаа. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах асуудал бол Монгол Улсын бусад холбогдох хууль, тогтоомжууд дээр тусгагдсан асуудал. Өнөөдрийн орж байгаа асуудал бол зөвхөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татвартай холбоотой асуудлууд байгаа юм. Тэр дээр ямар нэг өөр агуулга утга зүйл нэмэх зүйл байж болохгүй ээ гэдгийг Тамгын газраас гаргасан Хууль зүйн газраас нь гаргасан дүгнэлт нь өөрөө энийг харуулаад байгаа юм. Тэгэхээр та энийг ойлгож хүлээж авч үзээрэй л гэдгийг танд хэлэх байна.

Г.Занданшатар: Эхлээд Чойжилсүрэн сайд хариулчих. Засгийн газар яагаад ард түмнийг хордуулах хууль санаачлаад байгаа юм. Үнэн юм уу.

Б.Чойжилсүрэн: Засгийн газар ард түмнийг хордуулах бодлого бариагүй ээ дарга аа, 2 дугаарт бид нар дулааны болон цахилгааны эх үүсвэр тоног төхөөрөмжүүдийг дотооддоо үйлдвэрлэсэн аж ахуйн нэгжүүдийг Аж ахуйн нэгжийн орлогын албан

татварынх нь 90 хувийг хөнгөлж, 2029 оныг дуустал дэмжлэг үзүүлж гэсэн ийм л бодлого байгаа юм. Харамсалтай нь Өнөрболор гишүүн энэ асуудлыг ингэж ойлгохыг хүссэнгүй. Бид нар олон удаа гуйсан. Таны яриад байгаагаас нөхцөл байдал ондоо биш байгаа биз дээ. Бид нарт бас танд нөхцөл байдлыг таниулах бололцоо олгооч ээ гэсэн. Ойлгохгүй л ийм асуудал яваад байгаа юм. Энэ бол аж ахуйн нэгжүүд дотооддоо импортлохоо багасгая, дотооддоо валютаа үлдээе, ажлын байраа бий болгоё, эрчим хүчнийхээ тоног төхөөрөмжийг дотооддоо үйлдвэрлэж эхэлж гэсэн ийм бодлого байгаа. Одоо энэ хэлэлцэж байгаа хууль бол.

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн тодруулж асууна.

Д.Өнөрболор: Энэ асуудал ер нь ойлгож сөхөөд байх юм байхгүй л дээ. Яах вэ, тэгээд өчнөөн олон эрчүүд ингээд ер нь бүүлийдээд бүүлийд гэдгийг нь дээрлэхээд тээ. Өнөөдөр сая 9 гишүүн Төсвийн байнгын хороон дээр бүүлийдээд ганцаараа би дэмжихгүй, бүгдээрээ дэмжээд гараад ирж байгаа л асуудал байгаа юм л даа. Ер нь бол эрчим хүчний эх үүсвэрийн асуудал өнөөдөр Улаанбаатар хотод маш том асуудал болсон байж байгаа. Энэ эх үүсвэрийг нэмэгдүүлэхийн тулд 15мвт-аар 1,5 биш ээ, 1,5 бол зөвхөн нүүрс түлэх ийм хэмжээний технологи л байгаа. 15 бол бүрэн шаталттай 99,99 хувь шүүлтүүртэй ийм дэд өртөөнүүдийг суурилуулах боломж байж байгаа. Энэ эрэлт хэрэгцээндээ шаардлагатай хэрэгцээтэй эрчим хүчний эх үүсвэрийг 15мвт-аар миний орсон зарчмын зөрүүтэй саналаар энийг зохицуулах боломж байгаа юм аа. Улаанбаатар хотод. Тэрнээс бусад нөгөө Засгийн газрын яаралтай горимоор орж ирсэн байж байгаа том бодлогын ард талд гуя дагаад хүзүү гэгчээр Улаанбаатар хотод нүүрсний асуудлыг шийдвэрлэх.../минут дуусав/

Г.Занданшатар: Ганзоригийн Тэмүүлэн Төсвийн байнгын хорооны дарга.

Г.Тэмүүлэн: Өнөрболор гишүүн ээ, энд зүгээр нэг буруу ойлголт яваад байгаа юм. Энэ эрчим хүч цахилгаан дулаан үйлдвэрлэж байгаа станц эх үүсвэрт ерөөсөө энэ хөнгөлөлт, чөлөөлөлт чинь хамаарахгүй байгаа. Хамаарахгүй. Таны яриад байгаа. Энэ юунд хамаарах вэ гэхээр зуухны тоноглол, эд анги үйлдвэрлэдэг, эрчим хүч угсралтын засварын ч гэдэг юм уу юу гэдэг юм тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг цөөхөн хэдхэн компанид л хамаарах гээд байгаа байхгүй юу. Тэгэхээр ерөөсөө л дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж байгаа, Монголд үйлдвэрлэх боломжтой тоног төхөөрөмж, тэр станцыг барьдаг ч гэдэг юм уу тэр аж ахуйн нэгж, байгууллагуудыг л дэмжиж байгаа асуудлууд байгаа юм. Тэрнээс яг тэр станцтай шууд хамааралтай асуудал биш. Тэд нарт бид нар хөнгөлөлт үзүүлээд л нэг их айхтар зуух яндан нэмээд байгаа зүйл байхгүй шүү дээ ер нь бол. Тэгэхээр ерөөсөө Монголд үйлдвэрлэх үндэсний аж ахуйн нэгж, байгууллагуудыг үндэсний үйлдвэрлэлийг дэмжих л бодлого энд яваад байгаа юм. Тэгэхээр та энэ дээр зөв ойлгоод, энийг хараарай Тэгэхээр эрчим хүч үйлдвэрлэж байгаа аж ахуйн нэгжид энэ онцгой албан татварын хөнгөлөлт хамаарахгүй. Зөвхөн тоног төхөөрөмж үйлдвэрлэж байгаа дотоодын аж ахуйн нэгжүүдэд.

Г.Занданшатар: Ер нь тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг дэмжихэд чинь эдийн засгийн онолын хувьд ч гэсэн шийддэг л асуудал л даа. Ажлын хэсэг хариулчихъя. Тэгэхгүй бол улс төрчид хоорондоо нэг улс төрийн маргаан шиг харагдаад байна нийгэмд.

86. Ажлын хэсгийг тайлбарлах.
Мэргэжлийн хүний үгийг сонсьё.

З.Мөнх-Оргил: Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Мөнх-Оргил.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль бол цахилгаан, дулаан үйлдвэрлэж байгаа эх үүсвэрийн аж ахуйн нэгжүүдтэй бол хамааралгүй ээ. Эд нар т ямарваа нэгэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт олгогдохгүй. Зөвхөн эрчим хүчний үндсэн болон туслах тоног төхөөрөмж үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн тухайн үйл ажиллагааных нь орлогод нь ноогдох албан татварыг хөнгөлөх гэсэн ийм утгатай хууль байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Өнөрболор гишүүнийг бид боорлож болохгүй ээ. Энэ бол улс төрийн асуудал биш. Үнэн. Энэ техникийн асуудал. Та нар өнгөрсөн 4 жил Хүрэлсүх Ерөнхий сайд байхад, Даваасүрэн гишүүн Эрчим хүчний сайд байхад Утаагүй Улаанбаатар болгосон. Ганц ард түмэн овоо хүрсэн энэ түвшинээсээ би бууж болохгүй, буцаж эргэж ургаж болохгүй ээ. Өнөөдөр түүхий нүүрс рүүгээ буцаж орох гээд байгаа энэ явдал дээр та нар техникийн шийдэл нь 1,3 сая Улаанбаатарт амьдарч байгаа ард иргэдийн уушиг, эрүүл мэндийг золиосолж л энэ асуудлыг шийдье гэж байна шүү дээ. Энэ дээр инженер техникийн шинжээчдийн дүгнэлт гарах ёстой байхгүй юу. Улс төрийн биш. Хууль, эрх зүйн биш. Яг энэ эрчим хүчний экспертүүдийн дүгнэлт гарах ёстой энэ дээр. Тэгж байж энэ асуудлыг ярих ёстой.

2 дугаарт Улаанбаатарын гишүүд энэ дээр онцгой анхаараач. Хаа байсан холын тэр аймгийн гишүүд л энэ дээр санаа зовоод. Үгүй ээ, энэ чинь Үндсэн хуулиар олгогдсон эрүүл аюулгүй орчинд

амьдрах эрхийг нь бид хуулийг нь биелүүлдэг болохоос биш, энэ чинь хууль өөрөө Үндсэн хууль гүйж очоод хөл ургаад хэрэгжүүлэхгүй шүү дээ. Тэгэхлээр энэ дээр шинжээчийн дүгнэлт заавал гарах ёстой. Улс төрийн асуудал биш үнэн. Энэ бол яг техникийн асуудал. Тэгэхээр Үндсэн хуульд байгаа эрхийг нь Улаанбаатарчууд болон бусад Монголын ард иргэдэд эдлүүлэхийн төлөө зүтгэж байгаа энэ санаачилгыг дэмжих ёстой. Ийм байр суурьтай байгаагаа би илэрхийлье ээ. Асуулт алга.

Г.Занданшатар: Энэ чинь Байнгын хорооны асуулт. Техникийн, экспертний дүгнэлт энэ тэр гарсан юм уу. Техник экспертний ажлын хэсэг нь Тавинбэх сайд хариулах уу. Ажлын хэсгээс экспортын дүгнэлт гарсан эсэх дээр Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ганбаатар гишүүн ээ, энэ хуулийн төслийг боловсруулах шатад олон нийтийн хэлэлцүүлгийг 3 удаа хийсэн. Манай Эрчим хүчний яамны мэргэжлийн салбарынхан бүгд санаа бодлоо тусгасан. Энэ 3 бодлогын хууль хэрэгжсэнээр Улаанбаатар хотын утааг бүрэн арилгаж чадахгүй ээ. Одоо байгаагаас нь 2-3 дахин буулгах тухай л ярьж байгаа юм. Улаанбаатар хотын иргэдийн түлж байгаа шахмал түлшний талаар яриад явах шиг боллоо. Одоо бол мэйдлингээр хийж байгаа. Дэгдэмхий 22 хувьтай байгаа. Одоо бид нар Эрчим хүчний яамнаас Засгийн газарт нэг тогтоолын төсөл оруулах гэж байна. Энэ хагас коксоор хийе гэж. Тэгсэн тохиолдолд дэгдэмхий 12 хувиас бууна. Тоосонцор нь 370 орчим байснаа 86 орчим болж буухаар бүх техникийн туршилтуудыг хийчихсэн байгаа. Энэ 2 асуудал тусдаа асуудал. ТЭЦ-3, ТЭЦ-4, ТЭЦ-2-той бид нар Багануурын нүүрсийг түлж байгаа. Ойрын жилүүдэд түлэхээс өөр аргагүй байгаа. Гэхдээ энэ зуухнуудын бүрэн шаталтын хэмжээг нэмэгдүүлэх, шүүлтүүр филтер тавих ажлыг

үргэлжлүүлээд хийж байгаа асуудал. Өнөрболор гишүүн 2 асуудлыг хооронд нь хольж яриад байгаа юм. Улаанбаатарын гишүүд ойлгож байгаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Эцсийн хэлэлцүүлэг дээр Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асууна. Үг байхгүй юм байна.

Ингээд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна аа.

15.10 цаг.

Дараагийн асуудалд оръё. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хавдисламын Баделхан танилцуулна. Индэрт дурдаж байна.

Х.Баделхан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхээр санал, дүгнэлт гарган та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварыг хэсэгчлэн төлөх, хугацааг сунгах асуудлыг бусад хуультай нийцүүлэн судалж, холбогдох хууль, тогтоомжийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, Монгол Улсын Их Хурал 2020 онд баталсан “Алсын хараа 2050”, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 52 дугаар тогтоолын 6.4-д заасан Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил зорилтын хүрээнд дулааны болон цахилгааны эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглаж буй түүхий эдийн стандартыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх асуудлыг тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Өнөрболор тогтоолын төсөлд 1,5мвт гэснийг 15 мегаваттаас дээш хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар гэж өөрчлөх гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул тогтоолын төсөл болон Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Жамбын Батсуурь гишүүн, Гочоогийн Ганболд гишүүнээр тасаллаа. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: За яах вэ, энэ нэлээдгүй 3 7 хоногийн цаг хугацаанд ингээд мэтгэлцэж байхдаа бол үнэхээр ард иргэдийнхээ төлөө зарчимтай ажилладаг улсуудын ноён нуруу энэ хооронд хугардаг юм байна гэдгийг олон талаас нь ингээд харж үзлээ. Яах вэ тэгээд би хууль баталсантай холбогдуулаад нэн ялангуяа сая бас Ганбаатар гишүүний хэлсэн энэ бол улс төрийн шийдвэр биш юм. Энэ бол технологийн шийдвэр юм. Тухайлах юм бол Тэмүүлэн гишүүний хэлээд байгаа Төсвийн байнгын хорооны гишүүний хувиар тун хариуцлагагүй асуудал ярьж байгаа нь энэ Гаалийн тариф болон гаалийн татварын нэмэлт, өөрчлөлтөөр үндсэндээ энэ уурын зуухыг, уурын зуухны эд анги тоног төхөөрөмжийг гаалиар оруулж ирж байгаа юм. Энэ дээр бид нар 100 хувийн хөнгөлөлт үзүүлж байгаа юм. Энэ эд анги, тоног төхөөрөмжүүдийг бүгдийг нь угсраад зуух болж байгаа юм. Энэ зуух нь өөрөө нүүрс шатаагаад аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 90 хувийг хөнгөлж байгаа юм. Энэ дээр ямар нэгэн технологийн заалт хийлгүйгээр энэ юу руу оруулж ирсэн байж байгаа нь энэ хуульд оруулж ирсэн байж байгаа нь өнөөдөр түүхий нүүрс түлэхэд ч гэсэн нээлттэй байна л гэдэг агуулгыг илэрхийлж байгаа юм.

Тэгээд би гишүүддээ нэг зүйлийг анхааруулж хэлэхэд энэ хууль баталсантай холбогдуулаад авах арга хэмжээний тухай асуудал дээр би Байнгын хороо дээр нэг санал гаргасан юм. Өөрөөр хэлэх юм 1,5 болон түүнээс дээш байх юм бол үндсэндээ түүхий нүүрсийг зөвшөөрч байгаа асуудал хотод болж байгаа юм. Харин 15 болон түүнээс дээш болох юм бол энэ мегаваттын станцууд бүрэн шаталттай 99,99 хувийн

шүүлтүүртэй ийм дэд өртөөнүүд байх юм. Тийм учраас Байнгын хороон дээр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд саналын томъёолол оруулсан миний зарчмын зөрүүтэй саналыг та бүгд маань анхаарч үзээч ээ. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1 дээр 1,5мвт-аас гэснийг орон нутагт 1,5мвт-аас нийслэл Улаанбаатар хотод 15мвт-аас гэж өөрчлөх ийм санал оруулсан юм. Тэгэхээр Байнгын хорооны дэмжээгүй саналыг та бүгдийг дэмжихгүй байхыг хүсье. Тэгээд миний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжиж кнопдоо хүрэхгүй байхыг гишүүдээсээ хичээнгүйлэн хүсье. Нэн ялангуяа Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүдийг уриалж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар, Мөнхөөгийн Оюунчимэг нарын урилгаар Чингэлтэй дүүргийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Гочоогийн Ганболд гишүүнээр тасалсан. Зочид танилцуулчихсан. Ажлын хэсгийг ахиад танилцуулчихъя.

Протоколд үлдэх учраас. Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд, Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Зоригийн Мөнх-Оргил, Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Лувсандоржийн Мөнхжаргал. Жамбын Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Энэ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн нэмэлт өөрчлөлт орох тухай хуулийн хөнгөлөлтийг би дэмжээд байгаа юм. Тэгэхдээ сүүлийн 3 7 хоног л хэрүүл маягтай, мэтгэлцээн маягтай зөндөө зүйл боллоо. Монгол Улсын хэмжээнд цахилгааны эрчим хүч, дулааны эрчим хүч бол байнга дутагдалтай байгаа. Өнөөдөр үйлдвэрлэж байгаа хүчин чадлаасаа 2-3 дахин илүү хүсэлтүүд ирчхээд байж байгаа. Ялангуяа 21 аймаг, 300 гаруй сумдад цахилгааны богино дулааны эрчим хүч байнга дутагдалтай байж байгаа юм. Тэгээд энэ асуудлыг шийдэхэд энэ дээр юу гэдэг юм тоног төхөөрөмжийг нь оруулж авчраад, хямд үнэтэй өөрийнхөө сумд, өөрийнхөө багт өөрийнхөө аймагт таарсан үйлдвэрлэлийг явуулахад юу нь болохгүй байгаа юм. Тэгэхээр зарим хүмүүс шинэ сэргэлтийн бодлогыг унагах гэж байна энэ тэр гээд. Зүгээр нам дотор байгаа бүлэглэл хоорондын тэмцлээ хуулиар оруулж ирж байж Их Хурал дээр, Байнгын хороо дээр зодолдогоо болиоч дээ. Үнэхээр тийм бодлогын шинж чанартай, намын бодлого унах гээд байна гээд Байнгын хороо дээр орилоод байсан. Үнэхээр намын бодлого юм бол тэр намын бүлэг дээрээ яриач дээ. Санал, гомдлоо оруулж ирээч ээ. Сүүлийн 3 7 хоног Төсвийн байнгын хороог самарлаа. Их Хурлын бусад хүмүүсийнх нь дүгнэлт гарчхаад байна. Энэ чинь бүгдээрээ хэлэлцвэл, бүлээн усаар угаавал гэж дүгнэлт нь ч тэр бодит байдал нь ч тэр энэ хэрэгтэй юм гэхээр нэг л хүн хэрэггүй гээд байдаг. Тэгээд тэр хүнийг эсэргүүцсэн хүн болонгуут эх орныхоо эсрэг болдог, бүүлийдсэн болдог. Ийм байж болохгүй ээ. Яагаад вэ гэхээр 1,5мвт-аас дээш гэдэг чинь тухайн сумдаа тааруулж үйлдвэрлэнэ. 15мвт-ын гээд нэг эмэгтэйн хэлснээр нэг жижиг сумд тийм том дулаан үйлдвэрлээд илүүг нь хэн хэрэглэх юм. Хэн хэрэглэх юм. Ийм болохоор яг үнэндээ гаднаас энийг чинь Хятадын зуухнууд оруулж авчраад Монголын дулааны зах зээлийг чинь эзэлчихсэн байгаа шүү дээ. Жил болгон

солиод, төсвийн хөрөнгө тийшээ л урсаж байгаа шүү дээ. Тэгээд технологийг нь оруулж ирээд Монгол инженерүүдээ, Монгол хүмүүсээ үйлдвэрлүүлээд таарсан хүчин чадлаар нь ажиллуулъя гэхээр тэрийг нь дэмжсэн хүмүүсийг эх орноосоо урвагч, бүүлийддэг болгоод, дээрэмчин болгоод ингээд 3 7 хоног шоудаад байхаа боль л доо та нар. Та нар чинь том нам биз дээ. Шинэ сэргэлтийн бодлогыг үнэхээр унагах гээд байгаа юм бол тэр бүлэг дээрээ яриад, саналаа хураа л даа. 3 7 хоног Төсвийн байнгын хороо 3 7 хоног 1, 2 дугаар хэлэлцүүлэг гээд үймүүлээ. Өнөөдөр, маргааш чуулган хаах гэж байна. Ярих асуудлууд зөндөө байж байна. Ийм байдлаар асуудалд хандмааргүй байж байна. Яг бодитоороо энэ чинь 1000 яндан үйлдвэрлэх гэж байгаа биш, 1000 яндан байхгүй болгох гэж байна шүү дээ. Сумын төв дээр мянган яндантай байлаа 1.5 мегаваттыг үйлдвэрлэдэг хүчин чадалтай эх үүсвэр тавилаа. Тэр 1000 яндан байхгүй л болно шүү дээ. Байхгүй л болно шүү дээ. Өнөөдөр мянга мянгаар нь яндангүй болгох тэр хүчин чадалтай тэр станцуудыг чинь барингуут 5 жил 7 жил хүлээ гэж байна шүү дээ. Яахаараа 5 жил, 7 жил нэг эмэгтэй хэлснээр тэрийг дагаж бүгдээрээ дулааны эрчим хүчээ хязгаарлуулж байх ёстой юм. Яахаараа тэр хүний үгэнд орж Хятадын тоног төхөөрөмжийг жил болгон оруулж авч ирж сольж байх ёстой юм. Яахаараа тэгж үргүй зардал гаргаж байх ёстой юм. Тийм учраас нам доторх бүлэглэлийн зодооноо, хоорондын тэмцлээ энэ хуулиар оруулж ирж тэмцдэгээ боль боль. Энийгээ бүлэг дээрээ шийд та нар. Яасан арчаагаа алдчихсан юм та нар.

Г.Занданшатар: Үг хэллээ. Асуулт биш байна. Хариулах уу. Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Энэ гаалийн татвараас чөлөөлөх, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх асуудлыг нэлээн л сонслоо. Тэгээд би яах

вэ, инженер хүний хувьд нэг үг хэлье гэж бодож байна л даа. Жаахан мэддэг юмаа ярьж баймаар ч юм шиг. Үгүй ээ, 1,5мвт гэдэг чинь нэг сумын дулааныг л хангах хэмжээний 20 орчим мянган м3-ийг халаах зуухыг л хэлж байгаа шүү дээ. Үгүй ээ, тэгээд ямар чөтгөр нь тэгээд зөвхөн 1,5мвт нь нүүрс түлдэг гээд хэлчихсэн юм. Үгүй ээ, жишээ нь газаар халаадаг 1,5 байна. Цахилгаанаар халаадаг байна. Тэгээд нүүрсээр чинь бүрэн шаталттай 1,5мвт зуух зөндөө байгаа шүү дээ. Хятадын технологиор 1,5мвт-ын бүрэн шаталттай түрүүний сайдын хэлдэг шиг тэр гаргаж байгаа хорт хий тортог байдаг юм уу бүгдийг нь ингээд шүүгээд явж байгаа зуухнууд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр хамгийн гол нь манай ажлын хэсгийнхэн жаахан олигтойхон хариулт өгөхгүй ингээд л мэтгэлцээн үүсгээд л хооронд нь талхилдуулаад байх юм. Тэгээд мэргэжлийн хүмүүс чинь арай жаахан өөр ойлголт өгөөд яг саяын Батсуурь гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Үгүй ээ, энэ чинь олон айлуудын тэр нам даралтын зуухнуудыг нэгтгэж 100 айлын ч юм уу, 200 айлын дунд нь нэг төвлөрсөн зуух хийх гэж тэр гарч байгаа утаануудыг чинь цөөлөх гэж л ийм зуухнуудыг тавиад байгаа шүү дээ. Өнгөрсөн жилүүдэд Улаанбаатар хот чинь алслагдсан дүүргийнхээ бие даасан зуухтай сургууль, цэцэрлэгүүдийг газаар бие даалгаж шийдээд л яваад л байгаа шүү дээ одоо. Газын зуухаар, цахилгаанаар ч гэсэн шийдээд л яваад байгаа. Тэгээд энийгээ хамгийн гол нь дотооддоо үйлдвэрлэх тэр зуухнуудынхаа стандартыг л яам тавьж өгөх ёстой байхгүй юу. Ийм стандартын ийм шаардлага хангасан зуух үйлдвэрлэсэн дотоодын үйлдвэрлэгчид л бид нар тэр татварын болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлнэ ээ. Харин Өнөрболор гишүүний хэлээд байгаа зүгээр ингээд хар утаа хаясан, шаардлага хангахгүй тийм 1,5мвт-ын зуухыг бол зөвшөөрөхгүй гэдэг юмаа хаа хаанаа ойлголцоод явчихгүй ингээд нэг асуудлыг 2 талаас нь

мэтгэлцээд суугаад байгаа юм. Тэгэхээр энэ хууль гарсны дараа яам дахиад тэр оруулж ирэх, хөнгөлөлт үзүүлэх зуухнууддаа тодорхой шаардлага тавиад, стандарт тавиад, энэ стандартын шаардлагыг хангасан 1,5мвт-ын зуухнуудад л энэ хөнгөлөлтүүд үйлчлүүлнэ гэдэг ийм журам гаргаад явчих юм бол ямар ч маргаан мэтгэлцээн байхгүй. Өнөрболор гишүүний яриад байгааг ч би үгүйсгэхгүй. Тийм стандартын шаардлага тавихгүй бүгдийг нь 1,5мвт гээд явчих юм бол яг наад асуудал чинь үүсэх байхгүй юу. Тэр асуудлыг нь үүсгэхгүй явчих юм бол энэ ерөөсөө болохгүй зүйл байхгүй шүү дээ.

Г.Занданшатар: Энэ асуудлыг олон ургалч зүйлээр хэлэлцэж болно. Тэгэхдээ тийм хувийн болон юуны асуудал оруулж болохгүй. Ингээд асуулт асууж хариулт авч дууслаа.

Одоо “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй нэг санал байгаа.

Төсвийн байнгын хороо дэмжээгүй санал:

1.Тогтоолын төсөлд “1,5мвт-аас” гэснийг “15мвт-аас дээш хот, хөдөөгийн ялгамжтай байдлаар” гэж өөрчлөх гэснийг нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдинсүрэнгийн Өнөрболор. Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Байнгын хороо дэмжээгүй. Санал хураалт. Байнгын хорооны саналыг 62,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт

бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

15.26 цаг.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганибалын Амартүвшин танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Амартүвшин: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ. Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газрын дарга Лувсан байгаа юу. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

15.28 цаг.

Дараагийн асуудалд орно. “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ ээ.

Төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дэд дарга Жигжидийн Батжаргал танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын байгууллагаас 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдөр төрийн аудитын байгууллагын албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай саналаа ирүүлснийг Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 19 дүгээр тогтоолоор Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа түүнтэй

адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлийг баталсан бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудитор Төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн өндөр албан тушаалтны ТӨ4-А зэрэглэлд, Монгол улсын Ерөнхий аудиторын орлогч ТӨ4-А зэрэглэлд тус тус хамаарч байна.

Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.9 дэх заалтын дагуу төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах албан тушаалтны цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүрийг Монгол Улсын Их Хурал 2019 оны 63 дугаар тогтоолоороо баталсан бөгөөд уг тогтоолын 1 дэх заалтад Төрийн аудитын байгууллагын дарга, дэд даргыг хамааруулаагүй байна.

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын төрийн албаны зарим албан тушаалтны цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023 оны 241 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн хэмжээг нэмсэн бөгөөд уг асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын 2019 оны 63 дугаар тогтоолд холбогдох өөрчлөлт хийгээгүй байна.

Дээрх асуудлын хүрээнд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлд заасан журмын дагуу Монгол улсын ерөнхий аудитор, түүний орлогчийг тус тогтоолд хамруулахаар “Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж батлуулах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух гишүүн байна уу. Алга байна.

“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Санал хураалт. 65,1 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

15.32 цаг.

Дараагийн асуудалд орно. Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Пүрэвдорж: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн нарын 32 гишүүн 2023 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, анхны

хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар дээрх хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэн та бүхэнд хүргүүлсэн.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргүүлсэн өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль,

тогтоолын төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Төсвийн байнгын хороонд шилжүүлж байна.

15.34 цаг.

Дараагийн асуудалд орно. Жавхлан сайд ирсэн байна. Боловсролын ерөнхий хууль бэлэн болсон уу. 39-өөр батална шүү дээ танайх.

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын “Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцье.

Хууль санаачлагчийн илтгэл явчихсан юм. Бямбацогт сайд танилцуулчихсан. Асуулт дээр 4 хүн дутуу байгаа. Та андуурч байна. 4 нэрийг гаргачих. Цэндийн Сандаг-Очир гишүүн байсан санаж байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын 3 гишүүнээр тасалсан байгаа. Ингээд Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууж, үг хэлнэ ээ.

Б.Баттөмөр: Энэ хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаа юм. Нийт санхүүжилт нь 735 сая доллар. Үүнээс Азийн хөгжлийн банкнаас авах нь 550, буцалтгүй тусламж нь 78 сая, Засгийн газрынх нь 75 сая гээд ийм байгаа юм. Тэгээд энэ дотор юу гэхээр 25 жилийн хугацаатай хэрэгжинэ. 2 хувийн хүүтэй. 5 жилийн хугацаанд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөнө гээд их аятайхан, сайн нөхцөлтэй ийм зээл байгаа юм л даа. Тэгээд би түрүүн Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэхэд бол асуулт асуугаад, хариулт авч чадаагүй юм. Энд хэд хэдэн асуулт байна л даа.

Ер нь манай ерөнхий байдал бол их хүндэрчихсэн байгаа. Бэлчээрийн даац

30-аад хувиар хэтэрчихсэн байгаа. Нийт бэлчээр газар нутгийн 70 орчим хувь нь доройтчихсон. Мал сүргийн чанар муудчихсан. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамж муудчихсан, гаднаас импортоос нэлээн хамааралтай болчихсон. Энэ тохиолдолд гаднаас Хөдөө аж ахуйг хөгжүүлэх чиглэлд зээл авах нь зүйтэй. Гэтэл дотор талын хуваарилалт нь их сонин байгаад байгаа байхгүй юу. Тэгээд цаанаасаа ингэж тулгаж өгдөг юм уу, эсвэл өөрсдөө ийм зүйл хийгээд байдаг юм уу. Тухайлбал агро парк байгуулах, дулаан, цахилгаан, авто зам, ус зайлуулах, хог хаягдлын байгууламж гээд 395 сая доллар нь энд ингээд явчих юм байна л даа. Тэгээд энийг заавал зээл авах хэрэгтэй юм уу. Тэгээд энэ дээр баахан бүсчилсэн хөгжлийн үндэсний бодлогыг боловсруулж хэрэгжүүлнэ гээд. Хөдөө аж ахуйн байгууллага, салбар бол хамгийн олон эрдэмтэдтэй шүү дээ. Яагаад энэ эрдэмтдийнхээ хүчээр энийг хийж болдоггүй юм бэ. Заавал гаднын мөнгө авч ингэж хийх ёстой юм уу. Уур амьсгалд тэсвэртэй хөдөө аж ахуйн төлөвлөгөөг боловсруулах гэж. Яагаад эрдэмтэд нь энийг хийж болдоггүй юм бэ. 180 орон нутгийн иргэдийг сургана гэж байгаа юм. Заавал зээл авч сургах юм уу. Энийг жинхэнэ тэр ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хувьсгал гээд ярьж байгаа эрчимжсэн хөдөө аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй, зоорины аж ахуй, өвөл зуны хүлэмж гээд тулгамдсан усалгааны систем, нуур цөөрөм байгуулах гээд үгүй ээ, ийм юм руугаа хийж болдоггүй юм уу. 735 сая доллар гэдэг чинь маш том мөнгө шүү дээ. Хөдөө аж ахуйг шууд өөд нь татаад босоод ирнэ шүү дээ. 3-хан сая хүний хүнсний хангамжийн асуудал ярьж байгаа шүү дээ. Зээлийн үр өгөөжийг сайжруулна гээд би яриад байдаг биз дээ. Зээл авахыг ерөөсөө татгалзахгүй. Ялангуяа жилийн 2 хувийн хүүтэй ийм зээл бол авах хэрэгтэй. Дотор талын юмнууд нь ийм юм яваад байх юм. Тэгээд энийг ингэж болдоггүй юм уу. Тэгээд 21 дүгээр зуунд өөрөөр хэлбэл ногоон

болгоно л гээд байгаа юм. Ногоон хөгжлийн загварыг дэмжинэ гэж байгаа юм. Монгол Улсын ногоон хөгжлийн загвар гэж юу байна. Гарсан юм байна уу. Хөгжлийн загвар нь ч тодорхойгүй байгаа шүү дээ. Монголын. Тэгээд ногоон хөгжлийн загварыг дэмжинэ гээд байгаа юм. 2 дахь асуулт энэ.

3 дахь нь орчуулга энэ тэр дээрээ жосоохон юм бодвол яасан юм бэ. 1990 оноос Зөвлөлт Холбоот Улсаас салсан. Монгол Улс чинь 1924 оноос эхлээд тусгаар тогтнолоо зарлачихсан улс шүү дээ. Юу яриад байгаа юм бэ та нар. Нүүрсхүчилгүй хөдөө аж ахуй. Юу гэсэн үг юм энэ чинь. Нүүрсхүчилгүй мал аж ахуй. Эд нарт хариулт авъя.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. Болорчулуун. 87. Болорчулуун сайд биш Болорчулуун.

Ц.Болорчулуун: Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам.

Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хангамжийн аюулгүй байдал үндэсний хөдөлгөөн 5 жилийн хугацаанд гол нэрийн 19 нэр төрлийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангана гэж том зорилтыг дэвшүүлсэн. Нөгөө нэг нь бол Монголын мал сүргийг эрүүлийг баталгаажуулах, малын эрүүл мэндэд анхаарна гэсэн 2 том зорилтыг дэвшүүлсэн. Энэ хүрээнд 5 жилийн хугацаанд хэрэгжих хөтөлбөр маань нийтдээ санхүүжилтэд 1,7 их наяд төгрөг байгаа. Тэгээд энэ 1,7 их наяд төгрөгийн 34 хувь нь улсын төсвийн санхүүжилттэй, 43 хувь нь гадаадын зээл, тусламжид тулгуурласан санхүүжилт, 22 хувь нь аж ахуйн нэгжүүдэд тулгуурласан санхүүжилтээр ингээд нийт 1,7 их наядыг санхүүжүүлэхээр тусгасан байгаа. Энэ жилийн тухайд улсын төсөв дээр 127,5

тэрбум төгрөгийг тусгаж, арилжааны 10 банкнуудтай хамтарч ажиллаж, 982 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлүүдийг гаргаж байгаа. Тэгэхээр энэ төсөл маань хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх Улсын Их Хурлын 36 дугаар тогтоолын хэрэгжилт буюу яг энэ тогтоолоор баталсан 114 арга хэмжээний санхүүжилтэд хамрагдаагүй хэсгүүдийг нь энэ төсөл рүү тодорхой хэмжээнд оруулсан. Тухайлбал хүлэмжийн аж ахуйг 50 га-аар нэмэгдүүлнэ. Бусад яг хөтөлбөрт заасан асуудлуудаа энэ рүү ингээд чиглүүлээд оруулчихсан байж байгаа. Тэгэхээр бид нар эндээс нийтдээ 1 дүгээр шат нь 270 сая доллароор, үүнээс 128 сая долларыг нь хөдөө аж ахуйн салбар дээр зарцуулна гэж тусгасан. Энэ 128-аас 20 сая доллар нь бол буцалтгүй тусламж гэж гаргасан байж байгаа. Тэгэхээр бид нар яг хүнсний хангамжийн 36 дугаар тогтоолд заасан арга хэмжээнүүдээсээ энэ рүү нэлээд тусгаж өгсөн байж байгаа. Яг санхүүжигдээгүй нь. Энэ жилийн банкнуудаар явж байгаа зээлүүдээ нийтдээ 114 арга хэмжээнээс 27 чиглэлд нь зээл олгож байгаа. Тэгэхээр энэ зээлд хамрагдаагүй, нэмэлт санхүүжилт шаардлагатай зүйлүүдээ бол энэ төслийн зээл рүү нэлээд сайн хамаатуулж өгсөн байж байгаа.

Г.Занданшатар: Болорчулуун яасан нүүрс хүчилгүй мал аж ахуй гэж юу байдаг юм гэсэн шүү дээ.

Ц.Болорчулуун: Энэ найруулга дээр нь бид бас Монгол хэлний орчуулсан найруулга дээр нь анхаарч үзэхээр асуудлууд гарсан байгаа.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя. Ингээд л бурууддаг шүү та нар.

Б.Баттөмөр: Үнэхээр энэ болохгүй шүү. Ийм юм та нар хариуцлагагүй юм хийж болохгүй шүү. 20 жилийн дараа 25 жилийн дараа

Монголын бидний дараагийн үр хүүхдүүд та бид нар бол байхгүй байх. Үр хүүхдүүд төлнө шүү дээ. Ийм хариуцлагагүй юм хийж болохгүй шүү дээ. Энэ дотор их сонин юм бичсэн байгаа шүү дээ. 52 сумд нэг тийм гудамжны бүлэг, хөгжлийн бүлэг гэж байгуулах юм байна. Тэгээд даргатай, орлогчтой, тэгээд 50 хувь нь эмэгтэй хүн байна гэж байгаа юм. 51 мянган доллар зарна гээд биччихсэн. Ийм хариуцлагагүй юм хийж болохгүй шүү дээ. Та нар энэ юмнуудаа үз л дээ. Өөрсдөө үздэг юм уу. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, үзэл баримтлал гэж байдаг. Тэнд гаднын зээлийг эдийн засгийн өсөлт бий болгодог, өгөөжтэй салбарт авна гэж байгаа юм. Тэгээд та нар нэг ийм юм хийгээд ингээд яваад байж болохгүй шүү дээ. Дотор талыг нь зас л даа та нар. Зээлийг бол дэмжиж байна.

Г.Занданшатар: 84.

Д.Эрдэнэбаяр: Эдийн засаг, хөгжлийн яамны Бүс нутаг, аж үйлдвэрийн бодлогын газрын дарга Эрдэнэбаяр асуултад хариулъя.

Энэ зээлээр бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хэрэгцээгээ дотоодоосоо 100 хувь хангах зорилгоор 52 сумд хүнсний үйлдвэр, хөнгөн үйлдвэрийн томоохон үндэсний аж ахуйн нэгжүүдийн салбарыг нээхэд дэмжих ийм дэд бүтцийг барина гэж төсөвлөсөн байгаа. Аж ахуйн нэгж, иргэдээс ирдэг хамгийн гол хүсэлт нь бол орон нутгийн үйлдвэр үйлчилгээний ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан газар луу цэвэрлэх байгууламж, дулаан, цахилгаан, ус татаж өгөөч гэдэг ийм хүсэлт байдаг. Дээрээс нь үйлдвэр үйлчилгээ, тээвэр логистик, худалдааны бүсийг бий болгох саналууд маш их ирж байгаа. Нөгөө талаас Засгийн газраас явж байгаа шинэ сэргэлтийн бодлогын хот хөдөөгийн сэргэлт гээд бүлэг дээр иргэд, аж ахуйн нэгжийг орон нутагт шилжин суурьшихад нь зээлийн болон татварын дэмжлэг, дэд бүтцээр

дэмжинэ гэсэн ийм томоохон зорилтуудын хүрээнд 52.../минут дуусав/

Г.Занданишатар: 84 гүйцээгээд хариулья.

Д.Эрдэнэбаяр: Энэ 52 сумд үйлдвэр үйлчилгээ, худалдаа үйлдвэр, технологийн паркийн дэд бүтцийг энэ хөрөнгөөр шийдэхээр тусгагдсан байгаа. Нөгөө талаасаа хөрөнгө оруулалт нь Ногоон хөгжлийн сангаас орж байгаа учраас гадаад талаас тодорхой олон улсад тавигддаг шалгуурууд байгаа. Жендерийн мэдрэмжтэй, байгаль орчинд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, цэвэр технологийг ашигласан гэсэн үгнүүд бүх л төсөл дээр ижил шалгуураар орж ирдэг. Тэгэхээр энэ үгнүүд нь орчхоод байгаа учраас ингэж уншигдаж байж магадгүй. Гол хийх ажил нь бол энэ 52 сумд Монгол Улс дотоодоосоо үйлдвэрлэлээ, хүнсний хэрэгцээгээ хангадаг энэ үйлдвэр лүү чиглэж байгаа юм аа.

Г.Занданишатар: Жигжсидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Зээлийн хэлтсээр соёрхон батлахыг дэмжиж байгаа. Гэхдээ бид нар анхаармаар юмнууд байна. Тэргүүн ээлжид энийг бас эдийн засгийн үр өгөөжтэй салбар луугаа их бодитой чиглүүлж, тэр чиглүүлсэн салбар чиглэлүүд нь бас улс орны эдийн засагт, хүнсний хангамж, аюулгүй байдалд нэлээн томоохон дэм болохоор, үр өгөөж өгөхөөр ийм л юмаа илүү нарийсгаж тооцож хийх ёстой болов уу гэсэн ийм бодолтой байна. Бид нар хугацаа урттай, зээлийн хүү, үйлчилгээний зардал нь хямдхан ийм гадаад эх үүсвэр авч ашиглана гэж ярьцаагаад, зээл аваад ашиглаад байсан. Гэтэл бидэнд дутуу харсан зүйл байгаа юм билээ. Валютын ханишийн хэлбэлзлийг ерөөсөө тооцож байгаагүй ээ. Энэ өнгөрүүлсэн цаг хугацаанд ханишийн өөрчлөлтийн зөрөөгөөр зээлийн өртөгжилт их өндөр болж байгаа.

Үүнээс болоод бизнесийн салбарынх нь талдаа ч тэр Монгол Улсын Засгийн газар талдаа ч тэр зээлийн үзүүлэх дарамтын асуудал нэлээн нэмэгдэх ийм хандлагатай байна. Тийм учраас гадаадын зээл авч ашиглах үйл явцдаа бид арай өөр бодлого чиглэлээр хандаж, ер нь энэ зээлийн өртөгжилтийг нэмэгдүүлээд байгаа хүчин зүйлүүдээ тооцож харж, тэгээд зөв зүйлдээ авч ашигладаг ийм арга хэлбэр лүүгээ орох 1 дүгээрт шаардлагатай байна.

2 дугаарт ер нь дотоодын хуримтлал гэдэг юмаа эхлүүлж, хөгжлийнхөө, хөгжлийн том төслүүдийнхээ баялаг бүтээгч нараа дэмждэг хөрөнгийн эх үүсвэрээ бүрдүүлж байж өртөг хямдтай байх эх үүсвэрүүдийг дотоодоосоо дайчлах юмыг шийдэхгүй бол болохгүй юм байна. Дан ганц гадаадын зээл дээр дулдуйдаж үйл ажиллагаа явна гэж байхгүй болох нь байна шүү. Тийм учраас үүнийг анхаарах зайлиггүй шаардлага байна гэдгийг хэлье ээ. Баярлалаа.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. Үг хэлчихлээ. Дамбын Батлут гишүүн.

Д.Батлут: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Энэ зээлтэй холбоотой асуудал дээр анхаарахгүй бол болохгүй ээ бүгдээрээ. Үг нь энэ Азийн хөгжлийн банкнаас авч байгаа энэ зээлээр бол хөгжлийн томоохон зорилтыг хангах төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх ёстой гэж харж байгаа. Улс, орон нутгийн төсвөөр хийгдсэн бололцоотой ийм хөрөнгө оруулалтын ажлууд дээр гаднын зээл, тусламжуудыг авч хийж байгаа нь зарчмын хувьд буруу юм. Тийм учраас “Алсын хараа 2050”-д суусан байгаа олон томоохон хөтөлбөр зорилтуудыг хэрэгжүүлэхэд энэ зээлийг зарцуулж болдоггүй юм уу. Энэ тал дээр нэг хариулт аваадахъя. Тэгээд улс, орон нутгийн төсвөөр хийчих бололцоотой ажлууд дээр зээл авч, хөрөнгө оруулалт хийнэ гэдэг нь өөрөө тийм учир

дутагдалтай зүйл байгаа шүү гэдгийг нь хэлэх нь зүйтэй байх.

2 дугаарт нь аймаг, орон нутгуудыг сонгож байгаа нөхцөл байдал нь ямар шалгуураар явдгийг би сайн ойлгохгүй байгаа. Яах вэ 17 аймаг сонгогдсон байна. Тэгээд төсвийн гол ачаалал авдаг Өмнөговь, Орхон гэх мэтчилний аймгуудыг хасаад хаячхаж байгаа байхгүй юу. Төсөвт орлого төвлөрүүлдэг аймгууд нь бүхий л боломжуудаа дээш нь өгөөд, төвлөрүүлээд байдаг. Тэгсэн мөртөө ямар нэгэн зээл, тусламж, гаднын зээл тусламжид хамруулах болохоор хасаад хаячихдаг. Үгүй ээ, ийм бодлого байж болдог юм уу. 735 сая ам.доллар гэдэг асар их мөнгө шүү дээ. Бараг 2,5 их наяд орчим төгрөг. Тэгээд энэ мөнгөөр бид нар дэд бүтэц, үйлдвэрлэл үйлчилгээ явуулах дэд бүтцүүдийг барьж байгуулах, бизнес эрхлэгчдийг дэмжих гээд байгаа бол энэ 17 аймгаас бусад аймгуудад нь дэд бүтэц барих шаардлагагүй, бизнес эрхлэгчдийг дэмжих шаардлагагүй гэж үзээд байгаа юм уу. Харин магадгүй Орхон аймаг бусад тэр хасаад байгаа аймгууд чинь илүү энэ төсөл чинь хэрэгжих магадлалтай шүү дээ. Хүн ам олонтой тэр чинээгээрээ асуудал байдаг юм шүү дээ. Дэд бүтцээ хөгжүүлэх, цаашиаад бизнесээ дэмжих, хүн ардынхаа аюулгүй амьдралыг орлогоо нэмэгдүүлэх боломжуудыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагууд нь байдаг юм шүү дээ. Яагаад ингээд ялгавартай ханддаг юм бэ гэдэг дээр нэг хариулт өгөөч ээ. Юм болгоноос ингээд хасагдаад баймааргүй байна. Төсвийн хөрөнгө оруулалтаар ажил хийхэд ч гэсэн дандаа ялгаа заагтай хандаж байгаа. Орлого бүрдүүлдэг аймаг гэдэг юм уу, бололцоотой аймаг гэж үздэг юм уу маш багыг оруулдаг, маш бага хөрөнгө оруулалтууд оруулж байгаа, суулгаж өгч байгаа. Би зарим нэг хурал дээр нь ч хэлж байсан. Холбогдох албан тушаалтнуудыг дарга дагуулсан төсөв битгий оруулж ирцгээгээч ээ та нар.

Аймаг орон нутгуудынхаа хөгжлийг жигд хангах байдлаар төсвийнхөө төсөөллийг оруулж ирж байгаач ээ. Ингэж байж цаашаа явах ёстой шүү дээ гэдэг саналыг хэлж л байсан. Тэгээд ингээд л нэг Хөрөнгө оруулалтын ажил, зээл, тусламж гэхлээр л дандаа орлого төвлөрүүлдэг аймгуудыгаа хасчхаад явах юм. Манай аймаг гэхэд энэ жил улсын төсөвт 143 тэрбум төгрөг төвлөрүүлж байгаа. Сая төсвийн тодотгол дээр гэсэн чинь 21 тэрбумыг ахиад нэмээд хаячихсан байгаа. Үгүй ээ, тэр Орхон аймаг чинь тэгээд яаж цаашидаа амьдрах юм бэ. Хөрөнгө оруулалтаа яаж хийх юм бэ. Энэ мэтчилний асуудлууд дээр жоохон жигд, хүртээмжтэй хандаж баймаар байна. Асуултдаа хариулт авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд хариулъя.

Б.Жавхлан: Батлут гишүүний асуултад хариулъя. Эрхэм гишүүн ээ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд “Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан байгаа. Энийг та манай дунд урт хугацааны хөгжлийн томоохон хөтөлбөр асуудал биш гэж арай хэлэхгүй байлгүй дээ. Үүний дагуу ч тэр, Засгийн газар шинэ сэргэлтийн бодлогын хүрээ гээд Улсын Их Хурлаас батлагдсан төлөвлөгөө байж байгаа. Тэр дотор хүнсний аюулгүй байдал, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил, аж үйлдвэр гээд бүх асуудлуудтай энэ төсөл маань өөрөө бүрэн уялдаа холбоотой, хэрэгжих хугацаа нь 7 жил, зээл эргэн төлөгдөх хугацаа нь тэрнээсээ цаашаагаа 25-30 жилийн хугацаатай ийм төсөл хөтөлбөрүүд байгаа юм. Хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил гэхээр бид хөдөө орон нутагт бий болж байгаа, анхан шатанд бий болж байгаа өртөг

шингээсэн мал аж ахуйн гаралтай, газар тариалангийн гаралтай энэ бүтээгдэхүүнүүдийг өрсөлдөх чадвартай болгох, анхан шатных нь дэд бүтцүүдийг бий болгох, тэнд боловсон хүчнийг нь бэлдэх гээд маш олон талтай ийм төсөл хөтөлбөрүүд бүсчилсэн хөгжлийн агуулгаар ингэж хийгдсэн байгаа. Тэрнээс биш нэг сумыг хөгжүүлэх гээд байгаа асуудал биш. Тэр сумаар дамжаад газар зүйн байрлалын хувьд бүс нутгийн бүсчилсэн байдлаар, хүртээмжтэй байдлаар цаашаага тархах дамжих ийм хөгжлийн гинжин бүтцээр газар зүйн байрлалаар сонголтууд хийгдсэн байгаа. Ийм асуудлууд байгаа. Тэгэхээр боломжтой гэдгээр нь 1 дүгээрт биш шүү. Одоо байгаа, бий болчихсон байгаа дэд бүтэц болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнүүдийнх нь түүхий эд зэрэг өрсөлдөх чадварынх нь үзүүлэлтүүдийг харж ингэж сонголтууд хийгдсэн байгаа. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдын Засгийн газар энэ төслийг анх судалгааных нь түвшинд хүлээж авахад гуравхан аймаг байсан шүү. Энэ дүн дээр баруун гуравхан аймаг байсан. Харин энийг өнөөдөр нэлээн хүртээмжтэй болж бүсчилсэн хөгжлийн суурь газар зүйн байрлал, тэр агуулга дээр нь үндэслэж 17 аймаг 52 суурин газар дээр илүү их хүртээмжтэй байдлаар ингэж хийгдсэн байгаа. Тийм учраас энийг зүгээр орон нутгийн төсөв хөрөнгөөр хийгдэх ажлууд гэж үзэж болохгүй шүү. Энд маш олон дэд бүтцийн асуудлууд байгаа. Дээрээс нь олон улсын байгууллагуудын олон улсын түвшний стандартаар тавьдаг гэрээ хэлэлцээрүүдийг дагаж хийгддэг ийм сургалт, буцалтгүй тусламж гээд урьд өмнө нь байгаагүй, урьд өмнө нь аль ч зээлүүд дээр багтаж байгаагүй нэн хөнгөлөлттэй, манай талд илүү их хүртээмжтэй, ээлтэй ийм зээл байгаа. Энийг бид нэлээдгүй лоббидож байж, олон улсын байгууллагуудад ажиллаж байгаа. Монголын талаас ажиллаж байгаа маш олон том бүтэц бүрэлдэхүүнээр энийг хөөцөлдөж байж ингэж орж ирж байгаа. Энэ бол ганцхан

Азийн хөгжлийн банк ч биш. 3 санхүүгийн институт, дээрээс нь тодорхой хэмжээнд 10 хувь дээр нь Монголын Засгийн газраас үүрэг хүлээж оролцож байгаа ийм бүтэцтэй томоохон төсөл байгаа юм. Тийм учраас хүнсний аюулгүй байдал, хот, хөдөөгийн тэнцвэртэй хөгжил гээд томоохон дунд, урт хугацааны хөгжлийн бодлоготой маш сайн уялдсан, тэдгээрийнхээ суурь нь болж цаашаага ингэж явах ийм төсөл байгаа юм аа. Тэгээд тэр аймгуудын хувьд ямар.../минут дуусав/

Г.Занданшатар: 84. Ажлын хэсэг.

Д.Эрдэнэбаяр: Аймгуудын шалгуур дээр маш олон судалгаануудыг хийсэн. Жайкагийн олон улсын байгууллагуудтай хамтарсан 2 жилийн судалгаа, Азийн хөгжлийн банкны 3 жилийн судалгаа, Монгол Улсын Шинжлэх Ухааны академийн 100 орчим эрдэмтэд ажиллаж байгаад хөгжлийн ирээдүй сайтай 69 байриил буюу түүхий эд бүтээгдэхүүнээ дотоод, гадаад зах зээл дээр гаргах ийм нийлүүлэлтийн сүлжээ тээвэр логистикийн хамгийн стратегийн байршлуудыг сонгосон. Энэ дотроосоо хамгийн гол хүнсээр өнөөдөр Монгол Улсын хэрэгцээг хангаж байгаа 52 сумыг сонгож байгаа. Нөгөө үлдэж байгаа хэсэг нь илүү уул уурхай, олон улсын тээвэр логистиктой холбоотой учраас тэр сумуудыг өөр төслийн хүрээнд шийдвэрлэх нь зүйтэй юм аа. Энэ төслийн хүрээнд бид нар илүү 2-3 жилийн хугацаанд дотоодын хүнсний хэрэгцээгээ 100 хувь хангах тээвэр логистикийн ийм сүлжээг байгуулах чиглэл дээр хийсэн. Яг тухайлсан Эрдэнэт, Булганы тухайд маш олон хэлэлцүүлгүүдийг газар дээр нь хийгээд Эрдэнэтийн гол үйлдвэрүүдээс хүсэж байгаа зүйл бол нийлүүлэлтийн сүлжээ буюу анхан шатаасаа Булган аймаг дээр байж байгаа ашигтай байршлуудаас түүхий эдээ татаж, эцсийн бүтээгдэхүүн болгож боловсруулах нь чухал байна гэдэг хүсэлтийг удаа дараа тавьсан учраас бид нар Булган аймгийн

болон Сэлэнгэ, Дарханы бүсэд байгаа гол гол стратегийн байршлаас Эрдэнэтийн үйлдвэрийн бүс рүү түүхий эд нийлүүлэх дээр анхаарсан. Эрдэнэт өөрөө одоогийн суурилагдсан инженерийн дэд бүтэц харьцангуй сайн байгаа.

Нөгөө талд Хөдөө аж ахуйн яамнаас явж байгаа 980 тэрбумыг Эрдэнэтийн үйлдвэрүүд ашиглах бүрэн боломжтой байгаа. Энэ төслийн хүрээнд ч гэсэн олгогдож байгаа зээлийг аваад, үйлдвэр лүүгээ хийх боломжтой байгаа. Гагцхүү дэд бүтцийг нь сайжруулах гэдгээрээ л ялгаа байгаа болохоос бусад аймаг сум аж ахуйн нэгжүүд бол зээл аваад ашиглах бүрэн боломжтой.

Нөгөө талаасаа эхний үе шатад хэрэгжих 78 сая доллар нь буцалтгүй тусламж байгаа. Тийм учраас дараагийн 2 дахь, 3 дахь үе шат дээр байгаа зээлийг бид нар заавал ашиглах үүрэг хүлээхгүй. Тийм учраас буцалтгүй тусламжийн үр дүнгээс хамаараад цаашид хэрхэн энэ төслийг үр ашигтай хэрэгжүүлэх вэ гэдэг дээр тухай тухайн үед нь шийдэл гаргаад явах бүрэн боломж байгаа юм аа.

Г.Занданишатар: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе ээ. Энэ зээлийг зарчмын хувьд дэмжиж байгаа. Гэхдээ зээл авах сайхан, авч байх үед бас дараа дараагийн хүндрэлүүдийг бас нэг их тооцохгүй авчих гээд байдаг ийм тал байгаа. Энэ чинь хэдийгээр сайн нөхцөлтэй, хүү багатай боловч тодорхой хугацааны дараа татвар төлөгчдийн мөнгөөр л эргүүлээд л төлөх ийм л зээл. Тийм учраас энэ зээлийн үр дүн нэлээн тийм тодорхой байгаасай билээ гэж ингэж хүсэж байгаа юм. Ялангуяа зээлийн ангилал дотор би хөдөө аж ахуйтай холбоотой асуудал дээр 2, 3 санал хэлмээр байгаа юм аа.

1 дүгээрт энэ зээл маань өөрөө хүнсний аюулгүй байдал, хот хөдөө урт хугацаагийн хөгжил гээд олон зүйлүүдийг шингээж зээлийн батлах ийм ажил явагдаж байна л даа. Тэгэхээр миний хувьд бол хөдөө аж ахуйн салбар дээр тулгамдаад байгаа 2, 3 асуудлыг энэ зээлийн хөрөнгөөр шийдэх бололцоо байгаа юу. Энэ зээлийн төсөл дээр бичсэнээр бол энийг Хөдөө аж ахуй яам оруулж ирсэн юм уу, эсвэл зээл өгөх гэж байгаа газар маань ингэж хийх нь зүйтэй гэж ингэж үзсэн юм уу. Би бол хөдөө аж ахуйн салбар дээр нэг тулгамдаад байгаа асуудал бол малын халдварт өвчин. Үүнээс шалтгаалаад мал махны экспорт олон юмнууд гацаж байгаа. Монгол гэхдээ био комбинаттай хэдэн төрлийн вакцин хийдэг гэхдээ тэр нь хүрдэггүй. Унгарын Засгийн газраас хөнгөлөлттэй зээл аваад хийх гэсэн боловч бүтэлгүйтсэн. Тэгээд энэ зээлийн хөрөнгөөс био комбинатынхаа үйл ажиллагааг өргөжүүлээд энэ 70 сая малаа эрүүлжүүлэх ажлыг хийх бололцоо байхгүй юу. Энэ бол олон эдийн засгийн хувьд их үр өгөөжтэй болно гэж ингэж бодож байгаа юм. Хэрвээ энийг хийхгүй ээ, Био Комбинатыг өргөжүүлнэ, бид энийг шийднэ гэж байгаа бол хөрөнгийн эх үүсвэр нь байгаа юм уу. Байгаа бол яг хэдэн төгрөг хаана тавигдах гээд байгаа юм. Би бол ердөө олж хараагүй байгаа.

2 дугаарт. Энэ 70 сая малынхаа түүхий эдийн эргэлтийг бид нар бас л хийж чадахгүй л байгаа. 20 сая малынхаа арьсны түүхий эдийн талыг нь боловсруулдаг гэж ярьж байгаа боловч энэ худлаа тоо. Тэрийг тоолсон ч юм байдаггүй юм байна лээ шүү дээ. Ер нь бол. Яг амьдрал дээрээ. Дарханд нэг юм хийх гэсэн тэр бүтэлгүйтсэн. Өнөөдөр шүүхийн шатанд маргаантай явж байгаа байх. Сарын өмнө бид нар Эмээлт дээр дахиад нэгийг эко байгуулна л гэсэн. Парк байгуулна л гэсэн. Энийг бас үүгээрээ шийдчихэж болохгүй юм уу. Энэ 2-ыг хийж чадвал хөдөө аж ахуйн салбар дээр бол маш их ахиц дэвшил гарна. Энэ олон сая мал бэлчээр доройтож байгаа

гэж байгаа энэ асуудал шийдэгдэнэ. Малчдын нийгмийн даатгалыг төр төлөх гээд байна гэдэг малчдын орлого сайжирна. Өөрсдөө нийгмийн даатгалаа төлчихнө. Эргээд 10 жилийн дараа, 20 жилийн дараа зээлээ төлөхөд энэ салбар чинь өөрөө нэлээн том ахиц дэвшил үзүүлэх юм биш үү. Эндээс ингээд харахад 180 орон нутгийн иргэдэд суурилсан малын эрүүл мэндийн ажилтан сургана энэ тэр гэсэн нэг ийм л зүйлүүд байгаад байгаа юм. 20 жилийн дараа энэ яг үр өгөөжөө өгөх юм уу. Яг бид нар бодитой юм дээр энэ зээл гэдэг юм чинь ингээд шингээд, улс орны эдийн засагт дорвитой өөрчлөлт оруулах ийм л 2, 3 том зүйл рүү оруулж болдоггүй юм уу. Ингээд л тал тал тийш нь сэглэсээр байтал энэ чинь үнийн дүн нь том боловч гарч байгаа үр дүн тийм өөдтэй байж чадах уу, үгүй юу. Тэгээд тэр эко парк, Дарханы паркийн арьс ширний үйлдвэр дээр магадгүй бид нарыг хийх гэж байгаа гэж байгаа бол төсөв хөрөнгийнх нь эх үүсвэр яг хаана байгаа юм. Мэдэхгүй 2023 оны төсөв дээр лав юм тавигдсаныг би санахгүй байна. Иймэрхүү нэг бодитой юмнууд хийхгүй бол бид нар өр зээл тавиад, өнөөдөртөө зээл авч байгаа нь ажил хийх гэж байгаа юм шиг харагдавч 20 жилийн дараа төлөхөд наадах чинь асуудал үүсгэх вий дээ гэсэн миний санал ийм байна. Тэгээд би Био Комбинатын санхүүжилт, нөхцөл байдал, Дарханы Эмээлтийн экогийн төсөв хөрөнгө гэж ямар юмнууд хаана.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ.
87. Болорчулуун.

Ц.Болорчулуун: Идэрбат гишүүний асуултад хариулт өгье. Энэ төсөл хэрэгжих гэж байгаа 17 аймгийн 52 сумын дунд өвчнөөс ангид 12 байгууламж, 6 аймаг болон 6 сум дундын түвшний мал эмнэлгийн лабораториудыг чадавхжуулна гээд төсөв хөрөнгө тавьчихсан байж байгаа. Био комбинатын хувьд бол Дэлхийн банкны төслөөр бид нар санхүүжилт хийж Био

комбинатынхаа шинэчлэлийг хийе гээд ингээд Дэлхийн банкны 100 сая ам.долларын зээлийн төсөл явж байгаа. Энэ дээр тодорхой тусгаж өгсөн. Био комбинат бол нийтдээ 20 гаруй төрлийн вакцин хийж, үйлдвэрлэж байгаа боловч 1973 онд байгуулагдсан дэд бүтцийн хувьд нэлээд доройтсон, нэлээд хуучирсан ийм байдалтай байгаа. Тийм учраас дэд бүтцийг нь шинэчилье, бусад вакцин үйлдвэрлэлээ нэмэгдүүлье, вакциныхаа шинэ шугамуудыг барья гэдэг байдлаар Дэлхийн банкны төсөлд Био комбинатыг яг бүхлээр нь дангаар нь ингэж явуулж байгаа.

Эмээлтийн парк бас Дэлхийн банкны төслөөр хэрэгжихээр ТЭЗҮ, судалгааных нь ажлууд эхлээд явж байгаа. Нийтдээ 69 сая ам.долларын санхүүжилттэйгээр Эмээлтийн үйлдвэр технологийн паркийн дэд бүтцийг хийхээр ТЭЗҮ-г нь Дэлхийн банктай хамтраад боловсруулаад явж байгаа.

Г.Занданшатар: Болдын Жавхлан сайд гүйцээж хариулъя.

Б.Жавхлан: Хөдөө аж ахуйн яамны хариулт дээр нэмж хариулт өгье. Сайн, гүйцэд хариулж өгөхгүй юм. Идэрбат гишүүний асуултад хариулъя. Ингэж ойлгоорой. Энэ төсөл бол хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамж, ялангуяа хөдөө аж ахуйн гаралтай, мал малын гаралтай хүнсний хүртээмжийг нийт орон даяар анхан шатны боловсруулалт хийж, тэнд хадгалах, түгээх сүлжээг бий болгох гэж байгаа ийм төсөл юм байгаа юм. Био комбинат бол энэ чинь эцсийн бүтээгдэхүүн хийх төвлөрсөн үйлдвэр аж үйлдвэрийн асуудал байхгүй юу тусдаа асуудал. Тийм учраас ингэж салгаад Био Комбинатыг бид нар Дэлхийн Банк дээр 100 сая долларын төсөл хэрэгжүүлбэ гээд хэлэлцээр эхэлчихсэн ингээд явж байгаа. Эмээлт дээр мөн Дэлхийн банкны харьяа Ай Эф Си-ээс буцалтгүй тусламжаар ТЭЗҮ-г нь хийгээд боловсруулалт хийгээд явж байгаа юм шүү. Тийм учраас энэ

төсөл хөтөлбөр бол дахиад хэлье Бүсчилсэн ногоон хөгжлийн ийм анхан шатын бэлтгэн нийлүүлэх, анхан шатын боловсруулалт хийх ийм орон даяар дамнасан сүлжээг бий болгох ийм төсөл юмаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хураалтыг маргааш 39 гишүүн байна уу Тогтохсүрэн дарга аа.

Эцэслэн батлах санал хураалтыг маргааш өглөө 10 цагаас явуулна. Хойшлууллаа. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Эцэслэн батлах, соёрхон батлах тухай.

16.08 цаг.

Дараагийн асуудал орно. Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2023 оны 5 дугаар сарын 4, 16-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед эцсийн хэлэлцүүлгийг бэлтгэсэн зарим зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэгт дахин хэлэлцүүлэх горимын санал дэмжигдсэн тул Байнгын хороо 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаараа Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг дахин явууллаа.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан 6 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан хуулийн төслийн зарим зүйл, заалтаар дахин санал хураах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь үзсэн тул 3 зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Нийт 9 санал байгаа. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн асуулт асууна.

Б.Энх-Амгалан: Боловсролын ерөнхий хуультай холбоотой асуудлыг би анхнаас нь дэмжиж ирсэн. Энэ хуультай холбоотойгоор хэлэлцүүлгийн явцад 2, 3 санал гаргасан. Тэрнээсээ болоод нийгмийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр баахан доромжлууллаа. Тэгээд би зүүгээр 1 л зүйлийг хэлэх гэсэн юм л даа. Энэ хуулийн заалтыг би та бүхэнд бүр уншиж өгье.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн 3 дугаар бүлгийн 18 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад байгаа юм.

Боловсролын сургалтын байгууллага гэдэгт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллеж, дээд сургууль, их сургууль багтана гэж. Ингээд эд нарыгаа бүгдийг нь багтаагаад боловсролын сургалтын байгууллага гэдэг нэр томъёо дотор багтааж байгаа юм. Гэтэл тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дугаар заалтад боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэл нь Англи хэл байна гээд заачихсан юм. Тэгээд би гадаад хэл эсэргүүцээд байгаа юм

ерөөсөө биш байхгүй юу. Гадаад хэл сургаж болохгүй гээд байгаа юм ерөөсөө биш. Боловсролын сургалтын байгууллагууд гэдэг дотор чинь цэцэрлэг орчхоод байгаа учраас би Монгол хүний хувьд хэл дагаж сэтгэлгээ явдаг юм. Битгий хар багаас нь гадаад хэл заа. Монгол эх хэлнийх нь дархлаа сууг ээ, сэтгэлгээ нь сууг ээ, хэлний дархлааг нь битгий алдагдуулаач л гэж хүсээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр аваачаад ингээд ийм хуульд ийм юм оруулчихаад Англи хэлийг жадлан эсэргүүцэгч гээд нэр, цол зүүгээд ингээд яваад байх юм. Үгүй ээ, тэгээд тэр хэлнийх нь дархлаа суусан хойно нь хүссэн хэлээ сураач дээ. Би Монголчууд нэг биш нэлээн олон гадаад хэл сураасай гэж боддог ийм үзэл бодолтой хүн. Тэгээд ингэж хэлснийхээ төлөө аваачаад ингээд Англи хэлийг эсэргүүцэх ч ерөөсөө жадлан эсэргүүцдэг бузар булай амьтан гээд зарлаад байх юм. Ямар учиртай юм. Хэдэн ч хэл сурч болно шүү дээ. Харин битгий ингээд цэцэрлэгээс нь хэл зааж дархлааг нь алга болгочих гээд бай л гэж хэлсэн болохоос биш. Тэгээд энэ хууль чинь яг энүүгээрээ ингээд орчхож байна шүү дээ. Тэгээд ингээд цаашаа явах юм уу.

Г.Занданшатар: Гонгорын Дамдинням гишүүн, ажлын хэсгийн ахлагч хариулна.

Г.Дамдинням: Боловсролын ерөнхий хуулийн хэлэлцүүлэг явагдаж байхад тал бүрийн санал гарч ирээд, элдэв үл ойлголцол гарсан бол бас зарим эрхэм гишүүдээсээ уучлал хүсье. Үзэл бодлоо илэрхийлж, ардчиллынхаа үнэт зүйлийг бид нар хадгалж, парламент дээрээ хэлэлцэж байгаа учраас тал бүрийн санал гарах нь зүй ёсны асуудал. Я Ялангуяа энэ хэлэлцүүлэг өрнөснөөс болж манай Байнгын хорооны дарга Мөнхцэцэг гишүүн бол Монгол хэлний ач холбогдлыг өндөрт өргөх ёстой, эх хэлний асуудлыг өндөрт өргөх ёстой

гэдэг үнэхээр чухал саналыг гаргасан. Манай Чинбүрэн гишүүн бас энэ дээр гаргаж ирсэн. Тийм учраас эцсийн томъёолол бол гишүүдийн маань хэлсэн томъёоллоор орж ирж байгаа. Мөн Батшугар гишүүн болоод бусад гишүүд бол зөвхөн Англи хэл гэж хязгаарлаад байгаа гэдэг асуудлаар ярьсан учраас бид бүхэн бусад хэлийг нээлттэй үзэж болно, чөлөөтэй шүү гэдэг заалтыг оруулж ирж, энэ заалт маань бүр илүү дэлгэрэнгүй тодорхой болсон. Их Хурлын дарга маань ч гэсэн өөрөө найруулга, засвар дээр маш сайн редакц хийж өгч, бид нарт дэм тус болсон. Тэгээд ер нь бол манай Б.Энх-Амгалан гишүүний яриад байгаа боловсрол сургалтын байгууллага гэдэгт бас бага насны хүүхдүүд ороод байна гэдгийг ажлын хэсэг, Байнгын хороо аваад зөвхөн сургалтын гээд явсан шүү Энх-Амгалан гишүүн ээ. Тэгээд ер нь бас тал бүрийн байр суурийг илэрхийлж, боловсролд хэрэглэгдэх үндэсний хэл, эх хэл, үндсэн гадаад хэл болон бусад хэлүүдийн талаар илүү дэлгэрэнгүй тодорхой байр суурь илэрхийлж томъёолоход хувь нэмрээ Монголын ирээдүйн хүүхдүүдийнхээ төлөө санаа чилээж, зөв байр суурь илэрхийлж, тал талаасаа хамгийн эцсийн ойлгомжтой сайхан томъёоллыг оруулж ирэхэд дэм болсон эрхэм гишүүддээ талархал илэрхийлье. Тэгээд саяынх бол ийм учиртай байгаа шүү. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Энх-Амгалан гишүүн, Чинбүрэн гишүүдийн хэлж байсан санал хууль зүйн үндэслэлтэй байсан гэдгийг тодотгоод, Байнгын хороо ахиж хэлэлцсэн учир шалтгаан болбоос сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

Боловсролын сургалтын байгууллагад судлах үндсэн гадаад хэлийг сургалтын хөтөлбөрт заана гэсэн ийм 1 заалт нь 2-ыг орчихсон байхгүй юу. Тэгэхээр энийг нөгөө хэл дээр 2 маргалдаад байгаа тал нь аль нэг нь ч унагаалаа гэсэн дагаад хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хөндчихөөд байсан.

2 дугаарт нь эх хэлээрээ суралцах бололцоог хангах Казах иргэдийн ч болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Япон, Солонгос, Орос, Хятад, Франц, Герман гээд 10 гаруй хэлээр явагдаж байгаа сургалтын байгууллагуудын хэлийг хүчилж хориглочих гээд байгаа агуулгатай байсан учраас энэ дээр хэлэлцээд, 2 талын асуудлыг зохицоод тэгээд яг учрыг нь олохгүйгээр ингээд улс төржүүлээд 2 талд нь сошиалаар ч гэсэн буруу ойлголт сэвээд, нийгэмд буруу ойлгосон. Тэгээд боловсролын хуулийн үндсэн зорилго бол орчин үеийн, дэлхийн түвшний хэлтэй, боловсролтой, чадвартай, мэдлэгтэй, Монгол хэлтэй, Монгол соёлтой Монгол хүнийг бэлтгэхэд чиглэж байгаа гэдгийг л онцолж байна.

Гадагшаа гараад явчих хүн бэлдэх гэж байгаа хэрэг биш шүү дээ. Монгол хэлтэй, Монгол соёлтой хүнийг бэлдэх ёстой гэсэн энэ агуулгаар энэ өөрчлөлтийг оруулж, ингээд талууд бүгд зөвшилцөлд хүрч, санал нэгдээд орж ирж байна гэж ойлгож байгаа шүү дээ. Тийм үү. Тийм биз Дамдинням гишүүн ээ. Энийгээ та хэлэх ёстой байсан тийм биз Чинбүрэн гишүүн ээ. Чинбүрэн ч гэсэн маш зөв санал гаргасан.

Ингээд Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Зөв шийдэл, гарц гаргалгаа гарч, нэгдсэн ойлголцолд хүрээд тэгээд хэл соёлыг хамгаалахын зэрэгцээ Англи хэлийг бүгдээрээ дэмжиж байгаа гэдэг дээрээ, зөвхөн Англи хэл биш ер нь гадаад

хэл сурах асуудлыг ер нь хязгаарлахгүй, хориглохгүй дэмжиж хөгжүүлэх хөтөлбөр батална гэсэн ийм тодорхой санаанууд туслаа шүү дээ.

Ингээд санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. 9 санал байна.

Нэг.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо дэмжсэн санал:

Нэг.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Энд ахиж цохон тэмдэглэхэд энэ дээр асуудал үүссэн юм бол Байнгын хороон дээр дэмжигдсэн саналын томъёолол чуулганд орж ирэхдээ өөрчлөгдсөн байсан I.

2 дугаарт нь Байнгын хороон дээр дэмжигдсэн саналуудыг тус бүрдээ санал хураалт явуулсан байсныг Их Хурлын чуулганд санал хураахдаа нэгтгээд оруулж ирсэн байсан. Ийм зөрчил гарсан гэдгийг холбогдох Байнгын хорооныхон хүлээн зөвшөөрч, Улсын Их Хурлын Тамгын газраас ажлын хэсэг хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргаж, протоколыг үзэж танилцаад ийм зөрчлүүдийг илрүүлсэн болохыг мэдээлье.

1.Төслийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12.9.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сул орон тоонд аймаг, сум, баг, дүүрэг, тосгоны удирдлагын захиалгаар, эсхүл өөрийн хүсэлтээр 3-аас доошгүй жил мэргэжлээрээ ажиллах гэрээ байгуулсан багиуд төрөөс дэмжлэг үзүүлнэ. Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. Асуулт байхгүй л дээ. Энэнээс

чинь ер нь үг хэлэхээр л ингээд л бүх юм гагцхих гээд байгаа юм.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтан өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу тэтгэмжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт 81,6 хувийн саналаар санал дэмжлээ. Дотоод журмаар шийдчих юмнууд л байгаа юм.

3.Төслийн 21 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21 дүгээр зүйл. Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу эрх бүхийн этгээд олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, ЕБС мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж, хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний сургалтын хөтөлбөрөөр

боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгуулан шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Хамтран гэнэ хэнтэй хамтрах юм. Хэнтэй хамтарч шийдвэрлэх юм. Дипломат төлөөлөгчийн газар чинь Гадаад яамтайгаа хамтарна гэж байхгүй шүү дээ. Хамтран гэдэг үгийг найруулга дээр анхаараарай. Санал хураалт. Нэг бол Боловсролын яамтай хамтарна гэж бичих ёстой. 73,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 22, 23 дугаар зүйлийг 22 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

22 дугаар зүйл. Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавих шаардлага

22.1.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан болон доор дурдсан баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд б-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчийн гэрээ, танилцуулга;

22.1.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

22.1.3.стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлага хангасан хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

22.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

22.1.5.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааг санхүүжүүлэх мөнгөн болон бусад хөрөнгийн жагсаалт, хэмжээ, баталгаа, эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.6.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;

22.1.7.ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг, сургуулийн өмнөх, ерөнхий боловсролын сургалтын байгууллагад нийт багшийн 90-ээс доошгүй хувьд мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын байгууллагад нийт багшийн 80-аас доошгүй хувьд мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг;

22.1.8.цэрэг, цагдаа, төмөр замын мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын санал;

22.1.9.боловсролын сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн

мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, ял шийтгэл хүлээж байсан эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

22.1.10. татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

22.2. Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагад шилжүүлж болно.

22.3. Энэ хуулийн 22.2-т заасан эрх хүлээн авагч Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, шийдвэр гарган эрх шилжүүлсэн байгууллагад тайлагнана.

22.4. Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх хэсгийн 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох шийдвэр гаргана.

22.5. Мэргэжлийн, техникийн, дээд боловсролын шинэ мэргэжлийн, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх зөвшөөрлийг хүсэлт гаргахад Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичиг болон энэ хуулийн 22.1.3-22.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх үйл ажиллагааны танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эрхлэхээс 5-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд цахимаар ирүүлнэ.

22.6. Энэ хуулийн 21.1-д заасан этгээд хуульд заасан нөхцөл, шаардлага

хангасныг нотолсон баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийн хамт үнэн зөв бүрдүүлэх эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

22.7. Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой шинэ мэргэжлээр сургалт эрхлэх хүсэлтийг шийдвэрлэхэд энэ хуулийн 22.5-д заасан хугацаа хамаарахгүй.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Энэ чинь хэдэн хуудас юм болчхов. Санал хураалт явуулъя. 85,7 хувийн саналаар санал дэмжигдлээ

5. Төслийн 24, 25 дугаар зүйлийг 23 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

23 дугаар зүйл. Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

23.1. Сургуулийн өмнөх, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас доошгүй байна. Ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрлийн хугацаа 12 жил байна.

23.2. Зөвшөөрлийн хугацааг зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3. Энэ хуулийн 22.1.10-д заасан татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 42 гишүүн дэмжиж 85,7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 26 дугаар зүйлийг 24 дүгээр зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

24.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

24.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

24.1.2 зөвшөөрлийг хүчингүй болгосон;

24.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

24.1.4.нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

24.1.5.хуульд заасан бусад.

24.2.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдох эд хөрөнгийн харилцааг Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

24.3.Татан буугдсан боловсролын сургалтын байгууллагын сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох баримт бичгийг орон нутгийн болон үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.

24.4.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах шийдвэрийг тухайн хичээлийн жилтэй уялдуулж суралцагчийн сурах эрхийг хөндөхгүйгээр эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 87,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон

гишүүдийн 3-ны 2-оос доошгүйг нь дахин санал хураалгах шаардлагатай хэмээн үзэж боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

1.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалтыг төслөөс хасаж, 6.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5 дахь хэсгийг нэмэх:

“6.3.боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 6.4-д заасан агуулгыг монгол хэлээр эзэмшүүлэхээс гадна тухайн боловсролын сургалтын байгууллагын төлөвлөгөөнд заасан гадаад хэлийг судлахад энэ хуулийн 6.1-д дэх хэсэг хамаарахгүй.

6.5.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.”

Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт байна 85,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, коллеж, дээд сургууль болон их сургууль нь дараах тохиолдолд” гэснийг “Зөвшөөрлийн тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан дараах боловсролын сургалтын байгууллага” гэж, мөн зүйлийн 6.4 дэх хэсгийн “Монголын түүх, хэл зохиол, үндэсний бичгийн” гэснийг “монгол хэл, үндэсний бичиг, уран зохиол, монгол, монголын түүхийн гэж өөрчилж, мөн зүйлийн 6.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.1.Монгол улсад боловсрол эзэмшүүлэх сургалтыг төрийн албан ёсны хэлээр явуулна. Сургалтын үндсэн гадаад хэл нь англи хэл байх бөгөөд эх

хэлээрээ суралцах болон бусад гадаад хэл суралцах эрхийг үл хөндөнө.” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо.

Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн үг хэлнэ. Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: За би энэ дээр болсон процессыг хэлье. Ер нь бол Боловсролын байнгын хороо бас бид нарын хэлж байсан зүйл заалтуудыг тусгаж, Монгол Улсад боловсрол эзэмшүүлэх сургалтыг төрийн албан ёсны хэлээр буюу монгол хэлээр сургах асуудлыг энд оруулж өгсөн.

2 дахь чухал зүйл бол бусад гадаад хэл сурах эрхийг үл хөндөнө гэдэг зүйл оруулсан. Гэлээ гэхдээ сургалтын үндсэн гадаад хэл гэдгийг бид би бол өөрөө тэргүүлэх хэл гээд 1997 оны Засгийн газрын тогтоолд хүртэл тэргүүлэх хэл нь Англи хэл байна гээд оруулж өгч болж байсан юм дээр ингээд оруул гэдэг зүйл дээрээ тууштай зогсож байгаа.

Ер нь тэгээд сая Энх-Амгалан гишүүний хэлдгээр энийг эсэргүүцэний төлөө англи хэлийг эсэргүүцэж байна гэдэг нь ар-аа болиоч ээ. Ер нь энэ зааланд сууж байгаа улсууд гишүүд бүгд англи хэл тэртээ тэргүй хэрэглээ болчихсон, тэртээ тэргүй гадаадад гарах гарц маань англи хэл. Энийг бүгд ойлгож байгаа. Түүнээс энд бол язгуур эрх ашиг буюу хэл, соёл хамгаалах, Монголоороо үлдэх гэдэг асуудал дээрээ би үнэнч байгаа. Энэ асуудлаа хүртэл энд зориуд протоколд тэмдэглүүлж үлдээх хүсэлтэй байгаа тул би үг авсан юм аа. Тийм учраас энэ дээр уг нь сургалтын үндсэн биш сургалтын тэргүүлэх гадаад хэл нь англи хэл гэсэн бол илүү зохилтой санагдаж байсан юм. Энийг зориуд тэмдэглүүлж байна аа.

Г.Занданшатар: Протоколд тэмдэглүүлж байна. Суралцах гэдгээрээ өөрчилж байгаа тээ. Санал хураалт

явуулъя. 37 гишүүн дэмжиж, 78,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“43.4.3.мэргэжлийн боловсролын сургууль, политехникийн коллежийн дотуур байрны нийт зардал, төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хувьсах зардал, хоолны зардал, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны тогтмол зардал;” Санал гаргасан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо. Санал хураалт. 81,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд ишлжүүлээ.

16.35 цаг.

“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүд болон Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдтэй холбогдуулан боловсруулсан эдгээр хуулиудын анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням танилцуулна.

Г.Дамдинням: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Боловсролын ерөнхий хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос боловсруулан анхны хэлэлцүүлгийг 2023 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаараа хийлээ.

Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулах үед ажлын хэсгээс боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд дэмжигдсэнтэй холбогдуулан Төрийн хяналтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг

явуулах үед төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гаргаагүй тул Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2-т заасныг баримтлан хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Боловсролын ерөнхийн хуулийн төслийн хүрээнд холбогдуулан боловсруулсан Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай, Боловсролын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хууль, тогтоолын төслүүдийг эцэслэн баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Байнгын хорооноос гаргасан горимын саналуудаар санал хураалт явуулна. Санал хураалт. Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр нь баталъя гэсэн горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын

томъёоллоор санал хураалт явуулна.
Санал хураалт.

68,8 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энх-Амгалан сайд гуай их маяглаад байвал маргааш эцэслэн батална гэдгийг та бас. Хурал үймүүлээд байх юм бол хойшлуулчихна шүү.

2.Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

3.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт. Өмнөх саналыг 68,8 хувийн саналаар дэмжсэн.

Саяын саналыг 68,8 хувийн саналаар дэмжлээ.

Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг эцэслэн батлах үе шаттай нэгтгэн явуулах горимын санал гаргасныг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. 76,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооноос гаргасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг эцэслэн батлах бэлтгэл хангуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлээ.

Манай Гомпилдоогийн Мөнхцэцэг Байнгын хороон дарга их сайн ажиллалаа. Баяр хүргэе. Тэгэхдээ маргааш эцэслэн батлахдаа сайн анхааръя.

16.41 цаг.

“Монгол Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг танилцуулна.

Х.Ганхуяг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улсын Их хурал нэн яаралтай горимоор өргөн мэдүүлсэн “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Байнгын хорооны 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Энхтүвшин төслийн 1.4 дэх дэд заалтын “20 сая тонн хүртэлх” гэснийг “20 сая тонноос доошгүй” гэж өөрчлөх, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг төслийн тэмдэглэх хэсэг болон 1 дэх заалтыг

өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй 4, найруулгын 1 саналын томъёолол гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёолуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Гочоогийн Ганболд гишүүнээр тасаллаа.

Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Би тогтоолын төслийг дэмжиж байгаа. Гэхдээ нэг зүйлийг нэг тодорхой асуучихмаар байгаа юм. Хөгжлийн банкны асуудлаар түр хорооны нотлох баримтын хяналтын сонсгол хийж байх үед Монгол Улсын Ерөнхийлөгч асан Халтмаагийн Баттулга тухайн үеийн Зам, тээврийн сайд байсан Гансүх тэргүүтэй тухайн үеийн Төрийн өмчийн

хорооны нөхдүүд орж ирж тайлбараа өгсөн байдаг юм. Хэвлэл мэдээллээр бүгдээрээ ил тод явсан. Тэр үед бол Хятадаас ирж байгаа цэг Монголоос ирж байгаа цэг зөрөөд байна. Ямар учиртай юм бэ гэхэд яахаараа бид нар Хятадын нэг төрийн өмчийн компанийн үгээр явах ёстой юм бэ. Тийм зүйл байхгүй. Тийм болохоор бид нар өөрсдийнхөө тэр цэгийг тогтоох ёстой Монгол Улс тусгаар юм бол гэсэн ийм л хариулт өгч байсан. Гэтэл сая ингээд Ерөнхий сайдын айлчлалаар Хятадын талтай уулзаад явахад бид тохирсон зүйл байгаа шүү дээ. Монголын тал өөрийнхөө асуудлыг шийднэ. Хятадын тал өөр өөрийнхөө асуудлыг шийд. Хөрөнгө оруулалтаа бид үүгээрээ шийднэ. Өөрийнхөө газар нутаг дээр Монголын тал шийднэ гээд. Тэгээд маш их зөрүүтэй ойлголт өгч байна лээ л дээ. Тэгээд 1 талаасаа эх оронч юм шиг ингээд ярьсан, тохирсноосоо шал өөр юмыг тухайн үеийн Засгийн газар нь хийдэг, Ерөнхийлөгч нь хийдэг. Тэгээд зөрүүлчихдэг. Тэгээд тэрнээсээ болоод төмөр замын холболт байхгүйгээсээ болоод бид нар 10 гаруй жил маш их хэмжээний Монгол Улсын эдийн засгийг 5 дахин илүү өсгөх тэр боломжийг алдсан нь бодитой шүү. Монгол Улсын иргэдийн цалин, багш нарын цалин, дээрээс нь настнуудын тэтгэвэр 5 дахин өсгөх боломжийг зөвхөн энэ төмөр замыг гацааснаас бий болсон нь бодитой шүү. Одоо үнэн юмыг үнэн ярих цаг нь болсон шүү. Энэ бол ингээд бодитой үнэн. Одоо яаж байна гэхээр энийг холбох асуудал яриад байгаа юм. Тэгэхэд Баттулга ерөнхийлөгч надаас асууж байсан юм. Доржханд гишүүн ээ, та өөрөө очиж газар дээр нь үзсэн юм уу. Яг үзсэн юм уу. Тухайн үед бол би үзээгүй байсан. Яг тэрний дараа 7 хоногийн дараагаар очиж үзсэн юм. 2км-ийн зай байна. Гэхдээ 2км-ийн зайг шууд холбож өгөх боломжгүй юм байна. Тэр дунд нь маш олон бүтээн байгуулалт, дэд бүтэц, хувийн секторт газарт өгөх газар олгочихсон гээд тэрийг ингээд тойруулаад яах юм бол тэр чинь 2км-ийн

зай биш байна. Дээрээс нь ганц хоёрхон жилийн дотор хийчихээр ийм гүүрэн холболт биш байна. Энэ энэ чинь бол цаг хугацааны асуудалтай юм байна. Хөрөнгө хүчний асуудалтай юм байна. Холбохоос өөр аргагүй юм байна гэдэг ийм байдлаар газар дээр нь маш олон мэргэжилтнүүд дүгнэлт хийгээд ирсэн байдаг юм.

Одоо асуулт нь юу байна гэхээр ингэж худлаа популизм хийгээд эх орноо хохироосон хүмүүс нь ардын баатар болдог, Ерөнхийлөгч болдог, цаашаага алга ташуулдаг ийм хөгийн популизмыг бид нар яаж зогсоох ёстой юм. Дүгнэх юм уу, дүгнэлт өгөх юм уу. Одоогийн Засгийн газар нь эр зоригтойгоор дүгнэх юм уу. Ямар хэмжээний мөнгө алдчихаад байгаа юм бэ. Яагаад энэ буруу юм бэ гэдгээ дүгнэх юм уу. Хариуцлага тооцох юм уу. Эсвэл ингээд сайхан тэврэлдээд л бие биеийгээ ингээд хаацайлаад яваад байх юм уу. Энэ дээр нэг хариулт авчихмаар байгаа юм.

Тэгээд 2 дахь нь болохлоор яг одоо бодитойгоор хэзээ яаж тэрийгээ холбох гээд байгаа юм бэ. Тэр дунд барьчхаад байгаа хувийн секторын газар, дэд бүтцийн асуудлыг та нар яах юм. Өнөөдөр авлига хороолол шиг хотын дарга гарч ирээд нураачихъя гээд л тэгээд нураах юм уу. Тэр олгочоод байгаа газрын зөвшөөрлүүдээ шууд буцаагаад авчихъя гэх юм уу. Ийм байдлаас чинь болоод ажил гацаад байгаа юм. Тэгэхээр энэ дээр яг ямар байдлаар та нар шийдэх гээд байгаа юм. Ямар хугацаанд шийдэх юм. Хятадын тал нь хөрөнгө оруулах юм уу. Монголын тал нь хөрөнгө оруулах юм уу, яаж явах юм. Ямар эх үүсвэрээр шийдэх юм. Ямар хугацаанд шийдэх юм. Энэ дээр тендер нь юу болж байгаа юм гэдэг дээр тодорхой хариулт авмаар байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Хууль зүй, дотоод хэргийн сайд Хишигээгийн Нямбаатар асуултад хариулна.

Х.Нямбаатар: Би Доржханд гишүүний асуултад мэдэж байгаа зүйлээ хариулъя. Бусдыг нь Байнгын хороо болон Зам, тээврийн сайд хариулах байх гэж бодож байна.

1 дүгээрт яах вэ, Ерөнхий сайдын захирамж гараад намайг энэ Ганцмод-Гашуунсухайтын хил дамнасан боомтын төмөр замыг айлын талтай хэлэлцээр хийж, холболт хийх түүнтэй холбоотой бүтээн байгуулалт, түүнтэй холбоотой санхүүжилтийн асуудал, түүнтэй холбоотой гэрээ, хэлэлцээрийн асуудлууд, цаашилаад 2022 онд байгуулагдсан “Эрдэнэс Тавантолгой” “Чайна энерги” хоорондын ерөнхий хэлэлцээрийг хэрэгжүүлэх асуудал, 2018 онд байгуулагдсан Засгийн газар хоорондын санамж бичиг зэргийг хэлэлцүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой ийм ажлын хэсгийн хэлэлцээрийг ахалж ажилла гэдэг үүрэг, даалгавар өгсөн. Үүний дагуу сая Монгол Улсын ерөнхий сайдын айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллалаа.

“Чайна Энержи” компанийн ТУЗ-ийн дарга болон бусад гүйцэтгэх удирдлагуудтай бид нар уулзалтууд хийсэн. Тусгайлсан уулзалтууд бас хийгдсэн. Энд байгаа төлөөлөгчийн газрынхантай хийсэн. Ингээд бид нар ийм дараах хэдэн зүйлээр тохиролцоонд хүрээд байгаа юм.

1 дүгээрт санамж, хэлэлцээрийн хүрээнд жилд 20 саяас доошгүй тооны ийм нүүрсийг айлын тал зах зээлийнх нь үнээр тогтвортой худалдаж авъя.

2 дугаарт хил дамнасан төмөр замын холболтын барилга угсралтын ажлыг “Чайна Энержи”-гийн талаар бид нар гүйцэтгүүлъя. Хилийн 0 цэгээс манай нөгөө мухар гээд байгаа төмөр зам хүртэлх холбох тэр төмөр замын барилга угсралтын ажлын зардлыг манай тал өөрийнхөө нутгийн доторх зардлыг өөрсдөө хариуцъя. Түүнийгээ оффтейкээр биш “Эрдэнэс

Тавантолгой” өөрийнхөө борлуулалтын орлогоор хийе. Энэ оны 10 дугаар сар гэхэд ТЭЗҮ, зураг төсөв дуусвал ирэх он гараад бид нар чадвал 1 дүгээр улиралдаа ер нь барилгын ажлыг эхлүүлэе. Барилгын ажлыг ойролцоогоор төсөөллийн хугацаа 1,6 жилийн хугацаанд барьж байгуулж дуусна гэсэн. Энд тавигдсан төмөр замынхаа суурилагчийн хүчин чадлын тэр “Чайна Энерджи”-ийн авсан нүүрснээс бусад давсан хүчин чадлынх нь нүүрс экспортлох тэр замын эрхийг манай тал бусад худалдан авагчдад боломж олгож ашиглана гэсэн ийм үндсэн агуулгуудаар бид нар ойлголцож тохиролцсон гэдгийг танд хэлье.

Тэгээд үүний хүрээнд өнөөдөр Улсын Их Хурлын тогтоолын төслийг оруулж ирж байгаа. Дараа 8 дугаар сард бид нар барилга угсралт замын суурь бүтэц барьж байгуулахтай холбоотой нарийвчилсан хэлэлцээр, нүүрс нийлүүлэхтэй холбоотой нарийвчилсан хэлэлцээр, бусад нарийвчилсан хэлэлцээрүүдийг 2 талаасаа ажлын хэсэг Улаанбаатарт ажиллана. Шаардлагатай тохиолдолд Бээжинд очиж ажиллаж, нарийвчилсан хэлэлцээрүүдээ энэ намартаа дуусгана гэсэн ерөнхий төлөвлөгөөтэй байгаа.

Таны асууж байгаа алдагдсан боломжийн тухайд энийг тодорхой хууль хяналтын байгууллагаар шалгуулах, учирсан хор хохирлыг барагдуулах энэ асуудал бол нээлттэй гэж би бодож явдаг. Бид нар 2008 оноос хойш өнөөдрийг хүртэлх хугацаанд төмөр зам төр хувийн хэвшлийн түншлэлээр барьж байгуулагдсан бол бид нар ойролцоогоор 80 орчим их наядын боломжоо бид нар алдсан гэдэг ийм зүйлийг эдийн засагчид, судлаачид ярьдаг. Энэ асуудал дээр би тантай адил байр суурьтай байдгаа удаа дараа хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр илэрхийлж байсан гэдгийг хэлье.

Яах вэ, өнөөдрийн баригдах хил дамнасан байгууламжийн тухайд өргөн нарийн цариг 2 талдаа зөрж 2, 2 царигтайгаар хилийн терминалууд руугаа очно гэсэн.../минут дуусав/

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд.

С.Бямбацогт: Доржханд гишүүний хөндөж байгаа асуудал зүй ёсны асуудал аа. Ер нь Монголд төрийн бодлого тодорхой биш, тогтвортой биш, Монголчууд өөр хоорондоо хөлөө жийлцдэг, улс төрждөг, бие биеэ үгүйсгэдэг явсны үр дагавар одоо гарч байгаа юм. 2004 онд Монгол Улсын Засгийн газар Хятадын Засгийн газарт хил дамнасан төмөр замууд барьж байгуулья гээд Гашиунсхайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүн хатавч гээд боомтуудыг тохирсон байдаг. 2007, 2008 оноос үндсэндээ Гашиунсхайтын төмөр замыг барьж байгуулах, Шивээхүрэнгийн төмөр замыг барьж байгуулах ажлууд яригдаж эхэлсэн байдаг. 2014 онд Гашиунсхайтын төмөр замын бүтээн байгуулалтын ажил эхэлсэн. Анх яригдаж байхдаа нарийн царигтай гэж эхэлж байсан. Явцын дунд бөөн асуудал болж байгаад өргөн царигтай болсон. Ингээд үндсэндээ 2022 онд бид нар төмөр замаа олон жил хэрэлдэж, маргалдаж байж хил дээр аваачсан. Хил дээр аваачсан чинь хилийн холболтын цэг зөрсөн, өндөржилт зөрсөн. Үүнээсээ болж хэдэн 100 сая доллароор Хятадын төмөр замтай холбох ажлыг хийж хэрэгжүүлэх гээд энийг богино хугацаанд хийж хэрэгжүүлэхийн тулд өнөөдөр ингээд бөөн асуудал болоод л явж байгаа юм. Гэтэл Хятадын тал 2014 онд төмөр замаа хил дээр аваад ирсэн. Монголчууд төмөр замаа 2022 онд аваачсан. Аваачихдаа анх ярьсан тохирсноосоо өөр болсон. Эргээд нөгөө хилийн холболтын цэг нь зөрсөн. Энийг барьж байгуулахад маш техникийн хувьд маш их өндөр нарийн ажил болно. Энэ холболтын цэг

барихад гүүр стакадан байгууламж барина. Монголчууд хэзээ ч барьж үзээгүй, чадахгүй. Энийг хийхэд өндөр технологи шаардана. Тийм болохоор бид нар энийг хамтарч хийх тал дээр онцгой анхаарч, мэргэжлийн улсуудтай ярих ёстой гэж ТЭЗҮ хийж байгаа. Энэ явцад мэдээж олон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулж байгаа газар ашиглаж байгаа талбай хамрагдаж магадгүй объектууд. Ингэсэн тохиолдолд тэр бол нөхөн олговор олгох ёстой. Хуулийн хүрээнд тэр төмөр замын эдэлбэр газарт ашиглалтын талбайд үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжийн тэр төмөр замын бүтээн байгуулалтын талбай руу орох юм бол хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд нөхөн олговор олгоно. Хохирох ёсгүй ээ аж ахуйн нэгжүүд, иргэд. Ингээд одоо юу гэдэг юм Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас, төрийн байгууллагын буруутай үйл ажиллагаанаас, төрийн бодлогогүй, тодорхойгүй, бодлого шийдвэр нь эргэж буцсан байдлаас болж иргэн, аж ахуйн нэгж хохирох ёсгүй. Ялангуяа хувийн хэвшлийнхэн хохирох ёсгүй. Тийм болохоор юу гэдэг юм Төрийн албан хаагч хүнд суртал гаргадаг, шантаажилдаг, төрийн байгууллага гаргасан шийдвэр эргэж буцдаг ийм байдал цаашид битгий давтагдаасай. Мэдээж хууль зөрчөөд хуйвалдаад асуудал шийдэгдсэн байдаг бол тэр хуулийн хүрээнд хууль зөрчсөн асуудал дээрээ, хуйвалдсан асуудал дээрээ авлига, шан харамж авсан байдаг бол авсан асуудал дээрээ тэр Эрүүгийн хуулийн хариуцлагыг хүлээх ёстой. Энэ дээр хариуцлага заавал хүлээж, хууль зөрчсөн хүмүүст сургамж болгож, хариуцлага хүлээлгэх ёстой. Хууль зөрчөөгүй бол хэзээ ч иргэн, аж ахуйн нэгж, хувийн хэвшлийнхэн хохирох ёсгүй.

Г.Занданшатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууна.

Б.Пүрэвдорж: Би өнгөрсөн онд уул уурхайн ордоос хилийн боомт хүртэл

тухайн орны царигаар төмөр зам барих тогтоолын төслийг өргөн барьсан. Энэ бол 2 хөршийгөө хүндэтгэсэн, бодлогыг нь дэмжсэн, түүнийхээ дагуу хамтын ажиллагааг өргөжүүлэх ийм бодлогын хүрээнд хийгдсэн юм. Харамсалтай нь энийг өнөөдрийг хүртэл хэлэлцэхгүй байна. Тэгэхээр Таван толгойн төмөр зам, Гашиунсухайтын төмөр зам яагаад будилсныг би та бүхэнд хэлж өгье. 2014 онд Улсын Их Хурлын тогтоолоор нарийн царигаар төмөр зам барих Улсын Их Хурлын тогтоолын төсөл батлагдсан. Гэтэл Засгийн газар тогтоол зөрчиж 2019 онд Тавантолгойн төмөр замыг эхлүүлсэн юм байгаа юм. Засгийн газар тогтоол зөрчсөн гэсэн үг. Хууль бусаар эхэлсэн. Тэгээд үүнийгээ гэнэтхэн мэдсэн тэр нөхдүүд яасан бэ гэхээр 2020 оны 5 сард Үндсэн хуулийн цэцэд Удаанжаргалаар өргөдөл өгүүлээд, энэ өргөнөөр төмөр зам тавих нь буруу байна гэдэг ийм шийдвэр гаргуулаад, тэрийгээ Их Хурлаар дэмжүүлсэн байдаг юм. Тэгээд энэ дээр юу үлдэж байна вэ гэхээр дахиад буцаагаад Их хурлаар тогтоол гаргуулаагүй. Өөрөөр хэлбэл өргөнөөрөө тэнд авааччихсан бол өргөнөөр нь барина гэдэг Их Хурлын тогтоолыг зайлигүй гаргаж байж явах ёстой байхгүй юу даа. Нарийн цариг ч байна уу, өргөн цариг ч байна уу. Одоо өргөнөөр авааччихсан юм чинь, нарийн царигаа болиулчихсан юм чинь өргөнөөрөө буцааж тогтоол гаргуулах ёстой байхгүй юу. Гэтэл тэрийгээ гаргуулаагүй. Ингээд бүх юм хууль бусаар явсан байхгүй юу. Тэгээд өнөөдөр ингээд Монголын хөгжилд маш их гацаа үүсгэж байгаа. Тэгээд энэ замыг 1,3 тэрбум доллароор барьсан. Тэгээд тэрний нэг ойролцоогоор нь 800, 900 орчим сая долларыг нь нүүрсний оффтейк гэрээгээр хийгдэж байгаа. Тэр нь эд үнэтэй байж байхад 60 доллароор хийгдэж байсан шүү дээ. Ачигдаж байсан шүү дээ. Өнөөдөр биржээр 160, 140 доллароор нүүрсээ борлуулж байхад тэр компани 80 доллароор аваад явж байна шүү дээ. Тэгээд тэр төмөр зам нь түпик болчихсон байгаа шүү дээ. Мухар төмөр

зам болчихсон байгаа. Тэгээд энийг 1,6 жилийн дараа холбох тухай ярьж байна шүү дээ. Гэтэл нөгөө компани мөнгөө аваад дуусах гэж байна хөөе. 80 доллароор. Яасан дүлий төр вэ. Би энийг 3 сарын өмнө хэлж байсан. Чуулган эхлэхэд. Энэ “Бодь”-ийн төлбөрийг нүүрсний төлбөрийг зогсоо. Тэр төмөр зам нь ашиглалтад орохоор төмөр замаараа хурдан зөөгөөд аваад яв. Тэр хүртэл тэртээ тэргүй энэ нөхдүүд маш бага зардлаар би гаргасныг нь мэдэж байгаа. Би яагаад гэвэл яг энэ Тавантолгойн төмөр замтай холбоотой түр хороо байгуулж байгаад надтай аягүй бол хүмүүс айгаад орж чадахгүй байх. Тэгэхдээ би чинь хуульдаа юм хийгээд авчихсан. Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, түр хороо байгуулаад сонсгол байгуулах тийм заалтууд байдаг. Би түүгээрээ шалгаад явчихна. Тийм учраас Засгийн газрынхан нэг зүйлийг анхаараарай. Төмөр зам нь холбогдсон үед нь тэр юугаа хийчих л дээ. Тэр “Бодь”-ийн төлбөрийг хий л дээ. Мухар төмөр зам барьчхаад тэгээд төлбөрөө авч, дуусаж болохгүй шүү дээ. Одоо 200 сая доллар дутуу байгаа. Өдөр болгон жил, сар болгон 100 мянган тонн нүүрс ачиж байгаа. Тэндээсээ ойролцоогоор 60.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуултад хэн хариулах вэ. Гочоогийн Ганболд гишүүн.

Г.Ганболд: Би сая яг энэ асуудлын өмнө нүүрсний хорооны танилцуулга дээр уг нь нэлээн дэлгэрэнгүй юмнууд хэлсэн юм. Хэн ч анзаарсангүй, тоосонгүй. Тэр дотор саяын Пүрэвдорж гишүүний хэлж байгаа тэр “Бодь”-той хийсэн гэрээ ямар өртгөөр хийсэн юм, ямар хөнгөлөлт эдэлсэн юм. Тухайн үедээ гэрээ хийснээс хойш өнөөдөр дахиад нэмэлтээр 400 сая долларын гэрээ хийчхээд явж байгаа. Бүгдийг нь ярьсан хэн ч тоогоогүй. Тэгээд тэр төмөр зам мухар байгаа. Одоо холбох тухай ярьж байна л даа. Бид нар өмнө нь энэ мухар төмөр замуудыг барихдаа төрийн нууцад авч байгаад хүмүүст шууд гэрээ хийх

боломжуудыг олгож байгаад хийчихсэн. Гэтэл өнөөдөр тэр гэрээ хийсэн хүмүүс нь зарим нь зугтаагаад, зарим нь шорон оронд орчхоод явж байгаа. Тэгэхээр нь өнөөдөр тийм байдлаар авах юм бол дараа нь асуудал үүсэх юм байна гээд Их Хурал дээр нээлттэй ярьж байгаад шууд гэрээ хийх одоо бид нар ямар шийдвэр гаргаж байгааг Их Хурлын гишүүд маань зарим нь ойлгож байгаа юу. Тэр холболтын төмөр замыг шууд “Чайна Энержи”-тэй хий гэсэн тогтоол гаргаж байна шүү дээ одоо.

4 дэх заалтаар нь “Чайна Энержи”-д жилд 20 саяас доошгүй тонн нүүрсийг зөвхөн тэр компанитай гэрээ хийж өг гэдэг шийдвэр гаргаж байна шүү дээ одоо бид нар. Тэгэхээр тэр нөгөө бид нарын Биржийн хууль чинь юу болох юм бэ. Биржийн хууль. Энэ компани дангаараа 20 сая тонноос дээш нүүрс аваад явах юм бол Тавантолгойн бүх нүүрсийг зөвхөн энэ компани л авна гэсэн үг. Өөр хэн ч орж ирэх боломжгүй. Тэгэхээр энэ дээр бид нар нөгөө үнээ яаж тогтоох юм тэр компани чинь бид нар 20-оос доошгүйг авна. Одоо энэ жил та нар 20-оос доошгүй гэсэн юм чинь 50-ыг авна гээд бүгдийг нь ганцхан манайх авна гээд үнээ буулгаад зөвхөн энэ үнээр авна гэх юм бол үнээ яаж тогтоох юм бэ. Тэгээд бусад нөгөө нүүрсний өрсөлдөгчдийг чинь оруулж ирэхгүй байдлаар ингээд явах юм бол энэ асуудлыг хариуцлагыг нь хэн хүлээх вэ. Эцсийн дүндээ Их Хурлаас ингээд шууд гэрээ хийх эрх олголоо. Тэгэхээр Тавантолгой компанийн одоогийн бүрэн эрхт төлөөлөгч гэрээ хийх байх. Хөгжмийн нэг өдөр бас л нөгөө шалгалт шүүлэг болоод ирэхэд энэ хүн хариуцлага хүлээхгүй баталгаа байна уу. Эсвэл сая Хөгжлийн банк шиг хамтын шийдвэр гаргасан Их Хурал хамтын шийдвэр гаргасан гээд хамжигч дэмжигч гээд бүгдээрээ эрүү үүсгээд ингээд явж байх асуудал гарах юм биш биз дээ. Энэ дээр ер нь жаахан болгоомжтой хандах. Би бол 20 хүртэл сая тонн гэдгээрээ явж байсан бол гэрээ хийх явцад янз бүрийн

алдаа дутагдал гарна. 20-оос доошгүй гэгчээр чинь энэ чинь доод хязгаарыг нь тавьчихаар чинь дээшээ хязгааргүй явахаар ганцхан компанийн юманд л орчих гээд байх шиг л байх юм. Тэгээд эхний орж ирсэн заалтаар нь ядаж 20 хүртэл явж байгаад, тухайн эхний жилүүдийнхээ үр дүнг тооцож байгаад, сөрөг зүйл гарах юм бол гэрээгээ өөрчлөөд, тогтоолоо өөрчлөөд явах ийм боломж гарах уу. Тэгээд энэ талаар би нэг хариулт авъя гэж ингэж бодож байна.

Г.Занданшатар: Хишгээгийн Нямбаатар сайд.

Х.Нямбаатар: Ганболд гишүүн ээ, би хариулъя. Одоо бол бид нарын энэ гэрээний хэрэгжих хугацаа бол хил холболтын төмөр зам ашиглалтад орсноос хойш тэр жилээс нь эхлээд жил бүр 20 саяас доошгүй тооны нүүрс тогтвортой үнээр зарна гэдэг л ийм агуулгаар орж ирж байгаа юм.

2 дугаарт энэ тогтоолын 6 дугаар заалтыг та харсан бол Тавантолгойн нүүрсний ордыг иж бүрэн ашиглах, олборлолт, тээвэрлэлт, экспортыг нэмэгдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх уул уурхайн болон уул уурхайн бус бараа, бүтээгдэхүүн, түүхий эдийг тээвэрлэх боломжийг бүрдүүлэх гэдэг ийм агуулгаар орсон. Өөрөөр хэлбэл одоогийн байгаа Баруун, Зүүн Цанхаас гадна бусад ам дээрээ оператор зарлаж, олборлолтоо нэмэгдүүлэх ийм агуулгаар давхар тусаж орж ирж байгаа юм 1 дүгээрт.

2 дугаарт Бямбацогт сайд бид 2 яг тэр компанийн удирдлагуудтай нарийвчилсан уулзалтууд цуг хийсэн. Ганбат дарга бид хэд. Нэг зүйл аягүй тодорхой яригдсан. Тэр нь юу вэ гэхээр одоогийн манай БНХАУ-тай худалдаа хийж байгаа нүүрсний квотод энэ квот орохгүй гэж байгаа юм. Энэ хэмжээ. Өөрөөр хэлбэл энэ нь манай эдийн засагт

эерэг нөлөөллүүдийг авчирна гэсэн санаа хэлэх гэсэн юм.

Дараагийнх нь нэг юм болохоор Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Хөгжил шинэтгэлийн хороотой өнгөрсөн оны 8 дугаар сард энэ санамж бичгийг байгуулсан байна. Энэ гэрээ дээр талууд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг барьж, Монголын талын өмнө чиглэлийн төмөр зам болон Хятадын талын Ганцмод, Бугат, Ваниу Чуань өмнөд чиглэлийн төмөр замтай холбох Монгол-Хятадын дэд бүтцийн холболтын түвшнийг дээшлүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гээд энэ бусад нөхцөлүүдээ энд дурдсан байгаа.

Дараагийн дугаарт саяын таны хэлж байгаа тэр ганц компани зарах гээд байгаа юм уу гэдэг бол одоогийн зарж байгаа компаниуддаа бүгдэд нь зарна. Түүнээс гадна эдний дээр хэмжээг нэмэгдүүлж заръя гэдгийг мөн өнгөрсөн оны 8 дугаар сард буюу энэ хууль батлагдахаас өмнө хийгдсэн зүйл байгаа юм. Энэ 2 орны хооронд байгуулагдсан олон улсын ийм худалдааны гэрээ байгуулагдсан. Бид нарын гол асуудал бол нэгэнт гэрээ хийгдсэн бол тэр худалдааныхаа гэрээний үүргийг л хэрэгжүүлж гэдэг агуулгаар оруулж ирж байгаа юм.

2 дугаарт ер нь цаашид энэ жижиглэнгийн худалдаа, бөөний худалдаа гэдэг 2 зүйл дээр ялгамжтай хандах хэрэгтэй. Энэ айл 20 жилийн туршид тогтвортой үүнээс ч их хэмжээгээр бид нар танайхтай худалдаа хийхэд бэлэн байна. Гол нь танайх тогтворгүй шүү. Өнгөрсөн 10 гаруй жил бид нар замаа бариад, санхүүгийн тодорхой хэмжээний эрсдэлд орсон. Гэхдээ энэ зүйлийг бид энэ удаа яримгүй байна. Та нар цаашид тогтвортой нүүрсээ заръя гэдэг агуулгаараа хандаарай гэсэн ийм би тайлбаруудыг хэлэх байна. Нэмж хэлэх дээр Түвшээ

хариулах уу. Тавантолгойг хэн төлөөлөх юм.

Г.Занданишатар: Хэн хариулах вэ. Хэн хариулах юм бэ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 6 санал байгаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Сүүлд нэмж ярьсан болохоор цаасаар аваад ир.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал:

1.Төслийн тэмдэглэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд “Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заасны гэж заасан Зорилт 1.2-т тусгагдсан үйл ажиллагааг яаралтай хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг. Санал хураалт 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Хилийн боомт дахь ачаа тээврийн урсгалыг сайжруулах, нүүрсний экспорт, эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын хооронд урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг. Санал хурааа.77,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1.3 дахь дэд заалтын “Ганцмод боомт” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн” гэснийг “зураг төслийн” гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг. Санал хураалт.

Өмчлөгчийг эзэмшигч болгох нь зөв юм уу. 76,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4.Төслийн 1.4 дэх дэд заалтын “20 сая тонн хүртэлх” гэснийг “20 сая тонн тонноос доошгүй” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин. Шууд хураачих юм уу. Зөв юм уу. Ингээж Их Хурал тоо хэрэг байгаа юм уу. Санал хураалт. Засгийн газрынх зөв гэж бодоод байна шүү дээ би бол. 67,4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1.4 дэх дэд заалтын “Ганцмод” гэсний өмнө “хил доторх” гэж нэмэн, “өртөө” гэснийг “боомт” гэж, “өмчлөгч” гэснийг “эзэмшигч” гэж гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг. Санал хураалт. 72,7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал.

Төслийн 1.1 дэх дэд заалтын “Бүгт Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс хоорондын 1955 оны “Хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэснийг “1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-т” гэж, 1.7 дахь дэд заалтын энэ заалтын 3, 4-т” гэснийг “Энэ тогтоолын 1 дэх заалтын 3, 4 дэх дэд заалтад” гэж, 2 дахь заалтын “хорооны хуралдаанд” гэснийг “хороонд” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Байнгын хороо. Санал хураалт. Найруулгын саналаар тэр хэлэлцээрүүдийг сайн нарийвчилж хараарай. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Санал хураалт явуулж дууслаа. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. “Монгол-Хятадын 1955 оны хилийн төмөр замын хэлэлцээр болон Гацуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор авах арга зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

17.15 цаг.

Ганхуяг гишүүний яриад байсан тогтоол яасан юм. Тийм тогтоол байгаа юм уу. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23-д хууль тогтоолын төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авах үндэслэлээ тусгасан албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хууль тогтоолын төслөө татан авсанд тооцно гэж заасны дагуу Засгийн газраас 2023 оны 7 дугаар сарын 6-ны өдөр хуулийн төсөл татан авах тухай 1-112 тоот албан бичиг ирүүлснийг уншиж танилцуулъя.

Хуулийн төсөл татан авах тухай.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн төслийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангийн 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2011 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2012 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2016 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2017-2022 оны бүх төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн нийгмийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гатварын өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын 2019 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн

даатгалын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /1991 оны 6 дугаар сарын 20-ны өдөр батлагдсан/, Өршөөл үзүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай /200.07.07-ны өдөр батлагдсан/, Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс 1 удаа чөлөөлөх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус татан авч байгаагаа үүгээр мэдэгдэж байна.

Засгийн газрын 2023 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг хавсаргав гэсэн байна. Ингээд эдгээр хуулиудыг татан авсанд тооцлоо.

17.18 цаг.

Гишүүд чуулганы танхимд цуглая.
Чуулган тараагүй байгаа шүү.

“Хуулийн хэрэгжилтийг хангах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна.

Байнгын хорооны санал, дүгнэлт нь хаана байгаа юм. Энэ чинь зүгээр тогтоол нь байна. Байнгын хороо ахиж хуралдах болох нь байна шүү дээ.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын 2022 оны “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн явцтай

танилцах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 162 дугаар захирамжаар байгуулсан бөгөөд тус ажлын хэсгийн танилцуулгыг Эдийн засгийн байнгын хороо 2023 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хуралдаанаар сонслоо.

Ажлын хэсгийн танилцуулгад Зөвшөөрлийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбоотойгоор хууль хэрэглээнд алдаа гарч байгаа талаар болон зөвшөөрлийн нэгдсэн сангийн мэдээлэл, түүний бүрдүүлэх, уг санд зөвшөөрлийг бүртгэх, лавлагаа, мэдээлэл өгөхтэй холбогдсон журам батлагдаагүй, Засгийн газар хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, сургалт зохион байгуулах зэрэг ажлыг нэгдсэн журмаар хийгээгүй зэрэг алдаа дутагдал байгааг дурдсан байна.

Тус ажлын хэсгийн танилцуулгыг сонссонтой холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, хангуулах чиглэлээр “Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсгийг үндэслэн Байнгын хорооноос боловсруулж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийг баримтлан тус тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны

хуралдаанаар хэлэлцээд, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг тогтоолын төслийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууна.

С.Бямбацогт: Зөвшөөрлийн хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байгаа юм. Гарцаа байхгүй бидэнд хууль хэрэгжүүлэхэд зөвлөл байгуулагдах, мөн бас төрийн байгууллага албан тушаалтнуудыг гарын үсгээ үнэлдэг, зөвшөөрөл өгдөг байдлыг цэгцлэх шаардлага байгаад байгаа. Тэгэхгүй бол өнөөдөр ингээд яам дээр очоод хүртэл харж байхад өнөөдөр ерөөсөө л гарын үсгээ л үнэлдэг. Тэгээд л гарын үсгээр гацаадаг, хяхан боогдуулдаг, тэгж байгаад авлига, шан харамж авдаг. Энийг л шийдэх гэж уг нь тэр 1400 зөвшөөрлийг 350 болтол бууруулсан. Хууль нь батлагдаад хэрэгжиж байгаа. Одоо яг хэрэгжүүлэх шатдаа дунд, доод шатдаа явахгүй байгаад байна. Тийм болохоор Улсын Их Хурлаас энэ тогтоолыг бас яаралтай батлаад, хэрэгжилтийг нь хангуулах тал дээр онцгой шахахгүй бол болохгүй байгаа юм. Тийм болохоор энэ тогтоолын төслийг дэмжиж байгаа. Зөвшөөрлийг ил тод болгоё, цахим

болгоё, ямар нэгэн хүнд сурталгүй, хээл хахууль авдаггүй, гарын үсгээ үнэлдэг төрийн албан тушаалтнуудыг гарын үсгээ үнэлэх байдлыг таслан зогсоох цаг нь болсон. Энийг хурдан хэлэлцүүлэх нь зөв гэж хүсээж байна.

Г.Занданишатар: Асуултад хариулах уу. Санал хэлсэн үү. Санал хэлчихлээ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

“Хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлээ.

Эдийн засгийн байнгын хороо тэгээд маргааш өглөө хуралдах нь байна шүү дээ. 9 цагаас хуралдахаар зохицуулъя.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

17.15 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ